

Óã ííiú í áe=áyðòyé òí éáí î òí é áçð ýððéã Þ Í ÆÑÊÍ ýáyéí ý. Ýí ý ííiú ã àðèèæàí ù áóñ çí ðèèã î ð òýâéýí í èèòýèñýí áí éí í. Þ Í ÆÑÊÍ -ã î ñ óðüã=èèáí áe=áýð àãñáí ç° áð °° ð° èãéãýð ííiú ã òóæèàð, î èð ðóóéàð, àæóéãü ã ðóæéí çí ðèèã î ð àð èæàð áýð çýðýã àèèããà òýéáyðýð òýðýæýðééã ðàðóóòí ðèæí í í.

Ýí ý ííiã áóðãñáí áàðèì ñýèðééã ñí í ã ñí í, æðææ òàãüñáí, èèýððèééñýí ñáí àà áí æèí í ð° è° ð° ðàðèóðèããü ã çí ðèí ã-èã ðçéýýí ý. Ýááýðòyé Þ Í ÆÑÊÍ çàããè ñáí àà í èèéýð àèããæé á° æ° à ýí ý í ù áàèæóéèããü í ççðýã áóñ áí éí í.

Àð èæãñáí í ýðñ, ìý áýýèèéã òí èèèóóèñáí áàéããè í ù àèèããà óèñ î ðí ù ýðð ççéí ñòàðóñ, íóðãã áýãñýð, òí ò, ýñáýè æçàð í óðãã òýááýðèéí ýðð áàðèã-èã, ýñáýè óèñ òèè, òèè òýçæãðòáé òí éáí î òí é Þ Í ÆÑÊÍ -æéí òæèí í àèèããà ñáí àà áí ã èòí é í èèóýðæé.

Õààòãñí ù çóðæéã
Þ Í ÆÑÊÍ
Í Á-úí Õ° ææèéí Õ° ð° éá° ð
Éàðèí ñ Æðí àèüáí

Ãçðü í çóðæéí çí ðèí ã-èéí ýðð: Wikipedia On-line:

Í ð-óóèñáí : Ä.ì° í ðáçðýí
 Ã.Í àðáí æðãã
Í ýãèèáí ð ççñý : Õ.Í àðáí æðæè
Õýí àñáí : Õ.Õýáéýý

Õýáéýñýí : “Õààí îð èí òèí ã” ÕÕË

Óèãáí áããàðð òí ò, ìí í ã è Óèñ
□ Þ Í ÆÑÊÍ , 2007

1. Товч танилцуулга

2. Хэвлэл мэдээллийн салбарын байдал

2.1. Суурь мэдээлэл

2.1.1 *Ерөнхий мэдээлэл*

2.1.2 *Хэвлэл мэдээлэл*

2.2 Телевиз

2.2.1 *Тойм*

2.2.2 *Төрийн мэдлийн өргөн нэвтрүүлэг олон нийтийн болох явцад*

2.2.3 *Агуулга*

2.2.4 *Үзэгчид*

2.2.5 *Өмчлөл*

2.2.6 *Орлогын загвар*

2.3 Радио

2.3.1 *Тойм*

2.3.2 *Агуулга*

2.3.3 *Сонсогчид*

2.3.4 *Өмчлөл*

2.3.5 *Орлогын загвар*

2.4 Сонин хэвлэл

2.4.1 *Тойм*

2.4.2 *Агуулга*

2.4.3 *Захиалга, Уншигч*

2.4.4 *Сонин хэвлэлийн өмчлөл, хэвлэл мэдээллийн төвлөрөл*

2.4.5 *Хэвлэл мэдээллийн өмчлөлийн төвлөрөл*

2.4.6 *Түгээлт, Хэвлэлт*

2.4.7. *Орлогын загвар*

2.5 Мэдээлэл Харилцаа Холбооны Технологи /МХХТ/

2.5.1 *Өнөөгийн бодит байдал*

2.5.2 *Уламжлалт хэвлэл мэдээлэл ба МХХТ*

3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө дарамтанд байна

3.1 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нухчин дарах нь

3.2 Үндэсний цөөнх

3.3 Сэтгүүл зүйн боловсрол

3.4 Сэтгүүл зүйн ёс зүй

4. Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл-Тулгамдсан асуудал, боломж
4.1 Орлогын загвар буюу санхүүгийн хараат бус байдал боломжтой юу?

5. ТББ иргэний нийгмийн байгууллагууд
5.1. ТББ, иргэний нийгмийн үүрэг

- 5.1.1 *Монголын Хэвлэлийн Хүрээлэн /МХХ/*
- 5.1.2 *"Чөлөөт Хэвлэл" Сан Хэвлэх Үйлдвэр*
- 5.1.3 *"Глоб Интернэшнл" ТББ*
- 5.1.4 *"Нээлттэй Нийгэм Форум" ТББ*
- 5.1.5 *"Монголын Сонин ба Мэдээллийн Холбоо" ТББ*
- 5.1.6 *ЮНЕСКО*
- 5.1.7 *Бусад*

6. Аймгуудын ерөнхий судалгаа

6.1. Дорнод аймаг

- 6.1.1. *Үндэсний ХМХ*
- 6.1.2. *Орон нутгийн ХМХ*
- 6.1.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*

6.2. Сүхбаатар аймаг

- 6.2.1. *Үндэсний ХМХ*
- 6.2.2. *Орон нутгийн ХМХ*
- 6.2.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*

6.3. Хэнтий аймаг

- 6.3.1. *Үндэсний ХМХ*
- 6.3.2. *Орон нутгийн ХМХ*
- 6.3.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*

6.4. Говь сүмбэр аймаг

- 6.4.1. *Үндэсний ХМХ*
- 6.4.2. *Орон нутгийн ХМХ*
- 6.4.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*

6.5. Дорноговь аймаг

- 6.5.1. *Үндэсний ХМХ*
- 6.5.2. *Орон нутгийн ХМХ*
- 6.5.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*

6.6. Өмнөговь аймаг

- 6.6.1. *Үндэсний ХМХ*
- 6.6.2. *Орон нутгийн ХМХ*
- 6.6.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*

- 6.7. Дундговь аймаг
 - 6.7.1. *Үндэсний ХМХ*
 - 6.7.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.7.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.8. Төв аймаг
 - 6.8.1. *Үндэсний ХМХ*
 - 6.8.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.8.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.9. Сэлэнгэ аймаг
 - 6.9.1. *Үндэсний ХМХ*
 - 6.9.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.9.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.10. Дархан-Уул аймаг
 - 6.10.1. *Үндэсний ХМХ*
 - 6.10.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.10.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.11. Говь-Алтай аймаг
 - 6.11.1. *Үндэсний ХМХ*
 - 6.11.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.11.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.12. Ховд аймаг
 - 6.12.1. *Үндэсний ХМХ*
 - 6.12.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.12.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.13. Архангай аймаг
 - 6.13.1. *Үндэсний ХМХ*
 - 6.13.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.13.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.14. Завхан аймаг
 - 6.14.1. *Үндэсний ХМХ*
 - 6.14.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.14.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.15. Увс аймаг
 - 6.15.1. *Үндэсний ХМХ*
 - 6.15.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.15.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.16. Баян-Өлгий аймаг
 - 6.16.1. *Үндэсний ХМХ*
 - 6.16.2. *Орон нутгийн ХМХ*

- 6.16.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.17. Өвөрхангай аймаг
 - 6.17.1. *Үндэсний ХМХ*
 - 6.17.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.17.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.18. Баянхонгор аймаг
 - 6.18.1. *Үндэсний ХМХ*
 - 6.18.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.18.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.19. Хөвсгөл аймаг
 - 6.19.1. *Үндэсний ХМХ*
 - 6.19.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.19.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.20. Орхон аймаг
 - 6.20.1. *Үндэсний ХМХ*
 - 6.20.2. *Орон нутгийн ХМХ*
 - 6.20.3. *Ерөнхий дүгнэлт/Тайлбар*
- 6.21. Булган аймаг
 - 6.21.1. *Үндэсний ХМХ*
 - 6.21.2. *Орон нутгийн ХМХ*
- 7. Уулзсан хүмүүсийн нэрсийн жагсаалт
- 8. Товчилсон үгсийн жагсаалт

1. Товч танилцуулга

Хэвлэлийн эрх чөлөөг хангах замд урам зориг өгөхүйц ахиц дэвшил Монголд гарч байгаа ч, асар их саад бэрхшээлтэй тулгарсаар байна. 1990 оны улс төрийн шилжилтийг даган сонин хэвлэл өргөн дэлгэрсэн бол 1990-ээд оны сүүлээс электрон мэдээллийн хэрэгслээр илэвчлэл үүсч эхэлжээ. Хэвлэл мэдээллийн ажиллагаа бүтээгдэхүүн тоо ширхэг, төрөл хэлбэрийн хувьд нийслэлд ч, хөдөө орон нутагт ч өсөж байгаа билээ. 2005 оны байдлаар 2,5 сая хүн амд хэвлэл мэдээллийн 340 хэрэгсэл үйлчилж байв.

Гэсэн хэдий ч, энэ салбар маш их сорилттой тулгарч байна. Коммунист дэглэмийн үеэс хойш үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний байдал мэдэгдэхүйц сайжирсан ч, бие эрхтэн, эрүүл мэндэд халдах, заналхийлэх, нэр төр гутаасан хэрэгт буруутгах, санхүүгийн дарамт шахалт үзүүлэх, хууль бус хязгаарлалт тогтоох зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил Монголд өнөө үед гарсаар байна. Ийм зөрчил үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн байгууллагад ч, орон нутгийнханд ч тохиолдож байна. Эдгээр зөрчил нь өөрөө тулгамдсан асуудлыг төдийгүй, хэвлэл мэдээллийн улс төр, санхүүгийн байдалаа хамаатай бүр ч ноцтой асуудлыг юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд “Бизнес мэдээ” гэгч “төлбөрт нийтлэл”, “төлбөрт нэвтрүүлэг”-ээр дүүрчээ. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид нэгэн адил “Бизнес мэдээ” гэгчийг ерөнхийд нь хүлээн зөвшөөрч, үүнийг санхүүгийн бэрхшээлтэй салбараа өөд татах боломж гэж үзэж байна.

Ийм практикийн хариуд ХМХ, сэтгүүлчид улс төрч, бизнесийн санхүүгийн дэмжлэгээс туйлын их хараат ажилладаг. Үндэсний хэмжээний ихэнх ХМХ ажиллагаа бүтээгдэхүүн хэвлэл мэдээллийн бизнес ажиллагаа үндэсний улс төр, бизнесийн ашиг сонирхолыг эн тэргүүнд тавьж тэдгээрийг хамгаалах суртал ухуулгын дуу хоолой болжээ.

Хөдөө орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд улс төр, санхүүгийн хараат байдал өсөж байна. Орон нутагт засаг даргын тамгын газар (ЗДТГ), улс төрч, бизнес эрхлэгчид тухайн ХМХ-ээр оршин тогтнох боломж олгодог билээ. 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар Төр ХМХ-ийг хоригдсон ч, ЗДТГ-ын санхүүгийн дэмжлэг байнгын амь зуулга болдог билээ.

ЗХУ-ын хяналт үйлчилгээ болж, эмх замбараагүй байдал үргэлжилсэн он жилүүдийн эцэст орон нутгийн засаг захиргаа, бизнесийн ажиллагаа бүтээгдэхүүн ХМХ ажиллуулж, хяналтаа тогтоонон улс төр, бизнесийн шинэ загвар бий болжээ. Нөлөөлөх арга барил нь өөрчлөгдсөн ч, ХМХ хяналтанд нь байгаа этгээдийнхээ суртал ухуулгын хэрэгсэл байдаг үзэл баримтлал хуучнаараа үлдэв.

Хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд ХМХ ашигтай бизнесийн хэрэгжүүлж болохуйц санхүүгийн загвар дутмаг ажиллагаа нь хамгийн тулгамдсан бэрхшээл байна. Хэвлэл мэдээллийн шинэ хэрэгсэл, Монголын

эдийн засагтай хамт зар сурталчилгааны зах зээл ч өргөжиж байна. Гэхдээ зар сурталчилгаа нь голдуу хувийн хэлхээ холбоогоор дамжин “төлбөрт мэдээ”, эсвэл зар сурталчилгаа хэлбэрээр орж ирдэг байна. Сонин хэвлэлийн тоо олон ч, ашигтай бизнес эрхлэх хэмжээний тираж (хувь ширхэгтэй) нь цөөн ажээ.

Аймгуудад¹ байдал эсрэг. Зар сурталчилгааны зах зээл орон нутгийн ХМХ-д дэмжих хэмжээнд хөгжих шинж төлөв алга. Сонин хэвлэлийн захиалгын тоо багасч, орон нутгийн телевизийн нэмэлт орлого олох боломж хомс зэргүүн зүйл засаг захиргааны татаас, эсвэл улс төр, бизнесийн сонирхлоос хүчтэй хамаарч буй өнөөгийн нөхцөлөөс зайлсхийх арга хөдөөгийн ХМХ-д хомс байна.

ХМХ-ийн өмчлөлийн ил тод байдал хангалтгүй, өөрөөр эзнийг мэдэх аргагүй, ард ил гол төлөв улс төр, бизнесийн ашиг сонирхол үйлчилж байдаг байна.

Сансрын холбоогоор телевизийн нэвтрүүлэг хүлээн авах боломж нэмэгдэж буй ч, малчдын хувьд орон нутгийн мэдээлэл хүлээж авах ил хүндрэлтэй хэвээр байна. Сонин хэвлэл олж авах боломж багасч, мэдээлэл хүлээж авч чадахгүй байгаа тул үндэсний радио л тэдний мэдээлэл хүртэх цорын ганц электрон хэрэгсэл болжээ. Ялангуяа дулааны улиралд малчид нутаг сэлгэн нүүхдээ хиймэл дагуулын антенаа өвөлжөөндөө орхидог байна.

Өнөөгийн байдлаар, ХМХ-ийн төвлөрөл бага байна. Хувийн хэд хэдэн хэвлэл мэдээллийн бүлэг нэгдэн нийлсэн ч, давамгайлах байр суурьтай ХМХ ганц ч алга. ХМХ-ийн бүтэц хөгжихийн хэрээр байр суурь нь бэхжих байх. Үүний зэрэгцээ орон нутгийн ХМХ, мэдээллийн бүтээгдэхүүнд аймгийн дарга нар давамгайлах үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.

Олон Нийтийн Радио Телевизийн шинэ хуулийн дагуу Монголын төрийн өмчийн радио, телевиз 2006 онд олон нийтийн радио телевиз болон өөрчлөгдсөн билээ. Дөнгөж шинээр байгуулагдсан олон нийтийн өргөн нэвтрүүлэг шилжилтийн туйлын ээдрээтэй, бэрхшээлтэй үйл явцыг туулж байна. Гэсэн хэдий ч, дотооддоо институцийн өөрчлөлт хийхийн зэрэгцээ, өрсөлдөөний шинэ орчинд дасан зохицохыг оролдож байна. Шилжилтийн явцад зөвхөн нэвтрүүлгийн бодлогод жижиг сажиг өөрчлөлт гарчээ.

Мэдээллийн эрх чөлөөний асуудал ихээхэн сэтгэл түгшээж байна. Монгол Улсын Үндсэн хуулиар мэдээлэл хайх, хүлээж авах эрх чөлөө баталгаажсан ч, өнөөгийн үйлчилж буй хууль тогтоомж олон талаар мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байна. Төрийн нууцын хууль тогтоомж засгийн газрын мэдээ баримтыг өргөн хүрээгээр нууцлалын хүрээ, ангилалд оруулсан байдаг. Засгийн газрын бүх шатны албан тушаалтнууд

1 Монгол улсын засаг захиргааны том нэгж

олон нийтээс мэдээллийг нуун дарагдуулахын тулд энэхүү хязгаарлалтыг олонтаа ашигладаг.

Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэхдээ тэдний ажиллаж буй хэвлэл мэдээллийн дээр дурдсан орчинтой нийцүүлэх $\dot{\text{U}}\text{c}\dot{\text{z}}\dot{\text{e}}\dot{\text{o}}\dot{\text{y}}\dot{\text{e}}$. Нэтгүүл зүйн \emptyset инээр байгуулагдсан олон сургууль, хандивлагчдын санхүүжилтүүд $\text{b}\ddot{\text{e}}\text{e}\dot{\text{n}}\dot{\text{y}}\dot{\text{u}}$ өргөн хүрээний дунд шатны сургалт, хөтөлбөрийн хүчинд олон сэтгүүлчийн ур чадвар дээшилжээ. Хараат бус, баримтад тулгуурласан сэтгүүл зүйг хөхиүлэн дэмжихийн тулд урт хугацааны зорилттой ажиллаж буй Монголын Хэвлэлийн Хүрээлэн /МХХ/ нь үндэсний хэмжээнд, мөн орон нутагт сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байна.

Гэсэн хэдий ч, Монголын сэтгүүл зүйн түвшин төдийлөн сайжирсангүй. Хэвлэл мэдээллийн салбарт тулгарч байгаа бүхий л бэрхшээлийг улс төржсөн орчноос үүдэлтэй гэж буруушаадаг хэрнээ, олон сэтгүүлч төлбөрт нийтлэлээс шан харамж хүртдэг аюултай тойрогт хөл тавихад бэлэн ажээ.

Техникийн хүчин чадлын хувьд Монголын хэвлэл мэдээллээ $\dot{\text{e}}\dot{\text{e}}\dot{\text{i}}\dot{\text{a}}\dot{\text{a}}\dot{\text{e}}\dot{\text{e}}$ тухайн ХМХ-ээс хамааран янз бүр байна. Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг ТВ9, С1, Ийгл ТВ гэх мэт хувийн гол гол телевиз орчин үеийн тоон технологийн тоног төхөөрөмжтэй, харин төрийн өмчийн, хуучин төрийн мэдэлд байсан хөдөө орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хуучин компьютер, аналог камер, эвлүүлгийн төхөөрөмж зэрэг ядмагхан техник хэрэгсэлтэй байна. Үүнээс гадна Улаанбаатар хотоос өөр газар сонин хэвлэл боломжгүй.

Үүний зэрэгцээ техник тоног төхөөрөмжийн үнэ буурсан, ХМХ байгуулах зардал харьцангуй бага зэрэг нь ХМХ олноор нэмэгдэх боломж олгожээ. Хэвлэлийн эх бэлтгэх зохих мэдлэгтэй, компьютертэй, бага хэмжээний хөрөнгө оруулах чадвартай хэн боловч орон нутгийн сонин, FM радио байгуулах боломжтой. Дамжуулагч, хэдэн компьютер нэмж аваад телевиз байгуулсан ч болно.

Монголын хэвлэл мэдээллийн салбарт анхлан хөрөнгө оруулснаас хойш техникийн шинэчлэлд тун бага хэмжээний хөрөнгө заржээ. Санхүүгийн боломжоос үүдэн ХМХ өөрсдийн хөрөнгөөр шинэчлэл хийх чадваргүй. Техник, тоног төхөөрөмж байгаа ч хуучирсан байна. Гэвч ХМХ-ийг хоцрогдонгүй байдал нь зөвхөн техникийн асуудал бус, харин тогтвортой орлого олох загваргүйтэй холбоотой юм.

Дуу, дүрс бичлэгийг хулгайгаар ашиглаж буй нь энэ салбарт тулгарч байгаа бас нэг бэрхшээл юм. Гадаад, дотоодын кино, телевизийн шоу, хөгжим зэргийн хулгай түгээмэл дэлгэрсэн байна. Оюуны өмчийн хууль тогтоомж хэрэгждэггүй тул Монголын телевиз, радио хулгайн хальсүг чөлөөтэй нэвтрүүлдэг. Харин сонинууд гуравдагч нийтлэлийг хэвлэх нь харьцангуй бага. Оюуны өмчийг хамгаалсан хууль хүчтэй хэрэгжиж эхэлбэл Монголын олон тооны телевиз, радио хаалгаа барих байх. 3л шийтгэл

хүлээх айдасгүйгээр булгайн баяныг ашиглах нь үх бичлэг үйлдвэрлэх, тэдгээрт төлбөр төлөх нь хямд ч гэсэн, нөгөө талаар хяналт тавихгүй бол дүрс, дуу бичлэгийн зах зээлийн хөгжлийг хойш чангаасаар байх нь мэдээж.

Монголын хэвлэл мэдээлэл, мэдээлэл харилцааны олон санаачлыг хандивлагч байгууллагууд дэмждэг ч дэд бүтэц муу, хөдөөд хэвлэл мэдээлэл, мэдээлэл харилцааг бүтээгдэхүүний зохистой орчин бий болгох зэргийг хамруулан, тухайн салбарт тулгарч буй томоохон сорилтуудыг системтэйгээр шийдвэрлэх хэвлэл мэдээлэл, мэдээлэл харилцааны бодлого Монголын Үндэсний газарт байна.

Хэвлэл мэдээллийн салбарт хийсэн энэхүү задлан шинжилгээгээр Монголд чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд тулгарч буй нэн чухал багц асуудлыг тодорхойлов. Бүхэлд нь дүгнэхэд, олон нийтийг зохих ёсны хараат бус мэдээллээр хангах, ардчиллыг гүнзгийрүүлэх явцад “хоточ нохой” байх хамгийн гол үүргээ биелүүлэхэд нь хэвлэл мэдээллийн салбар өнөө хэр бэрхшээл тулгарсаар.

Иймээс чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн дэвшилтэд бүлгүүдийн тогтвортой байдлыг дэмжих нь туйлын чухал. Түүнчлэн монголын хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд ажиллаж буй онцгой утгаар нь ХМХ-ийн хөгжлийг дэмжихэд өөр өөр хандлага шаардлагатай. Тэдний өмнө тулгарч буй бэрхшээл өөр хоорондоо ялгаатай ч, үндэсний хэмжээнд (Улаанбаатар), хөдөө, орон нутагт хэвлэл мэдээллийн салбарт нэг адил ээдрээтэй байгаа.

2. Хэвлэл мэдээллийн салбарын байдал

2.1. Суурь мэдээлэл

2.1.1. Ерөнхий мэдээлэл

Монгол улс далайд гарцгүй, ойролцоогоор 1,56 сая ам дөрвөлжин км нутагтай, тархай бутархай, нүүдэлчин амьдралтай нийт 2,6 сая хүн амтай. Монгол улс хойд хэсгээрээ ОХУ, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэдэг.

Хөдөө орон нутагт голдуу оршин суудаг, 20 орчим үндэстэн ястантай. Хүн амын дийлэнх нь халх (85 хувь), дараа нь гол төлөв Баян-Өлгий аймагт суудаг казахууд (7 хувь) орно. Үлдэх 8 хувь нь цаатан, дархад, буриад зэрэг жижиг бүлүгд хуваагдана. Хэлний хувьд үндэсний цөөнх нь казах, тува хэлтэй цаатангууд. Бусад ястан í ù Монгол хэлний өөр өөр аялгàòàé. Үндэсний цөөнх (хэлний хувьд ч) гол ò°ё° à Монголын баруун, хойд хэсэгт оршин суудаг.

1990 онд коммунист дэглэмээс салсанаас хойш Монгол улсàà улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын томоохон өөрчлөлт¿¿à гарсан. Улс төрийн хувьд ардчиллын шилжилтийн явцад олон нам оролцсон, харьцангуй чөлөөт сонгуулиуд болж, 1996 оны сонгуулиас эхлэн засгийн эрх мэдэл улс төрийн хэд хэдэн намд шилжиж, 2004 оны сонгуулийн дараа МАХН, Ардчилсан намын эвсэл засгийн эрхэнд гарчээ.

Эрх мэдлийн энэ өөрчлөлт нь эмзэгхэн ардчилёû í эрүүл саруулын шинж хэдий ч, ардчилёû í үйл явцын хөгжилд олон бэрхшээл тулгарч байна. Энд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хоорондын ялгаа тодорхойгүй, мөн улс төр, бизнесийн ашиг сонирхлыг хольж хутгасан хэвээр байãà àæý.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг 2005 оны Авилгын тухай тайландаа дараахь дүгнэлтийг өгсөн байна.

“Монгол улсад “жижиг” буюу задиргааны, “их хэмжээний” буюу äýüä (элит) түвшинд авилга ёòýñ÷ ààéãàà òòòæé °íí ° í ù òèéñýí тоон болон чанарын бусад судалгааòàé òàéèàí æéí ã è ä¿ã ýèò àààòòàæ ààéí à. Авилгын энэ хоёр ò°ò° è аль аль нь Монголчуудын сýòãýè зовооñí í àñòóàäè òýàèé ÷, äýüä ò¿ã í èé ààèèãà í ù эдийн засаг, улс төрийн эрх мэдэлтнүүдийн хоорондох холбоог нягтруулж, òòó÷èí èíìóí èñò áóñãà í òí ù ààèè ардчилал, хөгжил цэцэглэлтэд ñ°ò° à нөлөө үзүүлæ ñààà ó÷òóòèããàòàà òàìà èéí í í òòí é í ù àèèýý.

Авилгúã°° ã ¿¿èæáóé хүчин зүйлийг тайланд онцлон дурдахдаа: “Төр засгийн ихэнх үйл ажиллагаа ил тод бус, энэ талаар мэдээлэл авах боломжгүй байгаа нь хариуцлагыг бүхий л талаар сулруулж, энэ нь улмаар хэвлэл мэдээллийн үр ашиггүй байдалд нэрмээс болж, бодлого хэлэлцэх, төр засагт хяналт тавих үйл явцад иргэд оролцох боломжийг хязгаарлаж байна.” Монголын иргэний нийгэм сул, Засгийн газар жагсаал цуглаан, иргэний нийгмийн үйл ажиллагааг улам их хавчин боох болжээ.

Монголын ДНБ-ний бодит өсөлт 2003 онд 5 хувь байсан бол 2006 онд 7,5 хувь болж өсчээ. Олон улсын зах зээл дээр алт, зэсийн үнэ тогтвортой өссөнөөс ашиг хүртсэн уул уурхайн салбар онцгой тэлæ° òã æñ°í í ù үнэ их өсөлтөд нөлөөлжээ. Цаг агаарын таатай нөхцөл нь Монголын мал аж ахуйн салбар, малын тоо толгой, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өсөлтөд мөн хувь нэмэр оруулсан. Тээвэр, барилга зэрэг үйлчилгээний салбар ч гэсэн эрчимтэй өргөжиж байна. Тус улсын худалдааны алдагдал 2003 онд ДНБ-

ний 15,7 хувьтай тэнцэж байсан бол 2006 онд 1,4 хувийн ашигтай гарчээ. Үүний зэрэгцээ гадаадад ажиллаж байгаа Монгол иргэд байнга мөнгө гуйвуулааг зэрэг нааштай ахиц дэвшлийн дүнд 2004 оны сүүлд гэхэд, тайлан тэнцэл бараг алдагдалгүй болжээ. Эдийн засгийн өсөлтийн дүнд Монголын нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 1999 онд 384 доллар байсан бол 2006 онд 950 доллар болж нэмэгджээ.

Монголын хүн амын гуравны хоёр нь оршин суудаг нийслэлд шинээр үүссэн хангалуун дээд, дунд давхаргын санхүүгийн хэргийг хариуцаж, ажиллагаагаа сайжруулж байна. Гэсэн хэдий ч, байгалийн нөөц, худалдаа, үйлдвэр, хувийн хандивлагчдын үйлдвэрлэл, хувийн хандивлагчдын үйлдвэрлэл тэгш бус байгаа нь нийгмийн асар том ялгаа үүсгэж байна.

^a Өрчлөгдөн шинэчлэгдэж буй нийслэл, уламжлалт нүүдлийн аж ахуй эрхэлдэг малчидтай, бүүдгэр аймаг, сумын төв бүхий зогсонги хөдөө орон нутгийн хооронд санхүү, нийгэм, соёлын ялгаа улам нэмэгдсээр байна. НҮБ-ын “Хөгжлийн Хөтөлбөрт” тусгаснаар ядуурлын түвшин улсын хэмжээнд харилцан адилгүй. Тухайлбал, Улаанбаатарт хамгийн бага буюу 27 хувь, хангайн бүс нутагт 39 хувь, баруун бүс 51 хувьтай байна. Ихэнх аймаг мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай. Олон тоо толгой малаа алдсан 2000, 2001 оны зуд үед хамгийн байдал нь аажим аажмаар сайжирч байгаа ажээ. Хөдөөд дэд бүтэц /зам/, нийгмийн салбар /боловсрол, эрүүл мэндийн / хөгжөөгүй, олон сумын төв өдөрт хэдхэн цаг цахилгаанаар хангадаг дизель станцтай хэвээр байна.

Хэлний ялгаа, алслагдсан нутагт төрийн төлөөлөл хязгаарлагдмал зэргээс үүдэн хөдөөд оршин суугаа үндэстний цөөнхүүд нэн ядуу байна. Жишээ нь: Их Британий “Хүүхдийг ивээх” сангийн тайланд³ дурдсанаар Баян-Өлгий аймагт сургууль завсардсан хүүхдийн тоо Монголын бусад нутагт оршин суугаа үеийнхэнтэй нь харьцуулахад гурав дахин их байна. (6,2-1,9 хувь). Сургуулиас завсардсан тува хэлтэн, цаатан хүүхдийн тоо хамгийн их буюу 37,7 хувьтай байна. Эх хүүхдийн эндэгдлийн түвшин зэрэг эрүүл мэндийн үзүүлэлт алслагдсан нутаг, үндэстний цөөнхөд хоёр дахин их ажээ.

Одоогийн байдлаар Засгийн газраас үндэстний цөөнхөд чиглэсэн ямар нэг тусгай хөтөлбөр хэрэгжүүлээгүй, түүнчлэн санхүү, хүний нөөцийн хомсдлын улмаас үндэстний цөөнхийн тухай албан ёсны нэгдсэн статистик тоо баримт ч байхгүй байна.

2.1.2. Хэвлэл мэдээлэл

Коммунизмын үед хөдөө орон нутагт үндэстний сонин хэвлэлгүй өргөн түгээдэг, түүнчлэн телевиз, радиотой өрхүүд радио, телевизийн өргөн нэвтрүүлэг хүлээн авах боломж сайжраагүй байжээ. Түүгээр ч барахгүй, бүх аймаг төрийн мэдлийн орон нутгийн сонинтой, тэдгээрийг бүх сум, багт

2 Газар нутгийн томоохон нэгж

3 Их Британийн “Хүүхдийг Ивээх сан”. Казах үндэстний боловсрол болон сургалтын талаар хийсэн Нөхцөл байдлын задлан шинжилгээ /2005/

хүргэж байв. Аймгийн төвүүд өөрийн радио, телевизтэй төдийгүй, зарим нь *Монголын радиогийн* нэвтрүүлгийг тасалж, долоо хоногт 4 цаг 30 минутыг орон нутгийн хөтөлбөрт зориулдаг байв. /Симеринг 99/. Үсэсэг захиргааны бүх түвшинд дээрээсээ доошоо түгээж байсан, сайн зохион байгуулалт á¿ðèè мэдээллèèí òрсгал коммунизм нурсны дараа алга болжээ. Үндэсний хэмжээний сонин хэвлэлийг урьдын адил орон даяар түгээхээ больж, орон нутгийн хэвлэл мэдээллийн олон хэрэгсэл хаагдсан тул, одоо Монголын Үндэсний Радио Телевиз чухал үүрэг гүйцэтгэх болжээ. /Мягмар болон Нельсон 2001 он/

1990-ээд оноос нийслэлд ХМХ хөгжиж байхад, аймгуудад нөхцөл байдал эрс доройтсон юм. Олон аймагт төрийн мэдлийн орон нутгийн хэвлэл мэдээллийн хуучин тогтолцоо задарч, хэвлэл мэдээллийн олон байгууллага шинээр байгуулагдсан ч, санхүүгийн хувьд хүчин мөхсдөж, үйл ажиллагаагаа зогсоожээ. 2000 оны байдлаар 21 аймгийн долоо нь орон нутгийн сонингүй, орон нутгийн бүх сонинны хэвлэлтийн тоо 400 мянга орчим байв. Мөн 2000 онд 13 аймаг орон нутгийн радио станцтай, тэдгээрийн тэн хагас нь өдөр бүр, 3-16 цаг, үлдсэн нь долоо хоногт 1-7 цагийн өргөн нэвтрүүлэг цацдаг байв. Нийт 17 аймаг орон нутгийн телевизтэй ч, хоёроос бусад нь долоо хоног бүр хагас цагаас 7 цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг байлаа.

Улаанбаатарт хэвлэл мэдээлэл эрчимтэй хөгжиж, нийслэлийг хамарч байсан нийгэм, эдийн засгийн бүхий л өөрчлөлтийн тусгал болж байв. 1980-аад онд нийтлэлийн бодлогод тавьж байсан хатуу хяналтаа Засгийн газар алдсан төдийгүй 1990 оны 2-р сард “Шинэ толь” сонин гарсанаар төр засгийн ноёрхол эцэс болсон гэж үздэг байна. Дараагийн жилүүдээс нь нийслэлд улс төрийн, гол төлөв долоо хоног тутмын шар сонин óòà гарч эхлэв. Засгийн газар шинэ сонин хэвлэлийг хүлээн зөвшөөрч, 1991 оны намраас бүх сонин Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд бүртгүүлж, зөвшөөрөл авдаг болжээ.

Хууль тогтоомж

Хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулсан зохих хуульгүй байснаас 1990-ээд онд Монголын хэвлэл мэдээлэл 1992 онд батлагдсан Үндсэн Хуулийн агуулгын хүрээнд хөгжиж ирсэн. Монгол Улсын Үндсэн хуулиар мэдээлэл хүлээж авах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан юм. 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдсанаар хэвлэл мэдээллийн салбарын зохицуулалтын хүрээг тогтоож өгчээ. Цагдан хяналт(òáí çòð)-ыг эцэс болгох, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулахад хуулийн зорилго оршиж байв. Уг хуулийн заалтууд бүрхэг, биелүүлэх нарийн заалт байхгүй. Төр, түүний байгууллагууд óýâéýè íú äýúèèèèèä хяналтандаа байлгахыг энэ хуулиар хориглосон. Төрийн мэдэлд байсан үндэсний хэмжээний хоёр сонинг хувьчилсан ч, уг хууль Засгийн газар төрийн мэдлийн радио телевизийг хуучны адил эзэмших, мөн орон нутгийн засаг захиргаа ХМХ өмчилж, үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлж чадаагүй билээ.

Төрийн нууцын тухай хуулиуд нь нууцлалын хүрээ, ангилал өргөн тул засгийн газрын мэдээ баримтад ч хамаарна. Засгийн газрын бүх шатны албан тушаалтнууд олон нийтээс мэдээллийг нуун дарагдуулахын тулд энэхүү хязгаарлалтыг олонтаа ашигладаг. “Глоб Интернэшнл” ТББ-ын хүчтэй лобби, олон улсын шахалт шаардлагын дүнд Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам 2006 оны 5-р сард Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Засгийн газарт оруулсан юм. Хуулийн төсөлд өнөөгийн байдлыг сайжруулах зарим чухал зүйл оруулсныг “19-р зүйл” байгууллага сайшаажээ. Хуулийн төслийг цогцоор нь үнэлж, дүгнэсэн санамж бичигт хуулийн зарим зүйл заалтыг сайжруулах шаардлагатай байгаа тухай тус байгууллага онцлон тэмдэглэжээ.

<http://www.article19.org/pdfs/analysis/mongolia-foi-law.pdf>):

- *Хуулийн төсөлд мэдээлэл хүртэх эрхийг тодорхой, хоёрдмол санаагүй тусгаж өгөх хэрэгтэй.*
- *Хуулийн төсөлд заасан мэдээллээ чөлөөлөх системийг бүрмөсөн шинэчлэн засах хэрэгтэй.*
- *Бусад хуулиар нууцын ангилалд оруулсан мэдээллийг чөлөөлөх заалтыг хасаж, үүнийг дээр дурдсан олон улсын стандартад нийцсэн мэдээлэл чөлөөлөх тухай нарийвчлан боловсруулсан дэглэмээр орлуулах.*
- *Мэдээлэл чөлөөлөх дэглэм болон нууцын тухай хуулийн хооронд зөрчил гарсан тохиолдолд хуучин нь давамгайлах ёстой.*

Үүний зэрэгцээ бодөөд зохих ёсоор хэрэгжүүлэх асуудал тавигдаж байна. Хууль тогтоогчид шаардлагатай өөрчлөлт хийж, хууль батлах эсэхийг цаг хугацаа харуулах биз.

Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хөгжлийг хязгаарлаж буй Монголын хууль эрх зүйн өөр нэг баримт бичиг бол нэр төр, гүтгэлгийн талаарх хууль тогтоомж юм. Энэ хууль иргэний нэр, нэр төр, мөн хувийн нууцыг зүй ёсоор хамгаалдаг ч, эрүүгийн болон иргэний хуульд нэр төр, гүтгэлэгтэй холбоотой зүйл заалт орсон нь олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөж байна.

Эрүүгийн хуулинд:

Гүтгэлгийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан, эсвэл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулах, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ялаар шийтгэнэ.

Эдгээр хатуу заалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ерөнхий баталгаатай нийцэхгүй бөгөөд одоогийн ерөнхийлөгчтэй холбоотой нэр төр гутаасан хэд хэдэн хэргийг шүүхээр шийдвэрлэжээ. /дэлгэрэнгүйг www.monitoring.mn/?module=record1&id=130&menuid=30/

1990 оны сүүлээр иргэний нийгмийн байгууллагууд төрийн мэдлийн радио, телевизийг өөрчлөх асуудлаар нөлөөллийн ажил өрнүүлсэн юм. Эцэст нь 2005 оны 1-р сард “Глоб Интернэшнл” ТББ, “19-р зүйл” зэрэг олон улсын байгууллагатай зөвлөлдөж, 2006 оны 1-р сард Олон нийтийн радио телевизийн тухай хуулиа батлаа төрийн мэдлийн радио, телевиз олон нийтийнх болж өөрчлөгджээ.

Хамгийн сүүлд хуульд оруулсан өөрчлөлтөөр зар сурталчилгааны орлогыг нийт нэвтрүүлгийн цагийн 0.5 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан байна. Арилжааны ашиг сонирхлоос хараат бус байхын тулд хуульд энэ заалтыг оруулсан бол одоо хууль тогтоогчид олон нийтийн өргөн нэвтрүүлгийн /ОНӨН/ тогтвортой байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай санхүүжилтийг баталгаатай байлгах үүрэг хүлээж байна. Өргөн нэвтрүүлгийн орлогын гол эх үүсвэр нь үйлчилгээний хураамж, улсын төсвөөс бүрддэг. Ийнхүү санхүүжилтийнхээ 70 орчим хувийг улсын төсвөөс авдаг учир тус байгууллага өнөөгийн байдлаар улс төрөөс хараат бус байж чадахгүй, хувийн ашиг сонирхлын гол бүлгүүдтэй ивээн тэтгэх гэрээ байгуулахыг чармайсан хэвээр байна. ОНРТ-ийн тухай хууль аль ч утгаараа орон нутгийн засаг захиргааны байгууллагаас ХМХ-д нөлөөлж байгаа оролцоог эцэс болгож чадаагүй байна. Энэ хуулинд “Орон нутгийн түвшинд олон нийтийн радио телевиз байх боломжтой. Хуулинд заасан зарчмын дагуу орон нутгийн радио телевизийг байгуулах бөгөөд орон нутгийн иргэдийн ашиг сонирхолд үйлчилж, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналтан дор нь ажиллана” гэж заасан байна. “Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурал орон нутгийн радио, телевизийн төсөв, үйл ажиллагааны журмыг тогтооно”. Гэхдээ орон нутгийн ХМХ хаанаас санхүүжихийг хуулинд зааж өгөөгүй байна. Энэ шалтгааны улмаас орон нутгийн телевизүүд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага болж өөрчлөгдөх тодорхой заавар байхгүй тул орон нутгийн засаг захиргааны мэдэлд хэвээр байна.

Монгол улсын Хүний Эрхийн Өаг 2000 Үндэсний Хөтөлбөрт “Үндэсний цөөнхийн эх хэлээрээ мэдээлэл солилцож, түгээх явцыг сайжруулах арга хэмжээ авна” хэмээн заажээ /“Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл хүртэх эрх” 2.2.5.7 зүйл/. Тус улсын алслагдсан нутагт энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд цаг агаарын хүнд нөхцөл, зам, цахилгаан эрчим хүч байхгүй, тоног төхөөрөмж үндэсний стандартад нийцдэггүй, одоо байгаа болон шинээр байгуулагдсан өргөн нэвтрүүлгийн байгууллагад бэлтгэгдсэн боловсон хүчин хомсдолтой, эдгээр асуудлыг шийдэх санхүүгийн боломж төв удирдлагад үндэсний дутагдалтай зэрэг бэрхшээл тулгарч байна. Мэдээлэл хүртэх боломж тэгш бус байгаа нь үндэсний цөөнхийг нийгэм, эдийн засаг, боловсрол, улс төрийн амьдралаас шахан гаргаж байгаагаас өөрцгүй юм.

Эцэст нь, хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл төвлөрөхөөс сэргийлсэн хэвлэл мэдээллийн өмчлөлийн талаар хууль байхгүй байна.

Өнөөгийн байдлаар, хувийн хэвлэл мэдээллийн эзэмшилд хязгаарлалт тавиагүй ч, хуулиар төр итгэл мэдээллийн хэрэгсэл эзэмшихийг хориглосон байдаг. Тиймээс улс төрийн намууд хувь хүнээр дамжуулан ХМХ-д хөрөнгө оруулж байна. Олон нийт хэвлэл мэдээллийн аль хэрэгслийг ямар улс төрч эзэмшиж байгаа, ямар арга замаар аль талыг түлхүү дэмжиж байгааг олон нийтэд мэдүүлэх үүднээс хэвлэл мэдээллийн байгууллагын бүх эзэмшигчийн нэрийг ил тод болгох талаар одоо ид яригдаж байна. АНУ-ын Христийн шашны байгууллагын санхүүжилтээр ажилладаг “Ийгл” телевиз гэх мэтийн гадаад эзэнтэй ХМХ байна.

Хулгайн бүтээл, зохиогчийн эрхийн зөрчлийг бодлогын түвшинд авч үзэхгүй байна. ^a дээр үндэслэл бүх суваг ёну, эцсийн хэрэглэгчдэд хулгайгаар хуулбарлан монгол хэлээр орчуулж, эцсийн хэрэглэгчдэд борлуулж байна. Зохиогчийн эрхийг төдийлөн хүндэлдэггүй хүмүүст хулгайн бүтээл нь өрсөлдөөний давуу тал болж байна. Агуулгаа өөрсдөө боловсруулахын оронд хямд үнээр бүтээл хуулсаар байвал хэвлэл мэдээллийн үйлдвэрлэл хөгжихгүй гэж хэвлэл мэдээллийн зарим эзэн үзэж байна.

Мэдээлэл, барилцаа холбооны технологийг цогцоор нь хүргэх чухал сорилт юу нголын ард түмэнд тулгараад байна. Зөвхөн хот суурин газар гэлтгүй аймаг, сумдад орчин үеийн мэдээллээ технологийг нэвтрүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулжээ.

“Е-Монгол” үндэсний хөтөлбөрийн 2012 онд хүрэх зорилтуудаас дурдвал:

- *МХХТ-ийг нэвтрүүлэх, хөгжүүлэх эрх зүйн орчин бий болгох*
- *Улс орныг хамарсан нийтэд хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны өндөр хурдны нэгдсэн сүлжээ байгуулах*
- *Өндөр хурдын нэгдсэн сүлжээг олон улсын урсгалд холбох*
- *МХХТ-ийн салбар дахь монопольт байдлыг халж, бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэнээр шинэ эдийн засгийг бий болгох*
- *Бүх нийтийн мэдээллийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх*

Бүх аймаг, сумыг 2006 оны сүүлээр шилэн кабелиар холбож дуусгавал, олон тооны мэдээллийг цаг алдалгүй хүртэх боломж бүрдэх юм. Судалгаа хийж байсан үе буюу 2006 оны 9-р сард ихэнх аймаг хэдийнэ шилэн кабелийн сүлжээнд холбогдсон байсан. Шилэн кабель тавих нүх ухах боломжгүй болох учир өвлөөс өмнө төслөө дуусгахаар шаргуу ажиллаж байв.

Бараг бүх аймаг интернет кафетай, зарим сургууль компьютерийн сургалт явуулдаг танхимтай байна. Компьютерийн сургалт чухал. Улаанбаатар хот, аймгийн төвийн залуучууд компьютерийн хэрэглээг хурдан эзэмшиж байгаа бол ахмад үеийнхэн компьютер эзэмшихгүй тэднээс хоцорч байна. Энэ боломжийг хэрхэн бүрэн ашиглаж, бодлоготой хэрэгжүүлэх талаар засгийн газарт тодорхой төлөвлөгөө байхгүй ажээ.

Хэвлэлтийн тоо хязгаарлагдмал хэвээр, сэтгүүл зүйн чанар эргэлзээтэй байв. Зохиогчийн эрхийн асуудлыг илт огоорон Азийн орнууд, үндэстэн дамнасан сувгуудыг өргөнөөр авч, радио телевизийн нэвтрүүлэг хүлээж авах боломж эрс нэмэгдсэний зэрэгцээ үзэгчдийн хөтөлбөрийн сонголтыг өргөжүүлсэн. Үндэсний хэвлэл мэдээллийн зах зээл өргөжсөн ч, жинхэнэ голдрилдоо орох болоогүй, хэвлэл мэдээллийн ихэнх байгууллага бизнесийн үйл ажиллагаа явуулахгүй байв.

МХХ-ийн тоо 2003 онд 321 байсан бол, 2005 онд 340 болж, жил бүр хугацаанд бага зэрэг нэмэгджээ. Хэвлэл мэдээллийн байдал харьцангуй тогтвортой байсан ч өнгөрсөн хэдэн жилд зарим нэг чухал ахиц гарсан байна. 2003 оноос хойш нийслэлд хэд хэдэн телевиз, аймгийн голдуу ФМ радио шинээр байгуулагдаж, эцэст нь өдөр тутмын сонины тоо 2005 онд 6-8 болж нэмэгджээ.

МХХ-ийн 1999 оноос хойш тасралтгүй явуулж байгаа Монголын хэвлэл мэдээллийн мониторингоос үзэхэд Монголын хэвлэл мэдээллийн салбарт хэвлэл мэдээллийн нийлүүлэлтийн талаар мэдээ баримт сайн байдаг ч, хэвлэл мэдээллийн хэрэглээтэй холбоотой мэдээлэл тэр бүр байдаггүй байна. МХХ нийслэлийн телевиз үзэгч, радио сонсогч, уншигчдын талаар тоо баримт бүрдүүлдэг ч, хөдөө орон нутаг дахь хэвлэл мэдээллийн ашиглалт, үндэсний цөөнхийн мэдээлэл хүртэх боломжийн талаар төдийлөн баримтжуулаагүй байна.

2.2. Телевиз

2.2.1 Тойм

Нийслэл, орон нутагт телевизийн салбар эрс өөрчлөлтийн шатанд байна. Урьд өмнө давамгайлах байр суурьтай байсан Монголын Үндэсний Радио Телевиз /МҮРТ/ олон нийтийн болон өөрчлөгдөж өрсөлдөөний талбарт нийслэлийн бусад телевизийн адил үүрэг гүйцэтгэх болжээ. Орон даяар өргөн нэвтрүүлгээ цацдаг Улаанбаатарын телевизүүд бий болж, өрсөлдөөн нэмэгдсэн байна. Улаанбаатар хотод Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз /МҮОНРТ/, 25-р суваг, “Ийгл” телевиз, UBS гэсэн дөрвөн сувагтай, нэлээн тогтвортой байсан он жилүүдийн эцэст 2003 онд ТВ-5, ТВ-9 гэсэн хоёр шинэ телевиз мэргэжлийн түвшинд байгуулагдаж, 2004 онд “Ийгл” телевиз түр хаагдсан байна.

МҮТВ-ийн оронд одоогийн Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз (МҮОНТ), бусад дөрвөн телевиз (25 суваг, UBS, ТВ-5, ТВ9) 2004 оноос сансрын холбооны шугамаар нэвтрүүлгээ цацдаг болжээ. Улаанбаатар, аймгийн төвд орон нутгийн эрх баригчдын мэдэлд байдаг ажээ. МҮОНТВ өөрийн сувагтай, UBS, 25-р суваг телевиз хоёр, ТВ-5, ТВ-9 хоёр тус бүр нэг нэг сувгийг хамтран ашиглаж байна. Эдгээр телевиз нэвтрүүлгээ нэг өнжөөд солбиж үзүүлдэг ажээ. Тухайн аймгийн боломж хязгаарлагдмал бол эхлээд МҮОНТ, дараа нь ТВ-

5, ТВ-9-ийн нэвтрүүлгийг хүлээн авдаг ажээ. Сансрын сувгийг ашиглаж эхэлснээр МҮОНРТ-ийн өргөн нэвтрүүлгийн хүртээмж нэмэгдэж, Улаанбаатар хотын дөрвөн телевизийг хоногтоо хүлээн авах болсон байна.

Үндэсний хэмжээний өргөн нэвтрүүлэгтэй таван телевизээс гадна 10 дамжуулагч зургаан телевиз, кабелийн 10 суваг зөвхөн сүүлийн гурван жилд байгуулагджээ. Эдгээрийн дотор үйл ажиллагаагаа дахин эхэлсэн “Ийгл” ТВ, мөн С1 зэрэг мэргэжлийн өндөр түвшинд хүрсэн, санхүүжилт сайтай сувгууд байгаа ч, дийлэнх нь бага төсөвтэй кабелийн телевиз байна.

Кабелийн телевизийн сүлжээ Улаанбаатарт төдийгүй ихэнх аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод кабелийн зургаан суваг байгаагаас хамгийн том нь Оятад-Монголын хамтарсан “Сансар” CATV /<http://www.sansarcstv.mn/> рi. Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тухай найдвартай, ил тод мэдээлэл байхгүй ч, 2005 оны Монголын хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны дүнгээс үзвэл Улаанбаатар хотын өрхийн 54 хувь нь кабелийн аль нэг телевизийн захиалагч ажээ. Өөрсдийн газарт орон сууцанд амьдардаг айл өрхийн дунд кабелийн холболт илүү дэлгэрсэн байна. Сансар кабелийн телевиз гэхэд 50 сувгийг сарын 4000 төгрөгийг төлбөртэйгээр санал болгодог. Өөрсдийнх нь хэлснээр 50 мянган захиалагчтай ажээ. Тэд Монголоос гадна англи, орос, хятад, герман, оранц гэх мэт сувгийн нэвтрүүлэг хүлээн авдаг. Монгол хэлээр нэвтрүүлгээ цацдаг сувгууд үүнд багтаж байна. “Сансар” кабелийн телевиз 2003 онд өдөрт таваас зургаан цагийн хөтөлбөртэй өөрийн суваг байгуулж байсан бол өнөөдрийн байдлаар голдуу хөгжим, цэнгээнт нэвтрүүлэг явуулдаг 24 цагийн өргөн нэвтрүүлэгтэй гурван сувагтай болжээ.

Гадаадын олон сувгийн өргөн нэвтрүүлгийг хулгайгаар дамжуулдаг байсан тул эздийн зүгээс гомдол мэдүүлж, хуулийн арга хэмжээ авахыг сануулан анхааруулжээ. Үүний дараа тухайн кабелийн телевизээр дамжуулж байсан гадаадын хэд хэдэн сувгийг нэвтрүүлэхээ зогсоов. Германы “Дойче Велле”, Францын “ТВ5” зэрэг гадаадын сувгуудын нэвтрүүлгийг үнэ төлбөргүй цацах гэрээ байгуулснаар, тэдгээрийг Монгол даяар үзэх боломжтой болсон юм. Улаанбаатарт ажилладаг кабелийн зарим хүчирхэг телевиз үндэсний хэмжээний сувгуудаас төлбөр авч, нэмэлт орлого олдог байна.

Төсөв багатай телевизийн станц байгуулах зардал эрс буурсан тул сүүлийн хэдэн жилд орон нутгийн телевизийн тоо ихээхэн нэмэгджээ. 2005 оны Монголын хэвлэл мэдээллийн мониторингод дурдсанаар тухайн жилд орон нутгийн 36 телевиз байсан бол, шинээр байгуулагдсан олон телевизийг судалгааны баг бүртгэж авсан юм. Үүний дотор хоёроос гурван телевизтэй хэд хэдэн аймаг байв. Ихэвчлэн техникийн шалтгаанаар зарим телевизийн өргөн нэвтрүүлэг тогтмол бус ажээ. Зарим телевиз долоо хоногт цөөн цагийн өргөн нэвтрүүлэгтэй, түүнийгээ 10 минут, эсвэл долоо

хоногийн турш давтдаг, зарим нь өдөрт цөөн цагийн өргөн нэвтрүүлэгтэй байна. Үүнийг телевиз өдрийн турш өргөн нэвтрүүлгээ дамжуулдаг ажээ. Эдгээр телевизийн зарим нь өөрийн дамжуулагчтай, эсвэл орон нутгийн кабелийн сүлжээг ашигладаг байна. Зарим нь дээр дурдсан сансрын сувгаар дамжуулж буй нэвтрүүлгийг тасалж, өөрийн өөрийн үзүүлдэг ажээ.

Ихэнх аймгийн төв ФМ радиотай, мөн нэгээс хоёр кабелийн сүлжээтэй, түүгээрээ телевизийн нэвтрүүлэг дамжуулдаг, түүнчлэн үүрэн телефоны сүлжээтэй ажээ. Аймгийн төвд ажиллаж буй кабелийн телевизүүд нэг өрхөд 2000-3500 төгрөгөөр 20-50 суваг үзэхийг санал болгодог байна. Хулгайн замаар үзүүлбэл, асар олон суваг хүлээн авах боломжтой. Жижиг аймгийн төвүүдэд кабелийн телевизийн хэрэглэгч 200-500 байдаг бол, Дархан-Уул гэх мэт томоохон аймагт хэрэглэгчийн тоо 1500 хүрч байна. Орон нутагт кабелийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид кабелийн сувгийн үйл ажиллагаанаас олсон орлогоо телевиз, ФМ радиодоо хөрөнгө оруулахад ашигладаг байна. Эс тэгвэл санхүүгийн хүндрэлийн улмаас тухайн радио телевиз нь орон нутагт хөл дээрээ босох боломжгүй.

Өөдөө орон нутагт телевизийн өргөн нэвтрүүлэг эрхлэхэд цахилгаан эрчим хүчний асуудал гол бэрхшээл ажээ. Аймаг, түүнчлэн томоохон сумын төвүүд өдрийн турш цахилгаантай. Харин олон сумын төвийн дизель станц ихэвчлэн оройн цагаар өөрийн цахилгаан нийлүүлдэг. Гэрэл цахилгаантай хэдэн цагт л телевизийн өргөн нэвтрүүлгийг дахин цацах боломжтой. Иймээс зарим сум, багт телевизийн өргөн нэвтрүүлэг хүлээн авах боломж дордсон.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй тус улсад цахилгаан эрчим хүч тулгамдсан асуудал юм. Тиймээс хүлээн авах, дамжуулах станцын хамрах хүрээний бүсэд амьдардаг хүмүүс л телевизийн нэвтрүүлэг хүлээн авах боломжтой ажээ. Иймд хөдөөгийн малчид телевизийн нэвтрүүлэг хүлээн авах тавган антенаа ажиллуулахын тулд, нарны зай, салхины хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчний нөөцөд илүү найддаг байна.

Онолын хувьд малчид хиймэл дагуулаар бүх сувгийг хүлээж авах аргаар ч гэсэн ч техник тоног төхөөрөмж хязгаарлагдмал, хэлний бэрхшээлийн улмаас малчид голдуу Монгол, өвөр Монголын цөөн хэдэн сувгийг хүлээж авдаг байна. Казахстан оршин суудаг баруун аймгийн малчид ҮОУ-ын бүрэлдэхүүнд байсан Казахстан, мөн Туркийн хиймэл дагуулын телевизийг хүлээж авдаг.

ЮНЕСКО-ийн нийгэмд Тандэм TTVS ашигласныг Баян-Өлгийд хийсэн судалгаагаар: "Тэнд өөрийн дүрс үйлдвэрлэлийн бааз байхгүй зөвхөн релейнийх байдаг". Тандэмний олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь тус аймагт зөвхөн радио төлөөлж байна. Аймгийн өөрийн дамжуулах станцын онцгой нөхцөл байдлын улмаас гол хэл үзүүлдэг нэвтрүүлгийг хүлээж авах боломжгүй болжээ. 1965 онд байгуулагдсан

хуучин Чехословакийн Тесла тоног төхөөрөмж бүхий тус станц нийт хүчин чадлынхаа /30 квт/ дөнгөж тал хувийг нь ашиглаж байгаа бөгөөд нутгийн Мэдээлэл Технологийн Газрын /хуучнаар Мэдээллийн төв/ бэлтгэсэн казах хэл дээрх нэг цагийн нэвтрүүлэг, Улаанбаатараас дамжуулдаг монгол хэл дээрх 17 цагийн нэвтрүүлгээ тус тус цацдаг байна.

Малчдын ашиглаж буй тавган антены тооны тухай бодит мэдээ байхгүй. Өандивлагч байгууллагуудын тусламжаар нарны зай, тавган антентай болсон, мөн гол зам дагуу оршдог гэх мэт чинээлэгдүү гэж болохоор зарим нутаг, сум, аймгийн төвд тавган антен илүү тархжээ. Зарим эх сурвалжаас үзэхэд, малчдын 50 гаруй хувь, өөр эх сурвалжийн мэдээгээр 30-50 хувь нь антентай гэнэ.

Дулааны улиралд бэлчээрийн соргогийг шилэн оторлон нүүхдээ малчид өдөржин завгүй тул гол төлөв антенаа өвөлжөөндөө орхидог аж. Нонин хэвлэл ховорхон очдог болохоор энэ үед радио мэдээллийн гол эх сурвалж болдог байна.

2.2.2 Төрийн мэдлийн өргөн нэвтрүүлэг олон нийтийн болох явцад

Дээр дурдсанчлан 1 лон нийтийн радио, телевизийн тухай шинэ хуулийн дагуу төрийн мэдэлд байсан өргөн нэвтрүүлэг 2006 оны 1-р сарын 1-нд албан ёсоор олон нийтийн өргөн нэвтрүүлэг болон өөрчлөгдөн байгуулагджээ. Тиймээс тус телевиз дотоод зохион байгуулалтын өөрчлөлт хийхийн сацуу өрсөлдөөний шинэ орчинд дасан зохицохыг чармайж байна.

1990-ээд оны улс төрийн шилжилтийн дараа ч гэсэн Монголд төрийн мэдлийн радио, телевиз давуу эрхтэй байв. Тэдний мэдэлд радиогийн хоёр суваг байснаас нэг нь орон даяар, нөгөө нь гол төлөв нийслэл хотод нэвтрүүлгээ цацдаг байв. Телевизийн нэг сувгийн нэвтрүүлгийг орон даяар хүлээн авч байлаа. Тавган антентай айл өрхийн тоо нэмэгдэж буй ч, олон малчны хувьд радиогийн үндэсний сувгийн нэвтрүүлэг орон даяар хүртээмжтэй цорын ганц электрон ОИО хэвээр байна. Телевизийн хувьд релейний шугамаар нэвтрүүлгээ дамжуулдаг байснаа одоо сансрын Азисат суваг, улс даяар байдаг 320 хүлээн авах, дамжуулах станцаар нэвтрүүлгээ цацаад хэдэн жил болж байна.

МҮОНТВ-ийн өөрийнх нь дүн мэдээгээр улсын хэмжээнд 1,8 сая телевиз үзэгчтэй, долоо хоногт 119 цаг, жилдээ 6100 цагийн өргөн нэвтрүүлэг бэлтгэж цацдаг, 270 ажилтантай.

Радио нь өнөө хир үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгээрээ монополь байдалтай, телевиз нь ч хамгийн олон үзэгчтэй байгаа нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн хувьд өрсөлдөөний давуу тал юм. Энэ утгаар бол МҮОНРТ ойрын жилүүдэд орон нутгийн оршин суугчдын мэдээллийн гол

эх сурвалжийн хувьд гол үүрэг гүйцэтгэх төдийгүй үүндээ дөрөөлөн улс төрийн “гол тоглогч” хэвээр байх бололтой. Энэ давуу байдал нь ялангуяа телевизийн хувьд сул тал үүсгэнэ. Нийслэл дэх цэцэглэн хөгжиж буй телевизийн зах зээл дээр телевиз үзэгчдийн төлөв эрс өөрчлөгдөж байна. Олон нийтийн телевиз нэвтрүүлгийнхээ өнөөгийн бодлогыг энэ хэвээр нь хадгалж, Монголын хүн амын хэрэгцээ шаардлагад үл нийцэх, төрийн мэдэлд байхаас эхлэн тогтсон дээрээс удирдан зохицуулдаг арга барилыг хуучнаар нь үргэлжлүүлбэл нийслэлийн шинэ өрсөлдөөнт орчинд байр сууриа тун удахгүй алдана. Нөгөө талаас энэ нь, нийгмийн тодорхой бүлэг хэсгүүдэд хуваагдсан нийслэлийн орчин үеийн үзэгч, өөр хоорондоо адил төстэй хөдөөгийн үзэгчийн хэрэгцээ шаардлагын зааг ялгааг холбож чадахгүй учир оновчтой стратеги боловсруулах нь томоохон асуудал юм. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь олон нийтэд үйлчлэх үүргээ биелүүлэх ёстой. Одоогоор олон нийтийн өргөн нэвтрүүлэгт эдгээр асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан зохистой стратеги алга.

Хоёрдугаарт, шилжилтийн үйл явцад улс төрийн шинжтэй зүйл ч байна. Улс төрийн эрх баригчид, байгууллагын дээд удирдлагаас эхлээд бүх ажилтан албан хаагч өнөө хэр í ÿ амь бөхтэй байгаа улс төрийн соёлыг өөрчлөх шаардлагатай. Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд олон жилийн турш төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн статусын òòöæ хэлэлцүүлэг өрнүүлж байсан. Гэсэн ч, хэт улс төржсөн нийгэмд радио телевиз бол эрх мэдлийн чухал хэрэгсэл гэдгийг ойлгож байсан тул МАХН ч, Ардчилсан нам ч засгийн эрхэнд байхдаа төрийн мэдлийн өргөн нэвтрүүлэгт тогтоосон хяналтаасаа татгалзахад бэлэн биш байлаа. Өчнөөн жилийн дараа, 2005 онд Í лон нийтийн радио телевизийн тухай хууль батлах болсон нэг шалтгаан нь МАХН ч, Ардчилсан нам ч Улаанбаатарт, мөн улс даяар өөрсдийг нь сайн дэмждэг хувийн олон тооны радио, телевиз байгуулсантай холбоотой байж болох юм. Өөр нам тэдгээр телевиз, радиогоор дамжин сонгогчдод хүрэх мэдээлэлд хяналт тавьж байна.

Олон нийтийн радио, телевизийн шинэ хууль олон улсын хэмжээний дагуу төр, засгаас өргөн нэвтрүүлэг эрхлэгчид үзүүлдэг шууд нөлөөг хоригложээ. Иймээс 15 гишүүнтэй Зохицуулах зөвлөл буюу Үндэсний Зөвлөл байгуулагдсан нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийг удирдан хянах үүрэг хүлээж байна. Үндэсний Зөвлөлд нэр дэвшигчийг иргэний нийгмийн байгууллагаас санал болгоно. Олс төрийн намын ажилтан, улс төрийн албан тушаалтан, төрийн албан хаагч Үндэсний Зөвлөлд байж болохгүй. Санал болгосон хүмүүсээс Ерөнхийлөгч дөрөв, Засгийн газар дөрөв, УИХ үлдсэн долоон гишүүнийг нэр дэвшүүлж, ОЕО томилно. Сонгон шалгаруулах энэ үйл явц Үндэсний Зөвлөлийн хараат бус байдлыг хангаж чадахгүй байна. Учир нь, дээд зиндааны улс төрчид олон нийтийн өргөн нэвтрүүлэгт тавих хяналтаас татгалзахад хараахан бэлэн биш гэдэг нь анхнаасаа тодорхой байлаа. Үндэсний Зөвлөл шууд бус нөлөөний төлөө улс төрийн тэмцлийн талбар болж, үүний уршгаар ОНРТ-ийн анхны ерөнхий захирал

томилогдсоноосоо хойш хэдхэн сарын дараа огцорсон. Олон нийтийн шинэ өргөн нэвтрүүлгийн зарим удирдлага сүүлийн саруудад хэд хэд өөрчлөгдсөн байна. Улс төрийн шууд нөлөө нь шууд бус болон өөрчлөгдсөн нь сайн хэрэг. Улс төрийн гол хоёр нам өөрсдийн телевиз байгуулах замаар нэгэнт урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тул хэвлэл мэдээллийн шинэ өрсөлдөөнт орчинд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байр суурь, дээр дурдсанчлан, ганхаснаар аажимдаа улс төрийн нөлөө зарим талаар буурч байна.

Гуравдугаарт, шилжилтийн явцад санхүүгийн асуудал ч хамаатай. МҮОНРТ-ийн санхүүжилтийн гуравны нэг нь үзэгчдийн хураамж, гуравны хоёр нь улсын төсвөөс бүрддэг тул санхүүгийн хувьд Үзэгчдийн газраас шууд хараат байна. Түүгээр ч үл барам МҮОНРТ олон нийтэд үйлчлэх үүргээ биелүүлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэх, урт хугацаанд ажилчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд илүү шаардагдах хангалттай санхүүжилтгүйгээр байгуулагджээ. Нэгэнт шилжилтийн явцад хөрөнгө мөнгө нь хязгаарлагдмал учир улам нэмэгдэж буй өрсөлдөөнт орчинд амьдрах, зохих ёсны өөрчлөлт хийхэд туйлын бэрхшээлтэй.

Эцэст нь тэмдэглэхэд, шилжилтийн үйл явцад нөөц чадавхийн асуудал бас хамаатай байна. Учир нь МҮОНРТ сайн ч бай, муу ч бай барилга байшин, хоцрогдсон тоног төхөөрөмж, удирдлага, орон тоо, түүнчлэн үзэгчдийн улс төрчдийн уламжлалт хүлээлт гэхчлэн хуучны коммунист тогтолцооны өргөн нэвтрүүлгийг өвлөн авсан юм. Төрийн мэдэлд байсан өргөн нэвтрүүлэг 2001 оноос зохион байгуулалт хөтөлбөрийн өөрчлөлт хийх санаачлага өрнүүлсэн ч, дотооддоо шинэтгэл хийх чадваргүй байв. Шинэтгэлийн үйл явцыг гадны хүмүүс олж хараагүй ажээ. Шинэ удирдлагаас зарим нь улс төрийн томилгоогоор ирсэн бол үлдсэн бусад удирдах ажилтан, ажилтнууд хуучиндаа ууссан, шинэ орчинд ажиллахад зохих түвшинд бэлтгэгдээгүй байна. Хуучин барилга, байгууллагын талаарх ойлголт цөм өнгөрсөн цаг үетэй шууд холбоотой.

Энэ бүхэн нь шинэ хуулиас ч илүү, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй сайн тоног төхөөрөмжтэй телевиз, орон даяар байгуулагдсан, цэнгээнт нэвтрүүлэг бэлтгэдэг олон шинэ ФМ радиодоо өрсөлдөхүйц цоо шинэ эхлэлийг шаардаж байна. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг ийм шинэ эхлэл тавих чадваргүй, шилжилтийн дүнд зөвхөн нэвтрүүлгийн бодлогод бага зэргийн өөрчлөлт гарсанд үзэгчид, иргэний нийгмийн бүлэг хэсэг, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд сэтгэл дундуур байгаа ажээ. 2006 оны 6-р сард Хөвсгөл аймагт болсон нөхөн сонгуулийн кампанийг, өнгөрсөн сонгуулиудын өрөөсгөл сурталчилгаанаас нэлээн өөр, улс төрийн хувьд илүү тэнцвэртэй мэдээлсэн гэлцэж байна. “Өөрчлөлт шинэчлэлтийг эрчимтэй хийж байгаа тул үзэгч, сонсогчид жаахан хүлээцтэй хандах байх гэдэгт найдаж байна” хэмээн удирдлага нь хэлэв. Учир нь “асар том хөлөг онгоцны чиглэлийг өөрчлөхөд цаг хугацаа хэрэгтэй” ажээ.

2.2.3 Агуулга

Олон тооны телевиз төрөл бүрийн нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэж байна. Орон даяар нэвтрүүлгээ цацдаг тав, мөн Улаанбаатарын бусад цөөнгүй телевиз мэдээ, улс төр, нийгмийн нэвтрүүлэг, соёл урлаг, цэнгээнт, спорт, хөгжим, боловсрол, кино, драмын цуврал, зар сурталчилгаа гэх мэт олон төрөл зүйлийн нэвтрүүлгээр үзэгчдийг хангаж байна. Улаанбаатарын зарим телевиз зөвхөн мэдээ, зөвхөн хөгжим зэрэг тодорхой чиглэлээр дагнан хөгжиж байна.

2005 оны Монголын хэвлэл мэдээллийн мониторингт дурдсанаар хөдөөд нэвтрүүлгээ цацдаг, мөн Улаанбаатарт шинээр байгуулагдсан телевизүүд ч нэвтрүүлгийнхээ ихэнхийг өөрсдөө бэлтгэдэг ажээ. Энэ нь уран бүтээлийн дотоод үйлдвэрлэлийн төрөл зүйлийг хөгжүүлэхэд чухал боловч тоо нь нэмэгдсэнээс чанар нь сайжраагүй байна. Нэвтрүүлгийг гол төлөв бие даасан жижиг продакшнууд бага хэмжээний, эсвэл огт хөрөнгө зарахгүйгээр төлбөрт захиалга, ивээн тэтгэлгийн хөрөнгөд дулдуйдан бэлтгэдэг байна.

Үндэсний бүх телевиз, мөн Улаанбаатарын зарим телевизийн хөтөлбөрт мэдээ чухал байр суурь эзэлж байна. Хэвлэл мэдээллийн бусад салбартай харьцуулбал, сэтгүүл зүй, үйлдвэрлэлийн чанар нь ерөнхийдөө доогуур. Мэдээ нь хэт өрөөсгөл, ихэнх тохиолдолд, зүрх сэтгэлээрээ жинхэнэ мэдээний төлөө бус, харин улс төрийн сонирхолыг нэн тэргүүнд тавьдаг эзэн, эрхлэгчийн өнцгөөс ханддаг байна. Сэтгүүлчдийн хэлэх үг хүчтэй хязгаарлалтад байдаг. Сонирхогч талууд мэдээний агуулгын төлөө мөнгө төлдөг, сэтгүүлчид байнга төлбөртэй мэдээ бэлтгэдэг байна.

Мэдээний талбарт “Ийгл” телевиз хүчтэй өрсөлдөгч болон гарч ирсэн. Тус телевиз хараат бус, тэнцвэртэй мэдээг тууштай дэмждэг, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх хөрс суурийг тавихад ихээхэн анхаарч ажиллаж байна. Түүгээр ч барахгүй тус телевиз өдрийн турш мэдээгээ Монголын олон нийтэд шууд хүргэж, мэдээний бүхий л төрөл, загварыг ашиглан, аливаа цензургүйгээр иргэдийн саналыг утсаар сонсох зэргээр мэдээ бэлтгэх шинэ арга барил, хэв маяг нэвтрүүлжээ. Үзэгчдэд хүрэх, тэднийг оролцуулах энэ шинэ арга барил, шинэ хэм хэмжээ тогтоож, бусад телевизийн нэг талыг барьсан, хяналттай мэдээг цохьжээ. “Ийгл” телевизийн рейтинг байнга өсөж, тус телевиз одоо Улаанбаатарын үзэгчдийг мэдээгээр хангахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна.

Олон телевиз өргөн нэвтрүүлгийнхээ цагаас хувийн продакшн, бусад сонирхсон бүлгүүдэд худалддаг. Продакшнууд ивээн тэтгэлэг, зар сурталчилгаанаас олсон орлогодоо үндэслэн хөтөлбөр бэлтгэдэг бол бизнесийнхэн, улс төрч, ТББ-ууд авсан хүссэн зүйлээрээ бөглөдөг ажээ. “American Idol (“Америкийн од)” гэх мэт гадаадын реалити шоу, тоглоомын загварыг ашиглан өөрсдөө бэлтгэдэг нэвтрүүлэг олширч байна.

25-р суваг телевиз нь зугаа цэнгээний нэвтрүүлгээрээ алдартай сувгуудын нэг юм. Тус телевиз олон алдартай нэвтрүүлэг бэлтгэдэг. Үүний нэг олон улсын аялалын нэвтрүүлэг ажээ. Аялалын багийнхан зорчин очсон тухайн улсын тухай төдийлөн хүндэтгэлтэй ханддаггүй ч тэдний чөлөөтэй байдал уг нэвтрүүлгийг үзэгчдийн дунд алдаршихад нөлөөлжээ. Үүний зэрэгцээ тус телевиз эрэн сурвалжлах сэтгүүл зүй, ёс зүйтэй сэтгүүл зүйн хөгжлийг хөхиүлэн дэмжихэд төдийлөн анхаардаггүй, харин үзэгчдийн дунд алдаршсан цэнгээнт нэвтрүүлгийн төрөлд шинэ хэм хэмжээ тогтоож байна.

C1 телевиз Монголын хуучин кинонууд үзүүлж, өглөөний мэдээний шинэ загвар бий болгосон. STV телевиз голдуу хөгжмийн нэвтрүүлэг явуулдаг гэхчилэн бусад телевиз ч шинэ хөтөлбөрүүд бий болгож байна.

Гадаадын нэвтрүүлгийн хөтөлбөрийн хувьд хулгай үндсэн асуудал ажээ. Ихэнх телевиз хулгайн замаар олж авсан киногоо монгол руу орчуулан үзүүлэхдээ эх бүтээлийнх нь харилцан яриа, дуу чимээг үлдээдэг. Хулгайн эсрэг хууль тогтоомж хэрэгждэггүй, тэгээд ч гадаадын киног орчуулах нь өөрсдөө үйлдвэрлэхээс хямд, эфирийн цаг бөглөх хялбар арга хэвээр байна.

Оюуны бүтээлийн хулгайг үлэмж бууруулсан ÷ дотоодын телевизүүд сайн чанарын өөрийн бүтээл хийх боломжтой эсэх нь эргэлзээтэй. Учир нь хэрэглэгчийн жижиг зах зээл нь зар сурталчилгаанаас их хэмжээний орлого олох боломж олгохгүй тул уран бүтээлийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх төсөв нь ч хомс.

Дээр дурдсанчлан орон нутаг дахь телевизийн өргөн нэвтрүүлгийн цаг харилцан адилгүй. Орон нутгийн телевизүүд ихэвчлэн хоёроос зургаан хүний бүрэлдэхүүнтэй цомхон бүтцээр ажилладаг. Нэг юм уу хоёр сэтгүүлч, нэг зураглаачаас илүү олон тоотой ажиллаж байгаа телевиз тун ховор. Телевизийн эзэн өөрөө сэтгүүлч, зураглаачийн үүргийг давхар гүйцэтгэдэг тохиолдол ч бий. Дархан, Эрдэнэт зэрэг арай хотжисон газрын телевизэд арай олон хүнтэй ажилладаг байна.

Хөдөөгийн ихэнх телевиз засаг захиргааны албан ёсны мэдээ, орон нутгийн зарим мэдээ, төлбөрт нэвтрүүлэг, зар сурталчилгаа нэвтрүүлж, заримдаа утсаар авсан зарлалыг дэлгэц дээр бичиж, далдаас уншдаг. Зарим телевиз өөрсдийн бэлтгэсэн баримтат, уран сайхны, хүүхдийн боловсролын, цэнгээнт нэвтрүүлэг, ярилцлага зэргийг дамжуулдаг. Үүний зэрэгцээ эфирийн үлдсэн цагаа голдуу гадаадын хулгайн нэвтрүүлгээр бөглөдөг.

Ажилтан, бэлтгэгдсэн сэтгүүлч, редактор, зураглаач дутмаг, ерөнхийдөө тоо цөөн, улс төр, санхүүгийн бэрхшээлээс үүдэн орон нутгийн ихэнх телевизийн нэвтрүүлгийн чанар тааруухан гэж болно. Жинхэнэ судалгаатай, шүүмжлэлтэй мэдээ, нэвтрүүлэг тэр бүр алга байгаа нь орон

нутгийн телевизүүд сонирхолтой, шүүмжлэлт мэдээ нэвтрүүлгийн эсрэг буй хэрэг биш юм. Нээлттэй Нийгэм Форумас 2005, 2006 онд “усны нөөц”, газрын баялагийн зөвшөөрөл гэх мэт нийгмийн асуудлыг олон нийтийн анхааралд төвлөрүүлэхийн тулд цуврал нэвтрүүлэг бэлтгэж, МҮОНТ-ээр явуулж, мөн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургалт зохион байгуулжээ. Эдгээр цуврал нэвтрүүлгийг сайн бэлтгэсэнээр хамгийн их үзэгчтэй болж, түүнтэй адил хэлбэрийн дууриамал нэвтрүүлэг олон бий болсон байна. Гэвч МҮОНТ-тэй урт хугацаанд хамтран ажиллахад хүндрэлтэй байсан тул нэвтрүүлгээ зогсоожээ. Гэхдээ чанартай бүтээл хийсэн олон жишээг дурьдаж болох юм. “Ийгл” телевиз гэхэд шуурхай, нягт нямбай мэдээ үйлдвэрлэсэнээрээ амжилт олж, хамгийн олон үзэгчтэй болжээ.

2.2.4 Үзэгчид

2003 онд МХХ төвийн хэд хэдэн телевиз, бизнесийн байгууллагатай Хамтарсан Зөвлөл байгуулан, тэдний гишүүнчлэлийн орлогоор санхүүждэг Хэрэглэгчийн тогтмол судалгааг хийж эхэлжээ. Хэрэглэгчийн судалгаа нь асуулгын анкет, үйл явдлын товчоонд суурилсан бөгөөд гол төлөв телевиз үзэгч, мөн радио сонсогч болон сонин уншигчдын төлөв байдлын талаар баримтаар сар тутам түвшинг /рейтинг/ тодорхойлдог. Судалгаагаар Улаанбаатар хотын телевиз үзэгчдийн байдлыг нарийвчлан гаргадаг төдийгүй, саяхнаас бусад хот суурийн газрынхыг хамруулах болжээ.

Нийслэлд телевиз хэвлэл мэдээллийн чухал хэрэгсэл болж байна. Хүн амын олонх нь өдөр бүр телевиз үздэг, өмнө өгүүлснээр кабелийн телевиз өргөн нэвтэрчээ. Орон даяар нэвтрүүлгээ цацдаг таван телевиз, түүнчлэн “Ийгл” телевиз, ТВ 8 телевизийн нэвтрүүлэг долоо хоногт үзэгчдийн 75-90 хувийг эзэлдэг бол, С1, ТМ ТВ, STV зэрэг шинээр байгуулагдсан зарим телевизийн нэвтрүүлэг долоо хоногт үзэгчдийн 50 хувьд хүрдэг. Оргил цаг нь оройн 8-11 цаг ч, өглөөний 10 цагаас эхлээд өдрийн турш бас л олон хүн телевиз үздэг. Ажилгүйдлийн түвшин өндөр тул олон хүн гэртээ өнждөг нь үүнд нөлөөлдөг байж болох юм.

Орон даяар өргөн нэвтрүүлгээ дамжуулдаг, үндэсний таван телевиз, “Ийгл” телевиз, үзэгчдийн тоо нь бага ч STV, ТВ 8, С1, ТМ ТВ-ийг хүмүүс тогтмол үздэг байна. Ийгл телевизийн бүх хэлбэрийн мэдээ долоо хоног бүр тэргүүн байр эзэлж байсан бол үндэсний телевизүүдийн оройн мэдээний гол хөтөлбөрүүд хамгийн өндөр үнэлгээ авсан байна. “Ийгл” телевиз мэдээгээрээ тэргүүлж байгаа бол үндэсний таван телевиз, ТВ8-ын мэдээ, улс төрийн асуудал, боловсрол, мэдээллийн нэвтрүүлэг, цэнгээнт, хөгжмийн гэх мэт янз бүрийн нэвтрүүлэг нь өндөр үнэлгээ авчээ. 25-р суваг, UBS, STV, С1 зэрэг телевиз цэнгээнт, хөгжмийн нэвтрүүлгээр дээгүүр байрт оржээ.

Телевизүүдийн өөрсдөө үйлдвэрлэсэн нэвтрүүлгүүд хамгийн алдартай нэвтрүүлэг, төдийгүй заримдаа Солонгосын кино, телевизийн цувралууд өндөр үнэлгээ авдаг байна. Хэдийгээр үзэгчид сансрын сувгаар

орос, хятад, япон, өрнөдийн телевизийн өргөн нэвтрүүлгийг кабелийн сувгаар хүлээн авах өргөн боломжтой ч, нутгийн ихэнх хэсэгт монгол хэлээр нэвтрүүлэг бэлтгэж цацдаг дотоодын телевизүүд хамгийн алдартай ажээ.

Аймгууд дахь телевиз үзэгчдийн төлөв байдалд хараахан судалгаа хийгээгүй байна. Цөөн тооны малчин, сум, аймгийн төвийнхнөөс тохиолдлоор ярилцлага авахад хүртээмжээс үүдэн МҮОНТ хөдөө орон нутагт тэргүүлэх байр суурьтай байна. Хүлээж авах дамжуулах станцтай аймгийн төв, сумдад ТВ5, ТВ9, UBS, 25-р суваг телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах боломжтой юм. Энэ дөрвөн телевиз өргөн нэвтрүүлгийн хоёр сувгийг хуваан ашиглаж өргөн нэвтрүүлгээ солбиж үзүүлдэг.

Малчдын судалгаанд Өвөр Монголын өөртөө засах орны телевизийн тухай тогтмол дурдагдсан бол казах үндэстэн олноор төвлөрөн суудаг баруун аймгуудад казах, турк, орос, мөн хятадын телевиз олон үзэгчтэй байна. Нийслэл Улаанбаатар хотоос шууд зам харилцаагүй, хэдэн мянган километрийн зайд оршин суудаг үндэстний цөөнх нь мэдээллийн онцгой хэлбэрийн хомсдолд ороод байна. Технологийн хоцрогдол, орон нутгийн засаг захиргааны цензур /цагдан хяналт/, үндэстний цөөнхийн өөрсөдтэй нь хил залгаа Орос, Хятад, Казахстанас телевизийн нэвтрүүлгийг хиймэл дагуулаар хүлээн авдаг зэрэг нь улс орны хөгжлийн тухай зохих мэдээллийг эх хэлээрээ хүлээн авч чадахгүйд хүргэж байна.

2.2.5 Өмчлөл

Хэвлэл мэдээлийн өмчлөгчийн тухайд гэвэл, байдал ил тод бус. ХМХ-ийн жинхэнэ эзнийг тогтоох хэцүү. Улс төр, томоохон бизнес эрхлэгчид өөрсдийн сонирхлыг тулгахын тулд хамтран үе үе ХМХ-д хөрөнгө оруулахаас биш ХМХ-ийг бизнесийн утгаар нь хөгжүүлэх хүсэл хоёрдугаарт байдаг.

Үүний зэрэгцээ, ард талд нь амин хувийн янз бүрийн ашиг сонирхол бүхий хувийн эзэмшлийн телевизүүд байгуулагдаж байна. ТВ5, ТВ9 телевизийн нэвтрүүлгийн бодлогоос МАХН-тай холбоотой нь мэдрэгддэг. Албан ёсоор ТВ9 телевизийг “Медиа Холдинг” компани эзэмшдэг гэх боловч одоогийн ерөнхийлөгч тус сувгийг эзэмшдэг тухай мэдээ бий. ТВ5 телевизийг албан ёсоор хувийн хөрөнгө оруулагчид эзэмшдэг гэдэг ч МАХН-ын томоохон улс төрчид, уул уурхайн компанитай ойр дотно хэмээх ажээ. Шинээр байгуулагдсан, санхүүжилт сайтай С1 гэхэд Женко группт харьяалагддаг. Тус группын ерөнхийлөгч нь УИХ-ын гишүүн. 25-р суваг телевиз нь Монголын хэвлэл мэдээллийн хамгийн хүчирхэг группийн нэг болох Монгол Ньюс группт харьяалагддаг. Тус групп нь өдөр тутмын

хамгийн нэртэй сонины нэг “Өнөөдөр” сониныг, мөн эзэмшдэг байна. Тус группыг МАХН-ын нэг жигүүртэй холбоотой гэдэг.

Ийгл телевизийг Америкийн Амонг шашны сан эзэмшдэг. Хөгжиж буй орнуудад христийн шашны ухуулга сурталчилгааг хөхиүлэн дэмжихээс гадна “Амонг” сан нь Америкийн хэт баруунтны бодлогыг дэмждэг байна. Ийгл телевизийг анх Монгол түнштэй хамтран байгуулсан ч үл ойлголцлын улмаас 2004 онд хаажээ. Гадаадынхан дангаараа эзэмшдэг “Ийгл” телевиз 2005 онд үйл ажиллагаагаа дахин эхэлсэн байна. “Ийгл” телевиз АНУ-ын одоогийн засгийн газар, Монгол дахь Америкийн элчин сайдын яамтай сайн харилцаатай болохоор тус телевиз улс төрийн зөрчил бүхий маргаан, хэд хэдэн ярвигтай асуудалд орооцолдсон ч хөөгдөлгүй үлдэж байжээ. Христийн шашны дэмжлэгээр ажиллаж, түүнийг сурталчилдагт нь зарим хүмүүс эгдүүцэж, телевизийг эзэмшигчийн ил тод бодлогод өнөө хир сэжиглэнгүй ханддаг.

Орон нутаг дахь олон телевиз аймгийн захиргааны мэдээллийн төвийн суурин дээр байгуулагджээ. Зарим телевиз өнөө хир аймгийн захиргааны мэдэлд байгаа бол, 1998 онд баталсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар төрийн байгууллага өөрийн мэдэлд ХМХ өмчлөхийг хориглосны дараа ажиллагсад хувиараа телевизээ дахин ажиллуулж эхэлсэн байна. Эдгээр телевиз өнөө хэр захиргааны байранд, ихэвчлэн төрийн хүчтэй нөлөөн дор хуучных шигээ ажиллаж байна. Үүний зэрэгцээ, хувийн хэд хэдэн телевиз байгуулагдсаны заримыг тухайн орон нутаг дахь САТВ-кабелийн телевизийн компанитай хувь хүмүүс өмчилж, ФМ станцуудыг улс төрийн нам, бизнес эрхлэгчид байгуулсан байна. Орон нутгийн цөөн хэдэн телевиз л улс төр, хувийн ашиг сонирхлыг урьтал болгохгүй ХМХ-ээ бизнесийн утгаар нь ажиллуулж байгаа ч, судалгаанд оролцсон олон хүн үүний эсрэг саналтай байв.

2.2.6 Орлогын загвар

Хэвлэл мэдээллийн бизнесийн орлогын эх үүсвэрийн талаар найдвартай тоо баримт байхгүй. Тухайлбал зар сурталчилгаа, сонины борлуулалт, кабелийн захиалга, төлбөртэй утас зэргийн орлогын хэмжээ тодорхойгүй байна. Төлбөрт материал, хээл хахуулийн талаар ч гэсэн тодорхой тоо баримт алга. Өмнө дурдсанчлан нөлөө бүхий ихэнх телевизүүд ХМХ-ийг бизнесийн утгаар ажиллуулж, ашиг олохоос илүү улс төрийн ашиг сонирхлоо урьтал болгодог тул телевизийн бизнесийн санхүүгийн байдлыг үнэлж, дүгнэхэд төвөгтэй юм.

Гэсэн хэдий ч ахуйн хэрэглээний бараа борлуулдаг олон улсын компани, мэдээлэл харилцаа холбооны компани, банкууд зар сурталчилгаанд их мөнгө зарцуулах болсны дүнд нийслэлийн зар сурталчилгааны зах зээл сүүлийн үед эрч хүчээ авч байна.

Сурталчлуулагчид өнөө хир хэвлэл мэдээллийн төлөвлөлтийн талаар бага ойлголттой, зорилтот бүлэг, зах зээлийн хуваарилалтыг огт харгалзалгүй зар сурталчилгаагаа байршуулдаг. Үүний оронд бизнес стратеги, улс төрийн хэлхээ холбоо, хувийн харилцаа, хямд үнэ, хамгийн доод үнээр мэдээний агуулга, нэвтрүүлгийн цагийг худалдан авах боломжид анхаарлаа хандуулдаг.

Үүнтэй адил, телевизийн мэргэжилтний олонх нь хэвлэл мэдээллийн менежментийн ур чадвар дутмаг, нэвтрүүлгийн төлөвлөгөө, сүлжээ боловсруулах, үйлдвэрлэлтэй холбоотой шийдвэр гаргахдаа үзэгчийн судалгааг өргөн ашигладаггүй байна. Энэ нь нэг талаар урьд өмнө ийм шаардлага байгаагүй, зарим талаар эдгээр арга хэрэгсэл үзэгчийн урсгал, үзэгчийн үнэнч байдал бий болгоход ач холбогдолтойг ойлгоогүйтэй холбоотой юм.

Нөгөө талаас, өрсөлдөөн нэмэгдэж, хүрэх арга хэрэгслийг мэргэжлийн түвшинд ойлгох шаардлага чинээлэг сурталчлуулагчдын хувьд гарч байна. Үүний зэрэгцээ үзэгчийн анхаарлыг татах өрсөлдөөн нь мөн л улс төрийн асуудлын нэг аж. Улс төрийн ашиг сонирхлоор байгуулагдсан телевизийг зөвхөн зорилтот үзэгчиддээ хүрэхийн тулд ашигладаг. Хэрэв энэ зорилгоо биелүүлэхэд телевиз үйлчилж чадахгүй бол хэвлэл мэдээллийн эзэд ч зохих өөрчлөлт хийнэ.

Саяхан гэхэд, “Ийгл” телевиз ХМХ-ийн үзэгчдийн судалгааг ашиглан хотод тэдний мэдээг хамгийн олон хүн үздэг хэмээн өргөн сурталчилсны дараа телевизүүдийн дунд маргаан дэгджээ. Үзэгчдийн тоо, нөлөөгөө алдахаас эмээн ТВ9 телевиз тэр даруй судалгааны дүнг эсэргүүцсэн байна. Энэ маргааны дараа хэд хэдэн телевиз, хувийн аж ахуйн нэгж хэвлэл мэдээллийн судалгаа, рейтинг тогтоох байгууллага байгуулах сонирхлоо илэрхийлжээ.

2.3 Радио

2.3.1 Тойм

Монголын Хэвлэл мэдээллийн мониторингийн 2005 тайланд дурдсанаар Монголд 58 радио байна. Үүнээс Улаанбаатарт 20 радио, орон нутагт 37 нь ажиллаж байв. Гэхдээ ФМ станцын тоо жилээс жилд хурдацтай нэмэгдэж буй учир энэ тоог өчүүхэн хэсэг гэж үзэх хэрэгтэй.

Сүүлийн хэдхэн жил шинээр олон ФМ радио байгуулагджээ. 2005 оны байдлаар зөвхөн Улаанбаатарт л гэхэд зургаа, орон нутагт 10 ФМ радио шинээр байгуулагдсан. 2006 оны тайлангаар өнгөрсөн 12 сард үүнээс ч олон ФМ радио байгуулагдсан тоо гарах байх, аймгийн төвүүдэд хоёроос таван ФМ радио байна.

Засгийн газар хувь хүмүүст лиценз олгож эхэлснээр радиогийн зах зээл үлэмж нэмэгдсэн байна. Лицензийн төлбөрийн хэмжээ бага (ойролцоогоор жилд 1500 доллар), түүнчлэн технологийн дэвшлийн дүнд радио станц суурилуулах нь урьдынхаас илүү хямд, хялбар болсон тул радио станцын тоо ийнхүү өсөхөд нөлөөлжээ. FM радио байгуулахад 5000 доллар шаардлагатай. Орлогын бялууг илүү жижиг хэсэгт хувааж, тоо нь нэмэгдсээр байгаа тул хуучин болон шинэ радио оршин тогтноход төвөгтэй болж байна.

1934 онд байгуулагдсан Монголын Үндэсний Олон Нийтийн Радио /МҮОНР/ нь 2006 оны 1-р сард өөрчлөн байгуулагдаж олон нийтийнх болсон. Хөдөөд МҮОНР-г орон нутагт малчид голдуу сонсдог бол, хот суурин газар FM радиог илүү их сонсдог байна.

МҮОНР орон нутгийн мэдээг орон даяар дамжуулдаг. Зарим бүс нутагт МҮОНР эфирийн цагаа долоо хоногт нэг эсвэл хоёр удаа дээд тал нь 30 минутаар орон нутгийн радио, сэтгүүлчдэд түрээсэлдэг. Баруун аймагт бүсийн олон нийтийн радиогоор долоо хоногт хоёр удаа нэвтрүүлгээ дамжуулдаг.

Тандем TTVS-ийн аймгууд дахь олон нийтийн, хувийн, хэсэг бүлгийн /коммунит/ радиогийн техникийн байдалд хийсэн 2005 оны дүгнэлтдээ: “Чанаргүй, өргөн нэвтрүүлгийн хоцрогдсон тоног төхөөрөмж, цахилгаан соронзоны зохих гэрчилгээгүй дамжуулах станцууд, цахилгаан тасалддаг зэрэг бэрхшээл алслагдсан нутагт суугаа үндэстний цөөнхөд учирч байна. Аймгийн төвүүдэд ихэвчлэн долгионы давтамжийг үр дүнгүй ашиглах, шуугианы түвшин өндөр, өргөн нэвтрүүлэгт хөндлөнгийн нөлөө их гэх мэт дутагдал байна. Хөндлөнгийн цогц шалгалт хийсэн тохиолдолд дээрх бүх нөхцөл байдлын улмаас радиог хаах, лицензийг нь хураахад хүрнэ” гэжээ.

2.3.2 Агуулга

Монголын Хэвлэл Мэдээллийн Мониторингийн 2005 оны тайланд дурдсанаар төрийн мэдлийн үндэсний радио нь мэдээ, нийгэм, улс төрийн асуудал, хөгжим, соёл, баримтат нэвтрүүлэг, зар сурталчилгаа зэрэг холимог төрөл жанраар бэлтгэсэн нэвтрүүлэг цацдаг байна. Төрийн мэдлийн радио дахь хоёр FM сувгаар Улаанбаатар, төвийн аймгуудад өргөн нэвтрүүлгээ дамжуулдаг. Энэ сувгаар гол төлөв боловсролын, цэнгээнт өргөн нэвтрүүлэг дамжуулдаг.

МҮОНР-ийн сувгаар далимдуулан аймагт бүсийн радио нь орон нутгийн, бүсийн мэдээ, бараа бүтээгдэхүүний үнэ ханш, алдагдсан малын зар, хөгжим, засаг захиргааны мэдээ /гол төлөв төлбөртэй байдаг/, зэргийг дамжуулдаг байна.

Улаанбаатар хотод ажилладаг ихэнх ФМ радио мэдээ, шууд ярилцлага, боловсрол, цэнгээнт нэвтрүүлэг, зар сурталчилгаа болон хөгжим зэрэг янз бүрийн нэвтрүүлэг цацдаг. Гэсэн хэдий ч хуучин байсан, мөн шинээр байгуулагдсан зарим радио ямар нэг тусгай бэлтгэсэн нэвтрүүлэггүй, зөвхөн хөгжим, зар сурталчилгаа дамжуулдаг байна. Зарим ФМ радио нь сайн тоноглогдсон, сайн боловсон хүчинтэй байдаг. Гэхдээ ихэнх ФМ станцыг “унтлагын өрөө” эсвэл автомат хөгжим гэж дүрсэлж болно. Нэг юм уу, хоёр өрөөнд байрлах ФМ радиод залуу хөтлөгчид байгаа эсэхийг шалган ажилладаг байна. Орон нутгийн ФМ радиог эрээвэр хураавар гэж хэлж болно. Тэдний ихэнх нь хөгжим, утсаар хүлээж авдаг зар, зар сурталчилгаа явуулдаг. Хэд хэдэн ФМ радио өгүүллэг унших, /өглөөгүүр хүүхдэд зориулсан үлгэр ярих/, асуулт хариулт, бага төсвөөр орон нутгийн зарим асуудал хөндсөн нэвтрүүлэг дамжуулдаг байна. Орон нутгийн зарим радио голдуу интернэтээс татаж авсан улс орны мэдээ, орон нутгийн мэдээ, мөн засаг захиргааны ажлын тухай төлбөрт мэдээ нэвтрүүлнэ. Төлбөрт нэвтрүүлэг телевизтэй харьцуулахад түгээмэл бус. ФМ радионууд ихэвчлэн хэт туйлширсан, улс төржсөн хэвлэл мэдээллийн орчинд татагдаж орохоос зайлсхийдэг. Учир нь улс төрчид ФМ радиог залуучуудад чиглэсэн нэвтрүүлэг явуулдаг, үгүйдээ сонгуулиудын хооронд улс төрөөс хөндий гэж үздэг ажээ.

Үүний зэрэгцээ ЮНЕСКО, түүнчлэн АНУ-ын Азийн сан, Нээлттэй Нийгэм Форум зэрэг ТББ-ууд байгаль орчин, авилга гэх мэт, зах зээлийн бараа бүтээгдэхүүний тухай мэдээлэл зэрэг нийгмийн асуудлаар нэвтрүүлэг бэлтгэхэд нь орон нутгийн радиотай хамтран ажиллаж байна.

2.3.3 Сонсогчид

Хөдөө орон нутгийн сонсогчдын талаар баталгаатай мэдээ баримт байдаггүй бөгөөд ФМ радио нь залуус хоорондын харилцаа, холбоонд зориулсан шинэ байгууллага болохыг хөдөөгийн сонсогч, ФМ радиогийн хөтлөгчдийн ярианаас олж мэдсэн юм. Залуу хөтлөгчид дөнгөж сургууль төгссөн, сургалтанд тэр бүр хамрагдаагүй байдаг ч, сонсогчдынхоо сонирхол, дуртай, дургүй зүйлийг нь мэдэрч нэвтрүүлгээ бэлтгэдэг. Нэвтрүүлэг нь улс төрийн өнгө аясгүй, Монголын тал нутгийн жижиг хотын хүүхдүүдэд хүрэх боломжтой, тэдэнд орчин үеийн ертөнцийн тухай цухас мэдээлэл өгдөг байна.

Залуу хөтлөгчдөд сургалт дутагдаж, ФМ станцууд санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг тодорхой тооны ФМ-үүдэд мөн ийм бэрхшээл тулгардаг ч, энд тогтвортой ажиллаж, санхүүгийн хувьд бэхжсэн ФМ радио ч бий. Сансрын телевиз хүлээн авах боломжгүй, нүүдлийн амьдралтай малчид зөвхөн радио сонсох боломжтой тул МҮОНР алслагдсан нутагт чухал үүрэг гүйцэтгэж байна.

Тавган антен, сансрын телевизээ орхисон өвөлжөөндөө буухаас нь өмнө судалгааны баг өнгөрсөн зун малчдаас ярилцлага авахад “радио мэдээллийн гол эх үүсвэр” гэж тэд хариулж байв. Малчид малын өвс, бэлчээрийн гарцад нэмэрлэх бороо орох эсэх тухай мэдээлдэг цаг агаарын дэлгэрэнгүй мэдээг хамгийн их сонирхдог байна.

2.3.4 Өмчлөл

Телевизтэй адилхан радио станцын өмчлөл мөн л ил тод бус байна. Ихэвчлэн хязгаарлагдмал хүрээнд хүмүүст хүрдэг учраас ФМ радио телевиз, сонин шиг улс төрийн нөлөөнд автдаггүй.

Гэсэн хэдий ч, 2004 оны сонгуулийн өмнө МАХН “улс төрийн машин” болгон ашиглах зорилгоор олон ФМ радио байгуулжээ. Сонгуулийн дараа улс төрийн дэмжлэг зогсч, ФМ радио шинэ удирдлагатайгаа оршин тогтнож чадах эсэхээ мэдэхгүй үлдэв. Гэвч анхны эзэмшигч нь лицензийг эзэмшсэн хэвээр тул жинхэнэ хараат бус эсэх нь ирэх сонгуулийн үеэр л тодорхой болно.

Үүний зэрэгцээ, орон нутгийн хэд хэдэн ФМ радио олон улсын зээл тусламж, Нээлттэй Нийгэм Форум, АНУ-ын ОУ-ын хөгжлийн агентлагийн хэрэгжүүлж буй “Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага” төслөөс санхүүжиж байжээ. Хямд зардлаар олон нийтэд мэдээлэл харилцааны үйлчилгээ үзүүлэх боломжтой гэж үзэн дээрх ТББ ФМ радиогийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан юм.

Эдгээр ФМ радиогийн ихэнх нь анхандаа янз бүрийн газраас санхүүжилт авч байсан байна. ФМ станцууд татаас авсны дараа ихэнхдээ туйлын хүнд байдаг санхүүгийн хувьд тогворжино гэж тэд найдаж байсан. ФМ станцын эзэмшигчид тухайн орон нутагт өөрсдийнх нь радиогийн гүйцэтгэж байгаа үүрэгт сэтгэл хангалуун ч, хэрэглэгчийн хэрэгцээг хангахад тэдэнд бэрхшээл тулгарч байна. Тэд өөрсдөө хагас цагийн өөр ажил хайхад хүрч, бага зэргийн, эсвэл огт туршлагагүй залуучуудыг хөтлөгчөөр авч ажиллуулдаг ажээ.

2.3.5 Орлогын загвар

ФМ радиогийн санхүүгийн эх үүсвэр төлбөртэй нэвтрүүлэг, зар сурталчилгаа, зарлал, утсаар шууд холбогдсоны орлого зэрэг дөрвөн хэсгээс бүрдэж байна. Телевизтэй холбон өгүүлсэнчлэн, Улаанбаатар хотын зар сурталчилгааны зах зээл эрчтэй хөгжиж байна. Радиод зар сурталчилгааны зардлыг илүү зориулдаг байна. Улам олширч буй ФМ радиогийн олонх нь бусдын хийснийг шууд дуурайдаг радионууд байдаг. Санхүүжилтийн бялуунаас хүртдэг. Энэ нь зар сурталчилгааны үнийг бууруулдаг үнийн дайнаас үүдэлтэй.

Аймгуудад зар сурталчилгааны зах зээл төдийлөн боловсронгуй бус, ач холбогдол багатай байна. Орлогын гол эх үүсвэр нь шууд утасны, зарлал ажээ. Хэдэн жилийн өмнө анхны хувийн ФМ радио яаж ийгээд амиа аргацааж байв. ФМ радионууд /телевизүүд ч гэсэн/ утасны систем ашигласны төлөө Харилцаа холбооны компанид сар бүр төлбөр төлдөг. Мөн төлбөртэй холбогдсон орлогын нэлээн хэсгийг хувааж авдаг. Телефон харилцаа холбооны компани шимтгэлийн төлбөрийг тогтоодог практик нийтлэг хэдий ч, энэ төлбөр нь их өндөр тул радионууд хүчээ нэгтгэж үнийг тохиролцох хэрэгтэй.

Олон улсын байгууллагуудтай ойр ажилладаг зарим ФМ радиогийн хүмүүсийн ярьснаар олон улсын байгууллагаас ХМХ-үүдэд дэмжлэг үзүүлдэг нь урт хугацаанд санхүүгийн хувьд бие дааж, нэвтрүүлгийн агуулгын чанарыг дээшлүүлэхэд тусалдаг аж. Үүний зэрэгцээ ийм нэвтрүүлгүүдээ хоорондоо солилцож ашиглах нь чанартай нэвтрүүлгийг илүү олон хүнд хүргэж, тухайн радио станцын зардлыг бууруулахад ч тустай ажээ. Шинээр байгуулагдсан Хөдөөгийн радиогийн холбооны гишүүд аль хэдийнэ нэвтрүүлгээ солилцож эхэлсэн нь радио станцуудын санхүүгийн хувьд тогтвортой байдлыг хангахад чухал алхам болох юм.

2.4 Сонин хэвлэл

2.4.1 Тойм

2005 онд өдөр тутмын сонин зургаагаас найм, долоо хоногт хоёр удаа гардаг сонин гурваас дөрөв болон нэмэгджээ. Жилдээ долоо хоног тутмын 29, сард хоёр удаа гардаг сонин 63, сар тутмын 32, тогтмол бус гардаг 19 сонин байна. Үүнээс гадна долоо хоног, сар, улирлын, мөн тогтмол бус гаралттай нийт 68 сэтгүүл байна. Анхаарал татам тоо нь, сонин хэвлэлийн зах зээл олон ургальч үзэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хувьд цэцэглэн хөгжиж байгаа мэт боловч, хэвлэлтийн тоо, чанарын тухайд өөр зүйл яригдана.

Борлуулалтын байдлаар: “Өдрийн сонин” өдөрт /13500/, “Зууны мэдээ” өдөрт /9000/, “Өнөөдөр” өдөрт /8000/ хэвлэгдэн тэргүүн байр эзэлж байна.

Долоо хоног тутмын зарим сонины хэвлэлтийн тоо өндөр байна. “Сэрүүлэг” гэхэд хамгийн их буюу нэг удаа 47500 хувиар хэвлэгддэг аж. Дараагаар нь “Хүмүүс” сонин 42000, мөн бусад гурван сонин нэг удаа 10000-20000 хувь хэвлэгддэг байна. Бусад сонин, сэтгүүл, бүх хэвлэлийн тоо цөөн. Ихэнх тохиолдолд эдгээр нь тусгай сонирхол бүхий сонинууд юм. Хэвлэлийн зах зээл нийслэлийн эргэн тойронд төвлөрсөн хэдий ч, үндэсний сонинууд болон ялангуяа өдөр тутмын бус сонин Монгол даяар өргөн тараагддаг.

Ихэнх аймаг нэгээс хоёр сонинтой. 2005 онд орон нутгийн өдөр тутмын 31 сонин, долоо хоногт хоёр удаа гардаг нэг, долоо хоног тутмын

хоёр, сард хоёр, гурав гардаг сонин 22 байв. Хэвлэгдэх тоо нь тав зургаан зуугаас хэтэртэггүй. Хэвлэлтийн тоог нарийвчлан гаргах нь ховор, улирлаас хамааран хэлбэлзэлтэй байдаг. Орон нутгийн ихэнх сонинг Улаанбаатарт оршдог “Чөлөөт Хэвлэл сан” хэвлэх үйлдвэрт хэвлэдэг. Үйлдвэрийн хэвлэх сонинны доод хэмжээ нь 500 хувь ажээ.

Үндэстний цөөнх оршин суудаг аймгуудад сонин хэвлэл мөн л эдийн засгийн бэрхшээлтэй, эх хэлээрээ бичиж нийтэлдэг сэтгүүлчид сургалтанд хамрагдаагүй.

2.4.2 Агуулга

Сонины чанар, төрөл хэлбэр нь харилцан адилгүй байна. Өдөр тутмын сонин нь хэмжээний хувьд их том /8-24 нүүрээр А 2-ын сонинны хуудсаар хэвлэгддэг, бичлэгийн зүйлийн хувьд янз бүр, гол төлөв улс төр, нийгэм, санхүү, соёлын асуудал, гэмт хэрэг, олон улсын мэдээ, спорт, эрүүл мэнд, амралт чөлөөт цагийн сэдвээр бичигддэг. Улс төржсөн орчинд сонин хэвлэлийн мэдээ нийтлэл өрөөсгөл. “Өдрийн сонин” сонинг чанартай, улс төрийн хувьд хараат бус гэдэг ч Ардчилсан Намд талтай гэнэ. “Зууны мэдээ” сонин одоогийн Ерөнхийлөгчийг дэмждэг, хараат бус байхыг чармайдаг. “Өнөөдөр” сонин МАХН-ын өөр жигүүрийг дэмждэг гэж үздэг байна.

Хамгийн сайн гэгддэг сонинд хүртэл “бизнес мэдээ” гэгч төлбөрт нийтлэл зонхилдог. Пи-Ар шинжтэй ийм нийтлэлийг сонинууд компани, улс төр, ТББ гээд өөрийгөө сурталчлахыг хүссэн хэнээс ч болов чөлөөтэй хүлээж авдаг байна. Сэтгүүлчид цалин дээрээ нэмж төлбөрт нийтлэл, нэвтрүүлгээс хувь авдаг. Тэргүүлэх өдөр тутмын сонинны сэтгүүлч эхний жилдээ 50-60 ам долларын цалин авдаг ч, “бизнес мэдээ” олж ирвэл, цалин нь хоёроос гурав дахин нэмэгддэг байна. Харин нэртэй, туршлагатай сэтгүүлч зөвхөн “бизнес мэдээ”-нээс сард 400 орчим ам доллар олох боломжтой. Эх бэлтгэлээс харахад, ихэнх сонинны тухайн нийтлэл хараат бус материал, эсвэл бизнес мэдээ болох нь үл ялгарна.

Ийм шалтгаанаар нийгэм, эдийн засаг, улс төрийн мэдээ сурвалжлага шударга үнэн зөв байх нь ховор. Олон сэтгүүлч ёс зүйн хэм хэмжээгээ умартан өөрийн санхүүгийн байдлыг сайжруулахын тулд улс төр, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэхэд бэлэн байдаг ажээ. Улс төрийн хавчлага, редакцийн бодлого, эх сурвалжийн хомсдол, мэргэжлийн ур чадвар сул зэргээс үүдэн сайн судалгаатай, эрэн сурвалжилсан сэтгүүл зүйн материал ховор гардаг.

Орон нутгийн сонинуудын агуулгын хувьд ч байдал түвэгтэй. Зарим нь засаг захиргааны мэдээ, зарлал нийтлэлтэй мэдээллийн тараах материалаас арай дөнгүүр. Гэсэн хэдий ч, орон нутгийн зарим сонинд албан ёсны мэдээллээс гадна, нийгмийн асуудал, өдөр тутмын амьдрал, улс төрийн хов жив, эмгэнэл, тэмдэглэлт ой, зарлал, зар сурталчилгаа,

ярилцлага, улс төрч, алдартай тамирчин, бизнес эрхлэгчийн хөрөг, цаг үеийн тулгамдсан асуудал, сумын мэдээ, зарлал гэх мэтчилэн янз бүрийн материал нийтлэгддэг байна. Орон нутгийн сонинг ихэвчлэн нэгээс хоёр хүн эрхлэн гаргадаг, эзэн нь өөрөө сэтгүүлч, захиргааны, сурталчилгааны ажилтан зэрэг давхар үүрэг гүйцэтгэдэг байна. Эрдэнэт, Дархан гэх мэт хот суурин газар цөөн сонин илүү олон орон тоотой, илүү чадвартай ажиллагсадтай ажээ.

Дээр дурдсанчлан урд хормойгоо авч хойд хормойгоо нөхөхийн тулд аймгийн сонинууд төлбөрт нийтлэл түлхүү хэвлэх хандлагатай аж. Ихэнх тохиолдолд сонинууд аймгийн засаг захиргаа, бизнес эрхлэгч, улс төрийн нам гэх мэт ашиг хонжоо хайгчдын оруулдаг орлогоос санхүүгийн хамааралтай байдаг. Учир нь сонин захиалга, зар сурталчилгаанаас тухайн сонин оршин тогтнох хангалттай орлого бүрдүүлэх нь ховор. Гудамжны гэрэл хагарсан, зам дээрх нүхийг бөглөөгүй зэрэг иргэдийн гомдлоос илүү, засаг захиргааны амлалтыг чухалчилдаг сонин ч бас цөөн тоогоор байна. Аймгийн ихэнх сонин ашиглаж болох орлогын урсгалын хувьд ЗДТГ-ын төлбөрт мэдээ авдаг ажээ. Амьдралд хэрэгжихүйц орлого олох загвар үгүйгээс сонголт бага учир орон нутгийн сэтгүүлчид аймгийн засаг захиргаанаас хараат байхыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Үүнийг онцгой тохиолдол гэж хэлж болох ч, улс төр санхүүгийн өнөөгийн бэрхшээлийг сөрөн улс төрийн асуудал, аймгийн төсөв, тендерийн будлиан, эмнэлгийн муу үйлчилгээний тухай бичиж нийтэлдэг сэтгүүлчдийн мэдээлэл олж авах боломж хязгаарлагдмал, байнгын дарамт шахалтанд өртдөг ажээ.

2.4.3 Захиалга, Уншигч

МХХ-гээс сар тутам гаргадаг хэрэглэгчдийн судалгаанаас өөр сонин хэвлэлтийн тоо, уншигчдын байдалд хөндлөнгөөс хийсэн судалгаа байдаггүй. Хэвлэлтийн тоог сонинууд өөрсдөө гаргадаг, МХХ-ийн 2005 оны судалгаагаар Улаанбаатар хотын хүн амын 19 хувь нь өдөр бүр, 53 хувь нь хааяа сонин уншдаг, 28 хувь нь огт сонин уншдаггүй ажээ. Тэдний 91 хувь нь телевизийг, 29 хувь нь сонинг мэдээллийн гол эх үүсвэр гэжээ. 2005 онд хамгийн их уншсан өдөр тутмын сонин нь “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, дараа нь “Хүмүүс”, “Сэрүүлэг” зэрэг өдөр тутмын бус сонин, үүний дараа өдөр тутмын “Зууны мэдээ” сонин орсон байна.

Өдөр тутмын сонинуудын 90 гаруй хувь, долоо хоног тутмын сонин гуравны хоёр нь хувийг захиалгаар нийлүүлдэг. Өдөр тутмын бус сонин хотод ч, хөдөө ч түгээмэл дэлгэрсэн байна. Сум, аймгийн төвд суудаг айл өрх өдөр тутмын сонин бус сонин захиалдаг, мөн өнгөрсөн үеийнхтэй адил орон нутгийн сонингоо захиалах бодолтой байдаг гэсэн юм. Урьд өмнө сонин мэдээллийн цорын ганц эх сурвалж байсан хэдий ч одоо орон нутгийн сонин чанар ерөнхийдөө тааруу тул нутгийн хүн амын сонирхлыг олигтой татахгүй байгаад гайхах зүйлгүй. Ийм ч учраас орон нутгийн сонин хэвлэгдэх тоо бага байна.

Зарим өдөр тутмын бус сонин харьцангуй өндөр захиалгатай байгаад сугалаа их түлхэц болдог байна. “Сонин захиалаад машин хож” гэх жишээтэй. Үүний зэрэгцээ сугалааг хулхи гэж ярилцдаг ч, энэ нь хараахан нотлогдоогүй байна.

2.4.4 Сонин хэвлэлийн өмчлөл, хэвлэл мэдээллийн төвлөрөл

Хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийн адил өдөр тутмын сонинуудын өмчлөл ил тод бус. “Өдрийн сонин” сонинг “Өдрийн мэдээ” ХХК өмчилдөг боловч Ардчилсан /АН/ намын аж ахуйн нэгж гэгддэг. “Өнөөдөр” сонин өмнө дурдсанчлан, “Монгол Ньюс” ХХК-ны өмчлөлд байдаг. “Зууны мэдээ” сонин өмчлөл ил бус, гэхдээ Ерөнхийлөгчийн гэргий хэсэгчлэн өмчилдөг гэсэн цуу яриа байдаг. “Монголын мэдээ” сонин эзэн УИХ-ын гишүүн, “Үнэн” бол МАХН-ынх, “Улаанбаатар Таймс” сонин Улаанбаатар хотын захиргааны мэдэлд байдаг ажээ. “Өнөөдрийн Монгол” шинэ хувийн сонин Ерөнхийлөгчийг дэмждэг бол хамгийн сүүлд гарсан сонин нэг болох “Ардын эрх”-ийн ард “Голомт” банк байдаг гэнэ. Аймгийн сонинуудын өмчлөлийг гол дөрвөн ангилалд хувааж болно.

1998 оноос хойш орон нутгийн засаг захиргаа хэвлэл мэдээлэл өмчлөхийг хориглосон ч зарим сонин аймгийн засаг захиргааны мэдэлд хэвээр байна. Зарим аймагт төрийн мэдэлд байсан сонинг эрхлэгч нь авсан, эсвэл Засаг даргын ивээл дор дахин гаргаж эхэлсэн, санхүүгийн хувьд төрөөс хамааралтай тул хяналтад нь байдаг ажээ.

Зарим сонин МАХН эсвэл АН, эсвэл намуудтай ойр хэлхээ холбоотой хүмүүсийн өмчлөлд байна. Зарим сонинг эрхлэгч нь, эсвэл орон нутгийн бизнес эрхлэгч хувьдаа эзэмших болсон.

Эцэст нь дурдахад “Эгэл” ХХК улс даяар орон нутгийн есөн сонинг эзэмшдэг. “Эгэл” ХХК Эрдэнэт дэх сониноо эрхлэн гаргадаг, үүний сацуу бусад найман сонинхоо санхүү, редакцийн бодлоготой ямар холбоотой нь тодорхойгүй. “Эгэл” ХХК эдгээр сонинг хэвлэх бүх зөвшөөрлийг хянадаг, сургалт, семинар зохион байгуулдаг. Зарим тохиолдолд “Эгэл” ХХК тухайн сонинд байгуулахад нь тусалж тоног төхөөрөмжөөр хангасан ажээ. “Эгэл” ХХК-ийн эзэн үүний цаана, “хөдөөд, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэх гэсэн сайхан сэтгэлээс өөр юм байхгүй” гэж баталж байв. “Эгэл” ХХК-д санхүүгийн ашиг сонирхол байсан гэж төсөөлөхөд бэрх боловч сүлжээ бол сонгуулийн сурталчилгаанд улс төрийн чухал хэрэгсэл болох боломжтой. Тэгэхээр “Эгэл” ХХК-ий сонинууд улс төрийн янз бүрийн хэлхээ холбоотой болж таарах нь.

2.4.5 Хэвлэл мэдээллийн өмчлөлийн төвлөрөл

2005 оны Монголын хэвлэл мэдээллийн мониторинг – тайлангаас харахад хэвлэл мэдээллийн 28 өмчлөгч нэгээс дээш тооны ХМХ эзэмшиж байна. ХМХ-ийн томоохон өмчлөгчдийн дотор: 25-р дугаар суваг, өдөр тутмын хамгийн том сонин нэгийг, гурван жижиг сонин эзэмшдэг “Монгол Ньюс” ХХК нь, UBS, UBS2 телевизүүд, радио, өдөр тутмын нэг сонин эзэмшдэг. Улаанбаатар хотын захиргаа, “Сэрүүлэг” өдөр тутмын бус сонин, бас нэг сонин, радио өмчилдөг “Таянхан” ХК, зургаан жижиг сонин эзэмшдэг “МОНЦАМЭ” агентлаг багтаж байна.

МОНЦАМЭ бол Монголын анхны үндэсний мэдээллийн агентлаг. Монголын цахилгаан мэдээний /телеграф/ агентлагийн хэлбэрээр 1921 оны 7 дугаар сард байгуулагдсан. Энэ нь Ази, Номхон далайн мэдээллийн агентлагуудын байгууллагын гишүүн бөгөөд Ройтерс, Синхуа, Итар-Тасс, Пренса Латина зэрэг мэдээллийн агентлагтай мэдээ солилцох хамтын ажиллагааны гэрээтэй. 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн “Төр ОНМХ эзэмшихийг хориглоно” гэсэн 4 дүгээр заалтыг зөрчин тус агентлаг төрийн мэдэлд хэвээр байдаг.

Хэвлэл мэдээллийн өмчлөлийн тухай хуулийн зэрэгцээ ХМХ олноор эзэмшигчийн аль нь ч давамгайлах байр суурьгүй тул хэвлэл мэдээллийн өмчлөлийн төвлөрөл нь хэвлэл мэдээллийн олон ургальч байдалд аюул учруулахаар байна. Гэхдээ өмнө дурдсанчлан, өмчлөл ил тод бус байдал, томоохон бизнестэй, цөөн тооны гол улс төрчийг тойрсон өмчлөлийн төвлөрөл өсөх хандлагатай байна.

2.4.6 Түгээлт, Хэвлэлт

Үндэсний сонин хэвлэлийг Монгол даяар өргөн түгээдэг хэдий ч өргөн уудам нутагт хэвлэл эзэндээ хүртлээ хэдэн өдөр болдог ажээ.

Төрийн эзэмшлийн “Монгол шуудан” ХХК нь шуудангийн гол үйлчилгээ үзүүлж Монголын хамгийн алслагдсан газарт ч хүрэх эрхтэй. “Монгол шуудан” ХХК бүх аймаг, сум, багийн 70 хувьд төлөөлөгчтэй. Сонин хэвлэлийг онгоц, галт тэрэг, машин, ачааны машин гээд боломжит бүхий л тээвэрийн хэрэгслээр аймгуудад илгээдэг. Төвийн аймгуудад сонин хэвлэл өдөртөө очдог бол, ихэнх тохиолдолд дөрвөөс зургаа хоногт, алслагдсан аймгуудад үүнээс ч удаан хүрнэ.

Сумаас багт хүрэх нь мэдээж хамгийн хэцүү. Сонин хэвлэл, бусад шууданг эзэнд нь хүргэхийн тулд боломжийн бүх аргыг хэрэглэнэ. Голчлон багийн засаг дарга морь, мотоцикль, машинаар малчдаа эргэхдээ сонин хэвлэлийг нь хүргэж өгнө. Зорчигчдыг ч гуйж сонин хэвлэлийг дайх ч үе бий. Хэрэв Улаанбаатар хотоос тухайн газарт түгээхэд 21 хоногоос дээш хугацаа өнгөрвөл хүрэх боломжгүй газар гэж нэрлэдэг. Дулааны улиралд малчид байнга нүүж, тэдэнд хүрэх нь илүү бэрхшээлтэй тул тэд өөрсдөө сум, багийн

төв рүү ирэхдээ шуудангаа авдаг байна. Ийм илэрхий шалтгаанаар улирлаас хамааран захиалгын тоо буурдаг.

Улаанбаатар, бусад том том хотуудад гар дээрээс, мөн мухлагаар борлуулах нь түгээмэл байдаг бол ихэнх сонин хөдөөд зөвхөн захиалгын үйлчилгээгээр түгээгддэг. Аймгуудад мухлагийн худалдаагаар зөвхөн аймгийн шуудан дээр борлуулдаг, гагцхүү олонд танил болсон сонин хэвлэлийг л худалддаг.

Монгол шуудангийнхны хэлснээр төрийн түгээлтэд зориулан санхүүжилт өгдөггүй. Монгол шуудангийн орлогын 15 хувь зөвхөн сонин хэвлэл түгээлтээс ордог бол тэдний зардлын 80 хувь нь хөдөөд шуудан түгээхэд зарцуулагддаг. Монгол шуудан энэ асуудлыг засгийн газарт тавих бодолтой байгаа, ямар нэг шийдвэр гаргахгүй алслагдсан нутагт шуудан түгээх үйлчилгээ тасалдана, эсвэл үнэ тариф нь нэмэгдэх байх гэж байв.

Монголын хэвлэн нийтлэгчдэд тулгарч буй өөр нэг бэрхшээл нь хэвлэлт ажээ. Монголд коммунизм нуран унахад улс төрийн янз бүрийн сонирхлууд олон нийтэд түгээх мэдээллийг хянах үүднээс хэвлэх үйлдвэрт хязгаарлалт тавихыг хичээсэн байна. Тухайн үед боломжийн үнээр сонин хэвлэх боломж олгох зорилгоор “Чөлөөт хэвлэл хэвлэл сан” /ЧХС/ үйлдвэрийг байгуулжээ. Улаанбаатарын, орон нутгийн хөдөөгийн олон сонин ЧХС хэвлэх үйлдвэрт хэвлэгддэг.

Хэвлэх үйлчилгээ үзүүлдэг үйлдвэрийн тоо нэмэгдсэнээр саяхнаас байдал өөрчлөгдөж байна. Заримдаа ЧХС үйлдвэрээс доогуур үнээр хэвлэж байна. ЧХС хэвлэх үйлдвэрийнхний тайлбарласнаар хувийн хэвлэх үйлдвэрүүд татварын хуулийн дагуу татвар төлдөггүй учир шударга бус өрсөлдөөнөөс давуу байдал олж авч байгаа нь үүний шалтгаан гэнэ.

Хэвлэлтийн зардал, эх бэлтгэл орон нутгийн сонинуудын хувьд санаа зовоож буй гол асуудал нь ажээ. Аймгуудад цөөн тооны хэвлэх үйлдвэр байдаг ч, аль нь ч сонин уламжлалт-хэмжээгээр сонин хэвлэх боломжгүй тул Улаанбаатарт хэвлүүлэхээс өөр аргагүйд хүрдэг. Тэд сонин эх бэлтгэсэн хувийг Улаанбаатарт байдаг хүнд USB флешээр илгээж, хэвлэгдсэн сонинг буцааж явуулна. Энэ нь эрхлэн гаргах хүн нэмэгдэж, сонин ажиллагсдын цаг их зарцуулснаас төсөв үнэтэй тусдаг байна.

Хэвлэх үйлдвэрийн шаардлагаас үүдэн нэг дугаарыг хэвлүүлэх хамгийн доод тоо ширхэг нь 500 хувь. Сонинууд ихэнхдээ үүний тал хувийг борлуулж чаддаггүй. Энэ судалгаанд хамрагдсан нэг сонин үүний оронд сониноо А4-ын цаасан дээр компьютерээс хэвлэж гаргахнаас өөр аргагүй байдалд хүрсэн байна. Сонин гэж харагдахгүй зүйлээр ямар ч зар сурталчилгаа олж чадахгүй гэж ихэнх нь энэ санааг эсэргүүцэж байв. Зарим сонин санхүүжилт татахын тулд А2-ын хэмжээнд шилжиж, өнгөтөөр, том хэвлүүлэх зорилго тавьж байгаа гэнэ.

1000 хувьтай сонины нэг дугаарын төсөв ойролцоогоор 150000-200000 орчим төгрөг ажээ. Нэг дугаараас 250000-300000 төгрөгийн орлого олвол сонин ашигтай ажиллана гэнэ. Шуудан тээврийн зардлыг оруулалгүйгээр, 500 хувь сонин хэвлэх зардал 100000 төгрөг байдаг.

2.4.7. Орлогын загвар

Хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийн нэгэн адил сонин хэвлэлийн орлого нь зар сурталчилгаа, захиалга, тодорхой шалтгаанаар “төлбөрт” нийтлэлийн хувьд ил тод бус байна. Захиалгынх нь тоо тааруухан ч өдөр тутмын, хамгийн том гурван сонин, долоо хоног тутмын таван том сонин нь захиалга, сурталчилгаанаас орлогын зонхилох хэсэг, төлбөрт “бизнес мэдээ”-ээс нэлээд хувийг олдог. Цалин, үйлдвэрлэлийн зардал нэлээн доогуур учир эдгээр сонин өөрсдөө ашигтай ажиллаж болох талтай ч засгийн газар, улс төрийн сонирхлын бүлгээс шууд бус дэмжлэг авдаг гэнэ. Татварын асуудал энд дахиад л босно сонинууд ихэнхдээ татвараас зайлхийдэг гэнэ. Гэвч сонин хэвлэл төр, засгийн талаар шүүмжлэлт өгүүлэл нийтлэл хэвлээд байвал татварын эрх баригчид өнгөлзөж эхлэх биз.

Улс төрийн шинжтэй, шүүмжлэлт нийтлэл хэвлэдэг долоо хоног тутмын сонин, хоёр долоо хоног тутмын олон сонин санхүүгийн бэрхшээлтэй. Ерөнхийдөө, Монголын сонин хэвлэл, мэдээллийн бизнес гэхээсээ илүү эдийн засаг, улс төрийн эрх мэдэлт хэрэгсэл тул зах зээлийн хүчин зүйлд хөтлөгддөггүй.

Аймгуудад олон жижиг сонин янз бүрийн эх үүсвэрээс орлого олдог. Тэнд жинхэнэ зах зээл байхгүй учир хязгаарлагдмал захиалга, зар сурталчилгааны хөгжөөгүй зах зээл сонинуудад дэмжлэг болдоггүй. Орон нутгийн сонины ихэнх нь оршин тогтнохын тулд орон нутгийн засаг захиргаанаас сар тутам авч хариуд нь мэдээг нь нийтэлдэг. Нэг аймагт нэгээс дээш сонинтой бол зөвхөн нэг сонин санхүүжилт авна. Орон нутгийн засаг захиргаанд илүү ойрхон байдаг сонин авах нь тодорхой. Санхүүжилт нь мөн тоног төхөөрөмж, өрөө тасалгаа, сонины дугаарыг худалдан авч, сум, багуудад тараах зэрэг хэлбэрээр ирдэг.

Үүнтэй адил нэг компани, түүний ажиллагсад, даргыг нь сурталчилсан нэг дугаарыг санхүүжүүлэх хэлбэрээр хувийн эх үүсвэрээс санхүүжилт олж болно. Зар мэдээнээс зарим нэг орлого орох боловч, гаралт найдвартай биш учир ийм эх үүсвэрээс мөнгө олох нь тун бага. Эцэст нь тэмдэглэхэд орон нутгийн зарим сонин улс төрийн гол намуудын дэмжлэгтэй ажээ.

2.5 Мэдээлэл Харилцаа Холбооны Технологи /МХХТ/

Сүүлийн таван жилд МХХТ-ийн хэрэглээ нь хөрөнгө оруулалт, туслалцаа, хамтын ажиллагааны хүчинд эрчимтэй өсч байна. Төр засаг МХХТ-ийн 2012 он хүртэлх ирэх жилүүдийн зорилт, стратеги, хэтийн зорилгоо тунхагласан.

МХХТ-ийн үндэсний хороог Монгол улсын Ерөнхийлөгчөөр ахлуулан байгуулсан. Саяхан МХХТ-ын газрыг төслүүдийн хэрэгжилт, зохицуулалтыг удирдах үүрэгтэйгээр Ерөнхий сайдын удирдлага дор байгууллаа.

Засгийн газрын харьяанд байдаг МХХТ-ын газар нь МХХТ-ын зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ:

Засгийн газар, эрх зүйн хүрээнд: Засгийн газар нь мэдээллийн нийгмийн бүтцийг бий болгох нээлттэй мэдээлэл, үйлчилгээгээр хангагч байна.

Бизнес-эдийн засгийн хүрээнд: Дэлхийн эдийн засагт үр дүнтэй нэгдэх /интеграцид орох/ чадавхи бүхий бизнесийн орчинг бий болгох, дотоодын болон үндэсний үйлдвэрлэлийн оюуны чадавхи болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

Хүний хөгжлийн хүрээнд: Иргэн хаана амьдарч байгаагаас үл шалтгаалан нийгмийн амьдралд эрх тэгш, идэвхтэй оролцох болон бие биетэйгээ харилцахад хялбар байх боломжоор хангах.

2.5.1 Өнөөгийн бодит байдал

МХХТ-ын хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш эрчимтэй өөрчлөлт гарчээ. Монголд үүрэн телефоны хэрэглээ нь аль хэдийн суурин утасныхаас давчихсан байна. 2004 онд ердөө хүн амын 5.5 хувь нь гэртээ суурин утастай байхад 12.9 хувь нь үүрэн телефоны хэрэглэгч байв. Дэлхийн банкнаас хийсэн МХХТ⁹-ын талаарх саяхны судалгаанаас үзвэл, үүрэн телефоны хэрэглээ 2000 оноос хойш хоёр дахин өсчээ. Монголын хүн амын 64 хувь нь Улаанбаатар, томоохон хот, аймгийн төвийг хамарсан үүрэн телефоны сүлжээнд хамрагдсан бол энэ тоо зарим суманд арай бага. Мобиком, Скайтел, Юнител гэсэн үүрэн телефоны компани байгаагаас Мобиком 550000 хэрэглэгчтэйгээр энэ салбарыг тэргүүлж байна.

Түүнчлэн нь 2000 онд Интернэтийн холболт 1.3 хувьтай байсан бол 2005 оны байдлаар 5.8 хувь болж өсчээ. Компьютертэй хүний тоо 1.3 -аас 2.8 хувь болж нэмэгдсэн. Харьцуулж үзвэл айл өрхийн 28 хувь телевизтэй.

Төв суурин газрын оршин суугчдын ихэнх нь Интернэт хүлээн авах олон боломжтойн зэрэгцээ, Улаанбаатар аймгийн төвүүдэд Интернэт кафе борооны дараахь мөөг шиг олширчээ. Хөдөөгийн интернэт кафе ихэнхдээ Монголын Цахилгаан холбоо компаний салбар, дунд сургууль эсвэл төрийн байгууллагын байранд байдаг ажээ.

Хэвлэл мэдээллийн уламжлалт хэрэгсэл, ялангуяа телевиз зугаа цэнгээн, мэдээллийн гол эх сурвалж болдог бол шинэ технологи болох гар

9 Хөгжлийн төлөө Мэдээлэл болон Мэдээлэл Харилцаа Холбоо 2006: Дэлхийн хандлага, Бодлого

утас, Интернэт хэрэглээ хурдан хугацаанд эрч хүчээ аван хүмүүсийг холбох, мэдээллийг цагт нь хүргэх, харилцаа холбооны талбар бий болгоход чухал хэрэгсэл болж байна.

Бидний очсон бүх аймаг доод тал нь нэг Интернэт кафетэй, голчлон Монголын цахилгаан холбооны газрын салбарын байранд байрлаж байсан. Зарим аймгийн төвд өөр интернет кафе сургуулийн төслийн нэг хэсэг болох интернэт төвтэй байв. Оросоос Хятад руу хойноос өмнийг чиглэсэн төмөр замын шугамын дагуух шилэн кабель суурилуулсан нь ийм боломж олгожээ. Шилэн кабелийн гол сүлжээ нь бүх аймаг, хэд хэдэн сумыг холбож байна. Энэ төсөл 2006 оны сүүлээр хэрэгжиж дуусах юм.

Томоохон төв суурин газарт интернэт хүлээн авах боломж олгохын сацуу, шилэн кабелийн сүлжээ нь хот, алслагдсан аймгийн төвүүдийн хоорондох харилцааг үлэмж нэмэгдүүлнэ. Гэхдээ энэхүү шинэ хүчин чадлыг ашиглах бодлого хэрхэн биелэхийг харах л үлдэж байна. Е-Бэлэн байдал судалгаа /2002: Сүлжээт дэлхийд Монголын Е - бэлэн байдлын үнэлгээний тайлан/ үүнийг өөдрөгөөр үнэлж байна:

- Төвийн, орон нутгийн засаг захиргаа компьютержсэн
- Бизнесийн компьютер, интернэт холбогдол өндөр түвшинд
- Сургуулиудын хувьд их сургуулийн түвшинд /интернэтэд/ холбогдсон
- Олон нийтэд зориулсан Интернэт төв, кафетай

Гэвч:

- Бага орлоготой иргэд интернэтэд нэвтрэх, компьютер авч дийлэхгүй
- Цөөн тооны дунд сургууль компьютер, интернэт хүлээн авах боломжтой.

Монголд ажиллах үеэр хотын залуу үеийнхэн аймгийн төвийн интернэт кафегаар дамжуулан мэдээлэл харилцаа холбооны шинэ технологид хурдан суралцаж байгаа нь илт харагдаж байсан. Гэхдээ суманд интернэт хүлээн авах боломжгүй байлаа. Хөдөөгийн олон сургууль саяхнаас л компьютерийн танхимтай болж, интернэт хүлээн авах боломжтой болсон эерэг тал байв. Эдгээр хүүхдүүд компьютер, интернетэд суралцаж, интернэтэд нэвтрэх нь хялбар болсноор Интернэтээс мэдээлэл авах боломж ихээхэн нэмэгдэнэ. Үүрэн телефон аль хэдийн өргөн хэрэглээний болж, зах зээлийн үнэ ханшийг улс даяар мэдээлэхэд байнга ашиглагдаж байна.

2.5.2 Уламжлалт хэвлэл мэдээлэл ба МХХТ

Телевиз, сонин, радио гэх мэт Улаанбаатар хотын хэвлэл мэдээллийн олон байгууллага өөрсдийн эсвэл вэб сайттай хамтарсан. 2005-оны Монголын хэвлэл мэдээллийн мониторинг тайлангаас харахад Улаанбаатар хотын 12-19 насны залуусын 18 хувь нь интернэтийг дотоод мэдээний нэг эх

сурвалж болгон ашигладаг гэсэн байна. Гэсэн хэдий ч тэдний 89 хувь телевизийг мэдээллийг хамгийн гол эх сурвалж гэж үздэг байна.

Интернэт өргөн зурвасын хэрэглээ зохиогчийн эрхийн зөрчлийг ихэсгэж байна, ФМ радиогийн ихэнх нь зохиогчийн эрхийн асуудалд өчүүхэн ч анхааралгүйгээр интернэтээс дуу хөгжим татаж авч, нэвтрүүлдэг байна. Кино, энэ нь мөн интернэтэд байрлуулсан бусад мэдээлэлд ч хамаатай.

3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө дарамтанд байна

3.1 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нухчин дарах нь

Судалгааны багийнхан сэтгүүлчдийн бие, эрүүл мэнд, эрх чөлөөнд халдах, айлган сүрдүүлэх, нэр төр гутаасан, гүтгэсэн хэрэгт буруутгах, санхүүгийн дарамт шахалт үзүүлэх, хууль бус хязгаарлалт тогтоох зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн янз бүрийн хэлбэр байгааг тогтоосон юм. Эдгээр зөрчил үндэсний, орон нутгийн хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд тохиолдсон байна.

“Глоб Интернэшнл” ТББ 2005 оны 10-р сараас Олон улсын чөлөөт илэрхийллийн сүлжээ, Москвад төвтэй Онцгой нөхцөл дэх Сэтгүүлчдийн төвтэй хамтран “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжих нь” төсөл хэрэгжүүлж эхэлсэн байна.

Энэ төсөл нь Монголын хэвлэл мэдээлэлд ардчиллын хөгжилд тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийн тулд илүү их эрх чөлөө эдлүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчилд цогц мониторинг хийж, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих аян өрнүүлэх зорилготой ажээ.

Үүний зэрэгцээ төслийн хүрээнд эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдэд хуулийн төлбөргүй зөвлөгөө өгч байна.

2005 оны 11-р сард “Глоб Интернэшнл” ТББ өдөр тутмын таван сонин, долоо хоног тутмын хоёр томоохон сонины сэтгүүлчдийн дунд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн судалгаа хийжээ¹⁰. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн талаас илүү хувь нь ажил үүрэгтэйгээ холбоотойгоор дарамт шахалт, заналхийлэлд өртсөн байжээ. Сэтгүүлчийг утсаар заналхийлэх, хэвлэл мэдээллийн удирдлагаас дарамт шахалт үзүүлэх, цагдаа, шүүхэд дуудах, худал залруулга нийтлүүлэхийг шаардах зэрэг зөрчил хамгийн их гардаг байна.

Төслийн эхний жил “Глоб Интернэшнл” ТББ-д 25-30 зөрчлийг мэдээлжээ¹¹. 2006 оны 7-р сард телевизийн эмэгтэй сэтгүүлчийн биед

¹⁰ <http://www.monitoring.mn/?module=record1&id=31&menuid=46>

¹¹ Зөрчлийн бүх мэдээ монгол хэлээр:

халдсан байна. Сэтгүүлч 2006 оны 6-р сард Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн 9000 ажилчны хувьчлалын үнэт цаасны асуудлаар сурвалжлага хийжээ. Телевизийн нэвтрүүлгийн дараа үл мэдэгдэх хүмүүс сэтгүүлч Б.Цэвэгмидийг утсаар заналхийлжээ. Хувьчлалын үнэт цаасыг хадгалж байсан “Эрдэнэт” брокерийн пүүсийн захирал “Энэ их ээдрээтэй асуудал. Чи амиа ч алдаж болно” хэмээн сэтгүүлчид анхааруулж байжээ. Сэтгүүлч 7-р сард үл мэдэгдэх хүмүүст орцныхоо үүдэнд зодуулж, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна.

2005 онд орон нутгийн сонины редактор бүсгүйг шүүмжлэлтэй нийтлэл бичсэнийх нь төлөө үл мэдэгдэх хүн хашааг нь машинаар дайрсан байна. Хэргийн тухай цагдаагийн газарт мэдэгдсэн ч, гэмт этгээдийг олж илрүүлээгүй байна. “Бизнес эрхлэгчдэд доромжлуулдаг гэхчлэн бид байнга дарамт шахалтанд өртдөг” гэж редактор эмэгтэй онцлон тэмдэглэсэн юм.

Цагдаагийнхан жагсаал цуглааныг сурвалжилж байсан сэтгүүлчдийн эрхийг хэд хэдэн удаа зөрчжээ. 2006 оны 10-р сард иргэний нийгмийн жагсаал, цуглааныг сурвалжилж байсан “Өдрийн сонины сэтгүүлч Г.Эрдэнэбат, Б.Хажидмаа, гэрэл зурагчин Аранжинбаатар, мөн “Ардын эрх” сонины гэрэл зурагчин Ш.Гэрэлсайхан нарыг цагдаагийнхан хоёр цаг орчим саатуулжээ. “Сэтгүүлч эмэгтэй Б.Хажидмааг цагдаагийнхан бороохойгоор зодож, нүүр биеийг нь хүнд гэмтээсэн байна. Цагдаагийн ажилтан гэрэл зургийн камерийг хураах гэж оролдоод эвджээ.”¹²

Эдгээр шуурхай мэдээ нь мөсөн уулын орой нь юм. Судалгааны баг “Глоб Интернэшнл” ТББ-ын судалгааны дагуу улсын хэмжээнд мөрдлөг, дарамт шахалтад орж байсан иргэний нийгмийн төлөөлөгч, сэтгүүлч, редакторуудтай уулзаж ярилцсан юм. Олон сэтгүүлч эрх нь зөрчигдсөн тухай цагдаад ч “Глоб Интернэшнл” ТББ-д мэдээлдэггүй байна. Эрх барьж буй улс төр, тэдний талынхан, нөлөө бүхий бизнес эрхлэгч, тэр ч бүү хэл цагдаагийнхан сэтгүүлчийн эрхийг олон тохиолдолд зөрчдөг, мөн сэтгүүлчид цагдаа, шүүхийнхэнд итгэдэггүй болохоо илэрхийлж байв. “Эрхийн зөрчлийг цагдаагийнханд мэдэгдвэл байдал улам дордоно” гэж тэд болгоомжилдог ажээ. Зарим тохиолдолд сэтгүүлчид “Глоб Интернэшнл” ТББ-ын төслийн тухай мэдээгүй, төслийн тухай мэддэг ч хэргийн тухай хэвлэлээр мэдээлж, олны анхаарал татвал байдлыг улам хурцатгаж, дайсагнасан байдал үүсгэнэ хэмээн айж энэ тухай мэдээлдэггүй байна.

“Глоб Интернэшнл” ТББ сэтгүүлчийн эрхийг зөрчсөн хүнд холбогдох хуулийн заалт зөрчсөн тухай сонордуулах захидал илгээдэг ч, үүний улмаас нэг аймагт нөлөө бүхий этгээд сэтгүүлч эмэгтэйг үргэлжлүүлэн мөрдөж мөшгин, мэргэжлээрээ ажиллахад нь улам төвөгтэй болгожээ.

<http://www.monitoring.mn/?module=zurchil&menuid=37> and IFEX-аао цацсан 12 мэдээ:

<http://www.ifex.org/fr/content/view/archivealerts/154/>

1 2 <http://www.globeinter.org.mn/en/enewsdetail.php?nid=371>

3.2 Үндэсний цөөнх

Монголд хэд хэдэн үндэсний цөөнх байдаг. Хамгийн том нь Казахууд, голчлон Баян-Өлгий, Ховд аймагт амьдардаг. Хүн амын 90 хувь нь казахууд амьдардаг Баян-Өлгий аймагт орон нутгийн хэвлэл мэдээлэл ихэвчлэн казах хэлээр мэдээллээ түгээдэг. Хүн амын дийлэнх нь лалын шашны Сүнни урсгалд хамрагддаг.

Лал, бурхны шашинтнуудын хооронд хүчтэй мөргөлдөөн гарч байгаагүй, тайвнаар зэрэгцэн оршдог гэж судалгаанд хамрагдсан хүмүүс хэлж байна. Баян-Өлгий аймагт улс төрийн байдлыг авч үзвэл, монголын бусад аймагтай нэгэн адил МАХН, АН давамгайлдаг. МАХН 2000 оноос хойш эрх барьж буй бөгөөд намаа дагаад нөхцөл байдал нь улс төржсөн, гэхдээ омгийн тогтолцооноос үүдэн улс төр, нийгмийн нөхцөл байдал илүү төвөгтэй. Хятад, Оростой бизнес харилцаатай, Казахстанас нэлээд дэмжлэг авдаг тул аймгийн төв нь хөрш зэргэлдээх аймгийн бусад төвүүдээс арай хөгжингүй.

Монголд гурван жижиг сонин орос хэл дээр, нэг сонин хятад хэлээр гардаг. Кабель сансрын сувгаар дамжуулан энд амьдарч буй цөөнх болох орос, хятад хүмүүс эх хэлээрээ телевиз үзэх боломжтой. Ялангуяа хил орчим суудаг хүмүүст энэ нь бүр ч хялбар.

Монголын нийслэл, алслагдсан аймгуудын хоорондох мэдээлэл хүлээж авах ялгааг арилгах нь чухал асуудлын нэг төдийгүй, эрчим хүчний хомсдол, эдийн засгийн дарамтаас үүдэлтэйгээр мэдээлэлгүй хоцорсон алслагдсан сум болон аймгийн төв хоорондох мэдээллийн ялгаанд ч хамаатай.

Үндэсний цөөнхийн мэдээлэл авах боломжийг өргөжүүлэх зорилготой ажлыг 2004 онд ЮНЕСКО эхлүүлж, Монгол дахь НҮБ-ын бусад байгууллагад үлгэр жишээ болсон. ЮНЕСКО үндэсний цөөнх цаатан, дархадуудад зориулсан “Цаа буга” ФМ радиог байгуулсан. Радио сонсогчдын дунд явуулсан саяхны судалгаагаар цаг агаарын мэдээ, мэдээ, шинжлэх ухаан, боловсролын нэвтрүүлэг, зар, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, Монголын нийтэд түгсэн дуу бусад хөгжмийн нэвтрүүлгийг тэд хамгийн их сонсдог гэлээ “Ямар төрлийн нэвтрүүлэг байнга сонсохыг хүсдэг вэ?” гэсэн асуултад тэд “хуульчийн зөвлөлгөө, уран зохиолын цаг, үндэстэн ястны хэл, соёлтой холбоотой зах зээлийн мэдээ” гэж хариулжээ. Дархад, цаатнуудад зориулсан ЮНЕСКО-ийн төсөл энэ хоёр ястан амьдралын өвөрмөц хэв маяг, хэл соёл, аялгаа хадгалж чадсан ч, төрөлх хэлээрээ хөгжлийн мэдээлэл авах туршлага их дутмаг байгаагаас өв соёлоо хадгалж үлдэх зэрэг бэрхшээлтэй тулгардагийг мэдэрч тусалжээ.

ЮНЕСКО мөн Би-Би-Си /BBC/, орон нутгийн ТББ-ын мэргэжилтнүүдтэй хамтран Баян-Өлгий аймагт хэвлэл мэдээллийн

ажилтнуудад зориулан олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сургалт зохион байгуулсан. Үүний дараа 2005 онд дөрвөн дадлагажигч Казахстаны Улсын Их Сургуулийн сэтгүүл зүйн тэнхимд суралцахаар явсан, 2006 онд “Өлгий” ТВ-ийн нэг зураглаачийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Малайзын Радио Телевиз рүү илгээсэн. Одоо ЮНЕСКО Баян-Өлгийн алслагдсан сумдад гурван радио станц байгуулахад нь орон нутгийн өргөн нэвтрүүлэгчид тусламж үзүүлж байна. ЮНЕСКО, Улсын төв номын сантай хамтран буриад, казах хэлээр олон мянган ном худалдан авч, мөн орчуулж, хэвлэжээ.

3.3 Сэтгүүл зүйн боловсрол

Коммунизм задран унаснаар Монгол улс шинэ залуу ардчилсан орны хэрэгцээ шаардлагад нийцсэн хэвлэл мэдээллийн бүхэл бүтэн шинэ тогтолцоо бий болгох зорилт, сорилттой тулгарсан юм. Сэтгүүлчдийг бэлтгэх, хэвлэл мэдээллийн менежментийн сургалт үүний чухал хэсэг юм.

Ийм учраас олон улсын байгууллага, Монголын ТББ-ууд сүүлийн 10-15 жилд сэтгүүлчдийг бэлтгэх сургалтад онцгой анхааран ажиллаж байна. Энэ судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн дийлэнх олонхи нь МХХ, Монголд ажиллаж буй ТББ-уудын дунд түвшний сургалтад нэг болон хэд хэдэн удаа хамрагджээ.

Дунд шатны сургалтад үлэмж хөрөнгө оруулсан болон бараг бүх сэтгүүлч чөлөөт, хариуцлагатай хэвлэлийн ач холбогдлын талаар иш татдаг болсон хэдий ч, Монголын сэтгүүл зүйн стандарт өчүүхэн төдий дээшилсэн байна.

1990 он хүртэл сэтгүүл зүйг зөвхөн Монгол улсын их сургуульд зааж байсан. Түүнээс хойш Улаанбаатарт 21 дээд сургууль сэтгүүл зүйн сургалт явуулах болжээ. Эдгээрээс дөрөв нь төрийн мэдлийн, үлдсэн нь хувийн хэвшлийн сургууль юм. Эдгээр сургууль дунджаар нийт 1500 орчим оюутантай.

Их сургууль болон хувийн сургуулиудын сургалтын чанар доогуур гэж хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, сэтгүүл зүйн багш нар хэлж байв. Хувийн сургуулиуд, ерөнхийдөө мэргэжлийн өндөр түвшин, ёс зүйтэй сэтгүүлчдийг бэлтгэхээс илүүтэй ашиг олохыг гол болгодог гэнэ. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэд хэдэн эзний хэлснээр их дээд сургуулиуд зөвхөн онолын хичээл зааж, практик ур чадварыг бараг эзэмшүүлдэггүй ажээ.

Үндэстний цөөнхийн хувьд тэд Монголд эх хэлээрээ сэтгүүл зүйн боловсрол эзэмших боломж байхгүй.

Сэтгүүл зүйн боловсрол, сургалтын асуудал хөдөөд огт өөр. ТББ-ууд үе үе хөдөөд сургалт явуулдаг боловч орон нутагт сэтгүүл зүйн сургалт

явуулах чадавхи бүхий байгууллага байхгүй. Хөдөөгийн хэвлэл мэдээллийн эздийн хэлснээр, сургалтад хамрагдах боломж урьд өмнө нь илүү байсан бол одоо бараг үгүй болжээ. Сэтгүүлчдийн сургалт Улаанбаатарт төвлөрдөг нь, хөдөөгийн сэтгүүлчдэд мөн л хүндрэлтэй. Бэрхшээл зөвхөн төлбөрт ч бус ажээ. Орон нутгийн хэвлэл мэдээллийн ихэнх байгууллага ердөө л нэг, хоёр ажилтантай тул тэд Улаанбаатар руу сургалтанд явчихвал хаагдахад хүрнэ.

Түүнчлэн “хот руу сургалтад явсан залуу сэтгүүлчид орон нутгийн ХМХ-ийн санхүүгийн хүндрэл, бага цалингаас үүдэн барагтай бол буцаж ирдэггүй” хэмээн эзэд нь гомдол мэдүүлж байсан. Үүний дүнд, ялангуяа хөдөөгийн залуу сэтгүүлчид албан ёсны сургалтад маш бага хамрагдаж, ажиллах явцдаа л суралцдаг ажээ. Ийм байдал аймгийн радиод илүү ажиглагдаж байна.

Сэтгүүл зүйн олон тооны сургуультай боловч хэвлэл мэдээллийн менежментийн курс, сургалт огт байхгүй байна. Монгол улс ардчилалд шилжсээр 15 жил болж байгаа ч, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн төлөө, эсвэл улс төр, бизнесийн дэмжлэгээс ангид ашигтай бизнес эрхлэхийн төлөө оршдог хараат бус, тэнцвэртэй ХМХ-ийг хэрхэн удирдах, хөгжүүлэх тухай ойлголт тун бага эсвэл огт ойлголтгүй хэвээр байна.

3.4 Сэтгүүл зүйн ёс зүй

Сэтгүүл зүйн ёс зүй бол Монголд гол асуудал. 2003 онд Монголын Чөлөөт, хараат бус сонинуудын холбоо ёс зүйн код баталсан боловч төдийлөн нөлөө үзүүлсэнгүй. Сэтгүүл зүйн ёс зүйн асуудал олон талын дарамт шахалтад байна. Хэвлэл мэдээллийн орчин нь өөрөө шударга, тэнцвэртэй мэдээллийг хүлээн зөвшөөрөхгүй, хөхиүлэн дэмжихгүй байна. ХМХ-ийн эздийн баримталж буй редакцийн дотоод бодлого нь тэнцвэртэй мэдээлэл өгөх боломж олгохгүй байна.

Сэтгүүл зүйн сургууль, ТББ-уудын сургалт нь өнөөгийн бодит байдалд бус харин хэвлэл мэдээллийн мэргэжлийн төгс зах зээл дээр үйл ажиллагаа явуулахад л чиглэж байна. Төгсөгчид нь практик ажил эрхлэхэд сургуульд эзэмшиж сурсан мэдлэг, ур чадвар нь тэдний ажиллах ёстой орчинд огт нийцэхгүй болохыг ойлгодог ажээ.

Гэсэн хэдий ч, асуулт оршсоор: яагаад олон сэтгүүлч, эрхлэгч хээл хахууль буюу өндөр үнэ санал болгогчдод “төлбөрт мэдээ” худалдахыг буруу гэж боддоггүй вэ? Үүнд олон учир шалтгаан байж болох юм. Одоогийн орчин нь чөлөөт, хараат бус сэтгүүл зүйг өсч өндийхөд нэмэр болох яагаа ч үгүй байна. Сарын 40-50 ам.долларын бага цалингаараа сэтгүүлч амь зуухад хэцүү. Энэ шалтгаан мэдээжээр мэргэжилдээ үнэнч, хариуцлагаа ухамсарлан, сорилтыг давах, бэрхшээлийг туулах хүсэл эрмэлзэлгүй сэтгүүлчдийн хувьд өөрийгөө хялбар зөвтгөх арга биз.

Өөр нэг шалтгаан нь нэг намын тогтолцоонд ХМХ нь зохион байгуулалт сайтай байдаг коммунист засаглалаас өвлөгдсөн байж болох юм. Дээрээс доошоо чиглэсэн хяналт ноёлж сэтгүүлчдийн юу мэдээлэх ёстой, юу ёсгүйг зааварчилдаг шугамаар гарч буй бүтээгдэхүүнийг тодорхой зохицуулж байсан. Энэ эрин үе ердөө л 15 жил орчмын өмнө төгсгөл болж, тэр үеийн сэтгүүлчээс олон нь одоо сонин, телевизэд ажиллаж байна. Хөдөөд зарим сэтгүүлч орон нутгийн ХМХ эрхэлж байна.

Тэднээс олон нь өнгөрсөн жилүүдэд хэд хэдэн ТББ-ын сургалтад хамрагджээ. Хүний сэтгэлгээг өөрчлөх хялбар бус, олон сэтгүүлч төрийн эрх барьж буй намын гишүүд учраас бус, зүгээр л тэдний хувьд эрэн сурвалжлах сэтгүүл зүй, Засгийн газар, удирдлагаа шүүмжлэх нь харь хөндий ажээ. Ёлангуяа хөдөө орон нутагт нэгтгүүлчид аймгийн захиргаанаас санхүүгийн хувьд хараат, хүн ам цөөн тул хавчин гадуурхагдахаас айж чөлөөтэй ярьж зүрхэлдэггүй гэдэг байна.

Гэсэн хэдий ч ахмад, туршлагатай зарим сэтгүүлч шинэ эрх чөлөөнд талархан таатай хандаж, шинэ үеийнхэндээ үлгэр дууриалал болж байна. Залуу сэтгүүлчид нь ёс зүйн хэм хэмжээ дутмаг, бизнес мэдээ, дуулиант төлбөрт нийтлэлд өөрсдийгөө дуртайяа зориулдаг нэг хэсэг, чөлөөт, хараат бус сэтгүүл зүйн зарчмуудыг хэлбэрэлт мөрддөг нөгөө нэг хэсэгт хуваагджээ.

4. Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл - Тулгамдсан асуудал, боломж

Монголын чөлөөт хараат бус, хэвлэл мэдээллийн хөгжлийн замд бэрхшээл тулгарч байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний дээр дурдсан зөрчлүүд нь ээдрээтэй, гэхдээ эдгээр нь хэвлэл мэдээллийн улс төр, санхүүгийн хараат байдалтай холбоотой илүү хурц асуудлуудын салшгүй хэсэг тул бүр ч ноцтой юм. Хэвлэл мэдээлэлд үзүүлж буй улс төр, санхүүгийн асар их нөлөөлөл нь хараат бус, сайн сэтгүүл зүйд маш бага орон зай үлдээж байна. Хэвлэл мэдээлэл төлбөрт нийтлэл, төлбөрт нэвтрүүлэг хэлбэртэй “бизнес мэдээ” захиалгат мэдээллээр дүүрэн байна.

Хэвлэл мэдээлэл дэх улс төр, санхүүгийн нөлөөллийн тухай дэлхий даяар мэддэг боловч. Монголын хувьд түгшээж буй гол зүйл юм. Шалтгаан нь, тухайн компани эсвэл улс төрчийн мэдээлэл, нийтлэлийг сэтгүүлчид өөрсдөө бэлтгэдэг. Ингэснээр тухайн сэтгүүлч мэргэжлээ таягдан хаях эрдслийг бий болгож, дараа нь нөгөө компани, улс төрчийн тухай шүүмжлэлт материал бэлтгэхээс зайлсхийхэд хүргэдэг. Хоёрдугаарт, хэвлэл мэдээллийн “бизнес мэдээ” болон хараат бусаар бэлтгэсэн материал хоёрыг заагладаггүй учир сонины уншигч, телевиз үзэгчид юунд итгэхээ мэдэхгүй төвөгтэй нөхцөл байдалд орно.

Сэтгүүлчид тухайн нийтлэл, нэвтрүүлэг захиалгатай, төлбөртэй болохыг байгууллагадаа мэдэгдэлгүй бүх мөнгийг өөрсдөө авчихдаг

тохиолдол ч гардаг ажээ. Сэтгүүлчийн ёс зүйн асуудал бус, харин хөнгөн зальд тооцогдон бага зэргийн сахилгын шийтгэл хүлээгээд өнгөрдөг гэнэ. Үүнээс гадна чөлөөт сэтгүүлчид ч хэвлэл мэдээллийн байгууллагад “бизнес мэдээ” нийлүүлэх замаар идэвхлэн мөнгө олдог байна.

Хэвлэл мэдээллийн зарим байгууллага “бизнес мэдээ” огт авдаггүй, харин энэ нь сэтгүүлчдийн дунд нийтлэг зүйл учир үүнээс зайлсхийснээр хүндрэл тулгардаг ажээ.

Үүний зэрэгцээ сэтгүүлч нь нийтлэл, нэвтрүүлгийнхээ төлөө төлбөр авсныг шүүхэд эрхлэгчид заримдаа бэрхшээлтэй ажээ. “Ийгл” телевиз төлбөрт мэдээ хийснээ тэр даруй нь мэдэгдэх ёстой гэсэн бодлого барьж, илчлэгдсэн тохиолдолд сэтгүүлч олсон бүх мөнгийг буцаан төлөх үүрэг хүлээдэг. Хоёр удаа, эсвэл улс төрийн агуулгаар ганц удаа төлбөр авсан тохиолдолд сэтгүүлчийг ажлаас халдаг. “Ийгл” телевиз сэтгүүлчиддээ мэдэгдэхүйц өндөр цалин, хамгийн бага нь сард 200 ам.доллар олгодог.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хувьд “төлбөрт” нийтлэл, төлбөрт нэвтрүүлэг бэлтгэх нь бүр ч түгээмэл болж байна. Шинээр байгуулагдсан бага төсөвтэй зарим ФМ радиог эс тооцвол, орон нутгийн бараг бүх хэвлэл мэдээлэл төлбөрт нийтлэл, төлбөрт нэвтрүүлгээс хараат ажээ. Үнэндээ орон нутгийн зарим телевиз төлбөрт нэвтрүүлгээс өөр юу ч дамжуулдаггүй. Гол ивээн тэтгэгч нь аймгийн ЗДТГ, улс төрч, бизнес эрхлэгч мөн сурталчилуулахыг хүссэн сумын төв, эсвэл төслөө сурталчлах зорилготой ТББ-ууд ч байдаг. ЗДТГ-аас үзүүлж буй санхүүгийн “тусламж” нь орон нутгийн хэвлэл мэдээлэл оршин тогтноход нэн чухал. 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар төр ОНМХ өмчлөхийг хориглосон боловч, үнэн хэрэгтээ олон аймгийн хэвлэл мэдээлэл нь засаг дарга болон улс төрч, бизнес эрхлэгч жижиг бүлэглэлийн хяналтад байдаг. Албан ёсны эзэмшигч нь хувь хүн, аймгийн ИТХ байдаг боловч үнэндээ УИХ-ын гишүүн эсвэл МАХН-ын бүлэг орон нутгийн ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянадаг.

Зарим аймагт хэвлэл мэдээллийн байгууллага нь сөрөг хүчин болох АН-д харъяалагддаг, эсвэл олон нийт энэ намтай холбоотой гэж үздэг. Хичнээн хичээсэн ч, энэ туйлширсан орчин нь хоёр намтай нөхцөл байдлаас ангид, гадна орших боломжгүй болгож байна. Гэхдээ “сөрөг” хэвлэл мэдээлэл ч олон талаараа аймгийн засаг даргаас хамааралтай. Тэдгээрийн зарим нь ЗДТГ-аас төлбөрт албан ёсны мэдээг авч нийтлэх нь санхүүгийн дэмжлэг болдог тул, шаардлагатай мэдээлэл олж авах үед Засаг дарга сайн хандана гэж найддаг. Зарим аймагт сөрөг хэвлэл мэдээлэл эрх баригчдаас шаардлагатай мэдээлэл ч авч чаддаггүй. Энэ нь мэдээллийн эрх чөлөө, ардчиллын үйл явцад хортой. Төгсгөлд нь тэмдэглэхэд, хэрэв орон нутаг дахь сөрөг хэвлэл мэдээлэл эрх баригчдад хэт шүүмжлэлтэй хандвал үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө дарамт шахалт дор хэмээх бүлэгт өгүүлсэнчлэн илүү хатуу арга хэрэглэдэг.

Үүргээ ухамсарласан, сайн бэлтгэгдсэн сэтгүүлчидтэй орон нутгийн зарим хэвлэл мэдээлэл энэ бүх гажигийг үл тоон, заримдаа бүр араа ч дэнчин тавин байж, судалгаа сайтай, материал бэлтгэн гаргадаг болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Харамсалтай нь, ийм эр зоригтой сэтгүүлч, редакторууд олон янзын дарамт шахалтаас айн болгоомжлох болсон төдийгүй, санхүүгийн хувьд оршин тогтнохтой холбоотой аж ахуйн захиргааны асуудлаар их хэмжээний нөөц бололцоог зарахад хүрдэг.

Хараат бус хэвлэл мэдээллийн үүднээс авч үзвэл, орон нутгийн ФМ радио нь зарим талаараа чөлөөт гэж хэлж болно. Орон нутагт шинээр байгуулагдсан богино долгионы олон радио нь хэвлэл мэдээллийн энэ туйлширсан орчноос ангид оршиж чаддаг. Үүний нэг гол шалтгаан нь, богино долгионы радио станцыг бага хөрөнгөөр байгуулж болно. Мөн ашиг олж буй олон радио станцын сайхан жишээ байна. Орон нутагт зарим радио станцыг бизнес эрхлэгчид ихэнх хэвлэл мэдээллийн нэгэн адил улс төрийн бус бизнесийн зорилгоор байгуулжээ. МАХН сүүлийн сонгуулийн өмнө олон ФМ радио станцуудыг сонгуулийн сурталчилгааны хэрэгсэл болгон байгуулсан ч, дараа нь шинэ удирдлагын гарт очиж МАХН-аас хараат бусаар ажиллах болсныг тэмдэглэх нь зүйтэй. Хоёрдугаарт, ихэнх ФМ радио станцын нэвтрүүлгийн хөтлөгч нь дунд сургуулийн хүүхдүүд, ихэвчлэн хөгжим, уралдаан, яруу найраг, сонирхолтой түүх, боловсролын хөтөлбөр явуулж, утсаар зарлал хүлээн авч нэвтрүүлдэг. Ихэнх ФМ радиог улс төрийн бус харин амралт, чөлөөт цагийн зориулалттай гэж үздэг. Ямартай ч, ФМ-үүдийн утсаар шууд холбогдох хэлбэр, орчин үеийн дэлхий ертөнцийг өргөн хүрээтэй танилцуулахад гайхалтай өөрчлөлт хийж байна. Тэгэхээр ФМ-үүд гагцхүү аймгийн залуу үеийн хувьд бус, харин соёлын үүднээс авч үзэхэд ач холбогдол бүхий үр нөлөө үзүүлж байна.

Мэдээ, арай илүү сэтгүүл зүйн шинжтэй нэвтрүүлэг дамжуулдаг радио станцууд хэвлэл мэдээллийн улс төрийн туйлширсан байдалд тэр даруйдаа уусдаг. Шүүмжлэлт сэтгүүл зүй бүхий радио станцууд нь бусад сонин, телевизүүдийн нэгэн адил дарамт шахалтад өртдөг. Хэдийгээр МАХН радио өргөн нэвтрүүлгийн бодлогод хөндлөнгөөс оролцдоггүй гэх боловч, тусгай зөвшөөрөл олгоход хяналт тавьдаг учир, тэдгээрийг дараагийн сонгуулийн үеэр дахин өөрийн хэрэгсэл болгон ашиглаж болох юм гэдгийг нэмж тэмдэглэх нь зүйтэй.

Аймгуудад МАХН, түүнтэй холбоотой бизнес сонирхол нь, эмх замбараагүй хэдэн жилийн дараа хэсэгчилсэн өрсөлдөөнт хэвлэл мэдээллийн зах зээлд дасан зохицох болжээ. Шинэ эрх баригчид хэвлэл мэдээлэл эрхлэх, хяналт тавихдаа шаардлагатай бол дарамталж, мөрдөхөөс ч үл буцах, улс төр, бизнесийн шинэ загварыг бодож олжээ. Арга нь өөрчлөгдсөн хэдий ч, зонхилох сэтгэхүй нь хэвээр байна. Аймаг дахь АН-ын зохион байгуулалт тааруу, эмх журам сул учир тус нам нөлөөтэй болж чадахгүй.

4.1 Орлогын загвар буюу санхүүгийн хараат бус байдал боломжтой юу?

Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд зайлшгүй чухал хүчин зүйл нь өөрт оногдсон эрхийнхээ дагуу зах зээлийн хувь хэмжээний төлөө өрсөлдөж (үзэгч, уншигч, сонсогч гэх мэт) ХМХ-ээ бизнес шиг ажиллуулах, улс төр, бизнесийн ашиг сонирхолд найдалгүй оршин тогтнох чадвар бүхий хэрэгжихүйц санхүүгийн тийм загвар юм.

Зах зээлийн хүчин зүйлээр зохицуулагддаг барууны загвар нь хэвлэл мэдээллийг өмчилснөөр бизнесийн үнэ цэнэ бүхий боломж олгодог санхүүгийн тийм загварыг олон оронд бий болгож чадсан хэдий ч, энэ нь бас л төгс бус. Уншигч, үзэгч, сонсогчийн хэрэгцээ, хүчинд тулгуурлах гэдгийг ардчиллын үйл явцын төлөөх эрүүл саруул хэв маяг болох олон нийтийн яриа хэлэлцүүлэг хэмээн хэтрүүлэх шаардлагагүй юм. Энэ арга барилыг ажил хэрэг болгохын тулд зах зээл, зар сурталчилгааны үнэ цэнийг мэдэрдэг, хүчтэй дадал зуршил бүхий эдийн засгийн орчин шаардагдаж байна. Хэрэглэгч найдвартай мэдээлэл шаарддаг, зугаацуулан цэнгээх нь санхүүгийн тогтвортой загварыг бий болгох түлхүүр нь юм.

Монголд ийм тогтолцооны хөгжил нялх хэвээр байна. 2.5 сая хүн амтай Монгол улс гайхалтай олон тооны ХМХ-тэй, тэдний дийлэнх нь ашиг сонирхол бүхий гадны дэмжлэгт дулдуйдаж, үлдсэн нь зар сурталчилгаа, захиалгын зах зээл хомс тул санхүүгийн эрхшээлд амь тээж байна. Хэвлэл мэдээллийн бизнесийн төлөө, хараат бус үйлчилгээ явуулдаг. ХМХ Монголд тун цөөхөн байна.

Гэсэн хэдий ч, Монголын эдийн засаг нүүрс, зэс, алт гэх мэт байгалийн асар их нөөц баялаг нээж илрүүлж буй улсын хувьд, улам бүр эрч хүчээ авч байна. Улаанбаатар хотын дунд давхаргын оршин суугч шинээр бий болж буй хэрэглээний зах зээлийг нэмэгдүүлэхийн сацуу шинэ баялаг ядуу ч, баян ч өөр өөрийн хувь хэмжээгээр хүртэн сууна. Хөдөөд хэлхээ холбоо сайтай хэдэн хүн, эсвэл Монголын байгалийн баялагийг хөршүүддээ хямдхан зарж буй хүмүүс л ашиг хонжоо олж байна. Бидэнд ярилцлага өгсөн нэг хүн “Хэдхэн хүн ашиг олж сууснаас Монголын байгалийн нөөцийн баялгаар хүн бүр мерседестэй болсон нь дээр” гэж билээ.

Монголын хэрэглэгчид, ялангуяа, төв суурин газрынхан зах зээл дээр янз бүрийн бараа, үйлчилгээ өсөн нэмэгдэж буйг хэвлэл мэдээллээр дамжуулан харж байна. Зах зээлийн өргөн хэрэглээний барааны зар сурталчилгаа өсөхийн хэрээр хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд зар сурталчилгааны томоохон боломж бий болж, улс төр, бизнесийн ашиг сонирхолд найдах нь багасахад дэмжлэг болох байх.

Өмнө тэмдэглэсэнчлэн, телевизийн өсөн нэмэгдэж буй өрсөлдөөнт зах зээлийн боломжуудыг телевизүүд удаан ч гэлээ ойлгож эхэлж байна. Хэрэглэгчийн судалгаа, холбогдох бусад судалгаа саяхнаас эрчээ авч байна. Хэвлэл мэдээллийн зах зээлийн ард орших учир уялдааг зах зээлийн

хүчин зүйл ерөнхийд нь алгуур өөрчилж болох юм. Амин хувийн ашиг сонирхолд тавих мөрий өндөр байдаг тул тэд хэвлэл мэдээллийг өөрийн гараас тэмцэлгүйгээр мулталчихгүй л болов уу.

Аймгуудад нөхцөл байдал эсрэг. Орон нутаг дахь хэвлэл мэдээлэлд дэмжлэг байхгүй, зар сурталчилгааны зах зээл бий болох төлөв харагдахгүй байна. Энэ нь орон нутгийн хэвлэл мэдээлэл төр, улс төр, бизнесийн ашиг сонирголоос ихээхэн хамааралтай байгаа өнөөгийн нөхцөл байдлаас зайлхийх сонголт тун цөөн байна. Зарим аймаг дахь бага төсөвтэй ФМ радио зарлал, шууд утсанд тулгуурлан зохистой бизнес хийж чадаж байгаа ч, ихэнхдээ бас л захиалгатай “төлбөрт” мэдээллээс нэмэлт орлого олдог. Шинээр өрсөлдөөн бий болж байгаа нь хөрөнгө оруулалтаа нөхөхөд хүндрэл учруулахын сацуу зарим газар шууд утсаар олдог орлого буурч байгаа аж. Утсаар холбогдож байгаа хүмүүсийн хувьд ч энэ нь үнэтэй болохыг ойлгосонтой холбоотой байж болох юм.

Хөдөөд зар сурталчилгаа, захиалгын орлого нь зохистой сайн мэдээлэл бүхий ХМХ-ийг дэмжихэд хангалтгүй учир олон нийтийн дэмжлэгийн хэлбэр эсвэл олон нийтийн өргөн нэвтрүүлэг л цорын ганц хэрэгжихүйц хэлбэр байж магадгүй.

5. ТББ иргэний нийгмийн байгууллагууд

5.1. ТББ, иргэний нийгмийн үүрэг

Ихээхэн улс төржсөн, авилгад өртөмдөй Монголын нийгэмд иргэний нийгэм нь чухал үүрэг гүйцэтгэнэ. Харамсалтай нь одоогоор иргэний нийгэм өөрчлөлтийг авчрах онцгой хүчтэй хүчин байж чадахгүй байна. Өмнө дурдсанчлан сэтгүүлчдийн байгууллагууд болон ТББ-уудын нэгэн адил олон байгууллага улс төрийн удирдагчидтай дотно холбоотой. Улс төрчийн гэргий юм уу хамаатан нь санхүүжилт авахын тулд ТББ байгуулах нь олонтаа. Үүнээс нэлээд өөр байх нь ÷ бий. Соёмбо хөдөлгөөн, Эрүүл, шударга нийгмийн төлөө хөдөлгөөн мэтийн байгууллагууд нийгмийн өөрчлөлтийн төлөө зүтгэх, шударга бус зүйлийн эсрэг сонор хоточ нохойн үүрэг гүйцэтгэхээр зүтгэж байна. Иргэний нийгмийн хэд хэдэн хөдөлгөөн 2006 онд хүчээ нэгтгэж, парламентын нэмэлт үйл ажиллагаанд жинтэй дэмжлэг олж чадсан юм.

Монголын ахмадын чөлөөт холбооны тэргүүн Г.Баасан 10 60000 сард цагдаад халдсан хэргээр баривчлагдсан. Иргэний хөдөлгөөний удирдагчийг чөлөөлөх жагсаалыг тараахаар цагдаа нар хүч хэрэглэхэд өдөр тутмын хоёр сонины гурван сэтгүүлч зодуулж, бусадтай хамт саатуулагджээ.

Жагсаалыг сурвалжилж байсан сэтгүүлч, жагсаалд идэвхтэй оролцогчдыг хүчээр дарсан нь олон нийтийн зүгээс эдгээр хөдөлгөөнүүдийг дэмжиж буйд Засгийн газар таагүй хандаж байгааг илчилж байна.

Хэвлэл мэдээллийн салбарт зарим ТББ чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх урт хугацааны зорилттой ажиллаж байна. МХХ, “Глоб Интернэшнл” ТББ энэ салбарт гол үүрэг гүйцэтгэж байна. Янз бүрийн ТББ, ХМХ-д энэ салбарын олон тооны хандивлагч дэмжиж, тусалж байна. 1990-ээд оны дундуур ДАНИДА ихээхэн хэмжээний тусламж үзүүлж. МХХ, “ЧХС” хэвлэх үйлдвэр байгуулахад их нөлөө үзүүлсэн юм. Гэвч чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хөгжил бие даасан, тогтвортой болохоос өмнө тусламжаа татсан анхны байгууллагын дотор ДАНИДА бас байв. Өнөөгийн байдлаар ЮНЕСКО, Америкийн хувийн сангууд голлох хувь нэмэр оруулж, хандивлагчдын дэмжлэг буурчээ. Ямартай ч, хэвлэл мэдээллийн янз бүрийн үйл ажиллагааг дэмжиж буй жижиг хандивлагчид байгаа хэдий ч, үйл ажиллагааны идэвхтэй өсөлт зохицуулалтад, аав эсвэл жинхэнэ хүсэл алга ааеí à.

5.1.1 Монголын Хэвлэлийн Хүрээлэн /МХХ/

Танилцуулга

МХХ нь ДАНИДА-гийн “Монгол дахь чөлөөт хараат бус хэвлэл мэдээлэл” төслийн хүрээнд 1995 онд байгуулагдсан.

МХХ-ийн зорилго:

- Монголд хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийн хөгжлийг хөхиүлэн дэмжих,
- Монголын хэвлэл мэдээллийн ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг, дээшлүүлэх,
- Монголын хэвлэл мэдээллийн хөгжилд дүн шинжилгээ хийж, түүний талаар бодит, найдвартай мэдээлэл түгээх, хэвлэл мэдээллийн талаар шинжлэх ухааны үндэстэй мэдээлэл солилцохыг хөхиүлэн дэмжих,
- Улс орны нийгэм, эдийн засаг, оюуны амьдралд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг олон нийтэд тайлбарлан таниулах

Сургалт

МХХ нь зургаан сарын дипломын курс, хүрээлэнгийн дэргэдэх Данийн Сэтгүүл зүйн сургуультай хамтран бакалаврын зэрэг олгох дөрвөн жилийн сэтгүүл зүйн сургалт, ЮНЕСКО-гийн санхүүжилттэй дижитал тоног төхөөрөмжид суурилсан фото сэтгүүл зүйн курс гэх мэт урт, богино хугацааны сургалт зохион байгуулдаг. Хэвлэл мэдээллийн чиглэлээр шинээр төгсөгчид сэтгүүл зүйн жинхэнэ ажлын практик дадлагагүй байдаг гэж хэвлэл мэдээллийн хэрэгслийн олонх эздийн шүүмжлэлийг үндэслэн онолоос илүү дадлага давамгайлсан сургалт явуулахад анхаарлаа чиглүүлдэг. Байгуулагдсанаасаа хойшхи арван жилийн хугацаанд МХХ ойролцоогоор 500 гаруй сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор таван мянга гаруй сэтгүүлчийг хамруулжээ.

Хэвлэл мэдээллийн судалгаа

МХХ 1999 онд байгуулагдсанаасаа хойш Монголын хэвлэл мэдээллийн салбарын тухай статистик мэдээлэл агуулсан “Монголын хэвлэл мэдээллийн мониторингийн судалгаа” тайланг жил бүр гаргаж байна. Хамгийн сүүлийн тайланд аймгуудын хэвлэл мэдээллийн төлөв байдлын тасралтгүй өөрчлөлтийн цөөн хэсэг нь бүртгэгдээгүй ч судалгаа баталгаатай ажээ.

2003 онд МХХ төвийн хэд хэдэн телевиз, бизнесийн байгууллагатай Хамтарсан Зөвлөл байгуулан, тэдний гишүүнчлэлийн орлогоор санхүүждэг Хэрэглэгчийн тогтмол судалгааг хийж эхэлжээ. Судалгаанд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Багануур, Налайх, Зуун мод гэх мэт хотыг хамардаг. Судалгааны тайланг хэвлэл мэдээллийн 15 эзэн, зар сурталчилгаа олгогч, бусад сонирхсон этгээдэд сар бүр борлуулдаг.

“Ийгл” телевиз саяхан МХХ-ийн хэрэглэгчийн судалгааны тайланг ашиглан, “хотод хамгийн олон үзэгчтэй мэдээ бэлтгэдэг телевиз” хэмээн өөрийгөө сурталчилжээ. Үүнийг ТВ-9 эсэргүүцсэн байна.

Нэг талаас, энэ нь өөрөө маш эерэг дэвшил $i^o \ i \ ч$, МХХ нь ТББ-ын хувьд гадаад, дотоод дарамтаас ангид байдаггүйн жишээ юм. ТВ9 телевизийн захирал Ц.Энхбат МХХ-ийн хуучин захирал байсан, одоо ч Удирдах Зөвлөлийн даргаар ажиллаж МХХ-г судалгааны дүн мэдээгээ өөрчил гэсэн дарамт үзүүлдэг ааёжээ. МХХ энэ дарамтад авталгүйгээр мэдээллийнхээ шударга, үнэн, зөвийг хамгаалсан байна.

МХХ одоо орлогынхоо 70 хувийг сургалт, судалгааны үйл ажиллагаанаас олдог. Энэ нь удирдлагыг төслийн санхүүжилт олоход хүчин чармайлт тавихыг шаарддаг.

МХХ-ийн хэрэгжүүлсэн төслөөс дурдвал, “Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэл” (ДАНИДА, 1995-1999 он), “Үндэсний хэмжээнд мэдээллийн чөлөөт урсгалыг бий болгох” (НҮБ-ийн ХХ, 1996-1999 он), “Ардчилал ба сэтгүүл зүй” (НҮБ-ын ХХ, 1997-2000 он), “Хариуцлагатай, олон ургальч хэвлэл мэдээлэл ба сэтгүүл зүйн мэргэжлийн стандарт” (ТАСИС, 1995-1999 он), “Монгол дахь хэвлэл мэдээлэл ба сэтгүүл зүй” (ДАНИДА, 1999-2002 он) зэрэг төсөл байна.

5.1.2 “Чөлөөт Хэвлэл” Сан Хэвлэх Үйлдвэр

“Чөлөөт Хэвлэл” Сан Хэвлэх Үйлдвэр 1996 онд ДАНИДА-ийн “Монгол дахь чөлөөт, хараат бус хэвлэл” төслийн хүрээнд байгуулагдсан. Хэвлэх үйлдвэр нь хувийн жижиг хэвлэх үйлдвэртэй орчинд боломжийн үнээр үйлчилж болжээ. Хэвлэх үйлдвэр нь улс төр, хөндлөнгийн нөлөөнөөс ангид ажиллан, эхэн үедээ Улаанбаатар хотод хэвлэгдэн гарч байсан нийт сонин хэвлэлийн 90 гаруй хувийг хэвлэж, өрсөлдөөн бага тул өндөр ашиг олдог байжээ.

Одоо ЧХС хэвлэх үйлдвэр оршин тогтноход улам хүндрэлтэй болж байна. Хувийн шинэ хэвлэх үйлдвэрүүд хямд үнэ санал болгодог. Дээр нь ЧХС хэвлэх үйлдвэр 1996 онд байгуулагдснаас хойш үнэ тарифынхаа бүтцийг өөрчлөхийг зөвшөөрөхгүй байв. Сонины цаасны үнэ бага багаар нэмэгдсээр байгаад сүүлийн хэдэн жилд 40 хувьд хүрчээ. Үүнээс үл хамааран ЧХС хэвлэх үйлдвэр одоо Монгол улсад хэвлэгдэж буй сонины тоо ширхгийн 60 хувийг, нийт сонины нэрээр бодвол 75 хувийг хэвлэж байна.

Орон нутгийн сонин хэвлэлүүд ЧХС хэвлэх үйлдвэрийн хэвлэх хүчин чадал, эх бэлтгэлийн үйлчилгээнд итгэж найддаг. Гэхдээ нэг дугаарын хэвлэгдэх доод хэмжээ 500 хувь, хэвлэлтийн зардал нь тэдний хувьд өндөр байдаг тэд сэтгэл дундуур ажээ. Учир нь, 500 хувь гэдэг тоо орон нутгийн хувьд арай абаацай ойт.

Цөөн хэдэн аймагт жижиг хэвлэх үйлдвэр ажилладаг ч, сонины уламжлалт хэмжээгээр хэвлэх боломжгүй учир хөдөөд хэвлэлийн хүчин чадал бүхий үйлдвэртэй болж болвол туйлаар талархах болно гэж сонины эзэд ярьж байв.

5.1.3 “Глоб Интернэшнл” ТББ

“Глоб Интернэшнл” нь 1999 онд байгуулагдсан, ашгийн бус, төрийн бус байгууллага юм. Одоогоор долоон ажилтантай. “Глоб Интернэшнл” ТББ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон нийтийн өргөн нэвтрүүлэг, ардчилсан сонгууль, ерөнхийдөө хүний эрхийн асуудалд гол анхаарлаа хандуулж, хууль эрх зүйн орчноор онцгой туршлага хуримтлуулжээ.

“Глоб Интернэшнл” ТББ 2002 онд “Мэдэх эрх: Мэдээллийн эрх чөлөө” хөтөлбөрийг санаачилсан байна. Мөн “19-р зүйл” байгууллагатай хамтран үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад задлан шинжилгээ хийжээ. Төгсгөлд нь дурдахад, Засгийн газар 2006 онд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг өргөж барьсан. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсан.

2004-2005 онд ЮНЕСКО-гийн санхүүжилтээр “Авилга хүн бүхэнд халгаатай” хэвлэл мэдээллийн аянг үндэсний хэмжээнд явуулсан. Тус байгууллага 2005 онд “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр Сенегалд болсон хуралд ЮНЕСКО-гийн урилгаар “Монгол дахь хэвлэл мэдээлэл, сайн засаглал” илтгэл тавьжээ.

2005 онд “Азийн эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийг IFEX-тэй түншлэн хэрэгжүүлж эхэлжээ. Зоригтой сэтгүүлчид аюул түгшүүртэй нөхцөл байдлыг өөрсдөө ойлгож мэдэрдэг. Одоохондоо, уг ТББ дарамт шахалтад өртсөн сэтгүүлч, ялангуяа орон нутгийн сэтгүүлчдэд зохих дэмжлэг үзүүлж чадаагүй байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг тулгамдсан асуудлуудын

тухай хангалттай ойлголт өгөхгүй байж магадгүй, уг төсөл нь нөхцөл байдлыг сайжруулахад нэг их нөлөөлөхгүй.

“Глоб Интернэшнл” ТББ үйл ажиллагааныхаа явцад монгол, англи хэл дээр олон тооны хэвлэл нийтлэл гаргасныг вэбсайтаас нь үзэж болно.

5.1.4 “Нээлттэй Нийгэм Форум” ТББ

Нээлттэй Нийгэм Форум (ННФ) нь Соросын Сангийн Сүлжээний бүтцэд багтдаг, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнг өв залгамжлан үлдсэн. ННФ нь 2004 онд ТББ-ын статусаар байгуулагдсан, Ардчилсан засаглал, эдийн засгийн бодлого гэсэн үндсэн хоёр салбарт төвлөрч ажилладаг. Үүний багахан хэсгийг нь “үнэн зөв, бодит, тэнцвэртэй мэдээллээр хангагч, олон нийтийн хоточ нохойнх нь хувьд хэвлэл мэдээллийн ардчилсан нийгэмд гүйцэтгэх үүргийг баталгаажуулахад туслах зорилго бүхий хэвлэл мэдээллийн хөтөлбөр” эзлэдэг байна.

Урьд өмнө нь, хэдэн жилийн турш Соросын сан байгуулагдсанаас хойш Монгол улсад чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд харамгүй дэмжлэг үзүүлж байжээ. Харин одоо тэдний санхүүжилт ННФ-д нь төвлөрч, хэвлэл мэдээллийн дэмжлэг эрс буурч байна. 2004, 2005 онд ННФ орон нутгийн радионуудад нэвтрүүлэг солилцох, олон нийтийн өргөн нэвтрүүлгийн өмгөөлөл, олон нийтийн хэд хэдэн уулзалт зэрэг хэвлэл мэдээллийн төрөл бүрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна. ННФ нийгэм, улс төрийн асуудлаар цуврал ток шоу нэвтрүүлэг хийсэн. Эдгээр нэвтрүүлгийг төрийн өмчийн телевизийн оргил цагаар үзүүлж байв.

ННФ нь санхүүжилт сайтай, өндөр чадвартай боловсон хүчинтэй ч хэвлэл мэдээллийн салбарт туршлага багатай, хэвлэл мэдээллийн асуудал нь бусад зорилтуудынхаа дараа хоёр дугаарт тавигддаг.

5.1.5 “Монголын Сонин ба Мэдээллийн Холбоо” ТББ

Монголын Сонин ба Мэдээллийн Холбоо нь Монголын асуудлуудын тухай мэдээ хараат бус, тэнцвэртэй мэдээллийн өөрийн www.moninfo.org вэбсайтаар түгээдэг. Хэтийн зорилго нь:

Сонин ба мэдээллийн холбоо төрийн бус байгууллага нь сэтгүүл зүйн сургалт, сэтгүүл зүйн нөөц бололцоог бүрдүүлэх, оюутнуудыг дадлагажуулах замаар Монголын сэтгүүл зүйн өргөн хүрээтэй шинэтгэлд оролцох.

“Монголын Сонин ба Мэдээллийн Холбоо”-ны хэвлэл мэдээллийн хөгжлийн төслийн нэг нь бусад ТББ, хандивлагч байгууллагуудын хооронд дунд мэдээлэл солилцооны талбар бий болгох төсөл ажээ.

Монголын Сонин ба Мэдээллийн Холбоо хэвлэл мэдээллийг хөгжлийн төлөө ажилладаг ТББ,, сэтгүүлчдэд зориулсан сургалт явуулдаг ТББ-ын төлөөлөгчдийн сар бүрийн цуврал уулзалтыг санаачлан, зохион байгуулсан юм. Уулзалт мэдээлэл харилцааны суваг бий, Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбар дахь асуудал, бэрхшээлийг тодорхойлох, урт хугацааны зорилтдоо хүрэхийн тулд хэвлэл мэдээлэлтэй, мөн бие биетэйгээ үр дүнтэй ажиллах арга замыг тодорхойлох зорилготой. Үүнд, “Глоб интернэшнл” ТББ, Монголын Хэвлэлийн Хүрээлэн, Нээлттэй Нийгэм Форум, Хүний Эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ийн ХХ, НҮБ-ийн ХАС, Швецарийн хамтын ажиллагаа, хөгжлийн агентлаг, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз зэрэг байгууллага оролцжээ.

5.1.6 ЮНЕСКО

ЮНЕСКО хэдэн жилийн турш Хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд холбоотой олон цуврал төслийг дэмжжээ. Үүнд, олон нийтийн захиргааны ил тод байдал, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрхийн тухай гарын авлага, үндэсний цөөнхийн асуудал, тухайлбал өмнө дурьдагдсан, казах нутгийн уугуул иргэдэд гэх мэт үндэсний цөөнхийг дэмжсэн цөөнхөд зориулсан төсөл, сургалт багтана. Цаашилбал, ЮНЕСКО-гоос илүү сайн мэдээлэлд тулгуурласан шинэ санаачлага өрнүүлэхийн тулд Хэвлэл Мэдээллийн салбарын төлөв байдлын энэ судалгааг санхүүжүүлсэн юм.

ЮНЕСКО-гоос хэвлэл мэдээллийн салбарт хэрэгжүүлсэн төсөл:

“МХХ дэх Гэрэл зургийн сэтгүүл зүйн сургалт ба гэрэл зургийн лаборатори” (2005 оны 11 сараас 2006 оны 3 сар), “Хэвлэл мэдээлэл ил тод засаглалын төлөө” (2004 оны 10 сараас 2005 оны 10 сар), “Сэтгүүлчдэд зориулсан практик зөвлөмжүүд” орчуулга, хэвлэлт (2006 оны 5 сарын 20-оос 7 сарын 10), “Монголын Үндэсний Радио, Телевизийн Үйлчилгээг сайжруулах нь” (2003-2004 он), “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хөгжүүлэх нь” (1999-2001 он), “Мэдээллийн МОНЦАМЭ агентлагт шинэчлэл хийх нь” (1985-1986 он) “Монголын Үндэсний Радио, Телевизийн ажилтнуудын сургалт” (1997-1998 он), “Хэвлэлийн үйлдвэрлэлийн шинэчлэл” (1995 он), “Улсын хэвлэл үйлдвэрийн сургалтын төв” (1988-1990 он).

5.1.7 Бусад

Улаанбаатар дахь гадаадын элчин сайдын яамд, Конрад Аденауэрын сан, Дойчэ-Вэле, Канад сан, Австралийн Хамтын ажиллагаа, хөгжлийн агентлаг, Дэлхийн банк, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний сүлжээ (IFEX) зэрэг идэвхтэй хандивлагч байгууллагууд байна. Одоо хандивлагчдын дэмжлэг олон талтай. Харин гол төлөв, хэвлэл мэдээллийг татан оролцуулах нь төслийн нэг л хэсэг болжээ. Тухайлбал, энэ нь

мэдээлэл харилцааны төсвийнх нь нэг хэсэг ажээ. Эдгээр нь хэвлэл мэдээллийн салбарын хөгжлийн асуудалд шууд хамаарахгүй төслүүд юм.

Хандивлагчдын үйл ажиллагааны хоорондын зохицуулалт муу бололтой. “Монголын Сонин ба Мэдээллийн Холбоо” ТББ-аас энэ хийдлийг нөхөхөөр зорьж байна.

6. АЙМГУУДЫН ЕРӨНХИЙ СУДАЛГАА

6.1. ДОРНОД АЙМАГ:

Нутаг дэвсгэр: 123,600 км²
Хүн ам: 73,400
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 1097,0 төгрөг

6.1.1. Үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн хэрэгслүүд

Сонин

Үндэсний хэмжээний сонин нь захиалгын үндсэн дээр Улаанбаатар хотоос онгоцоор долоо хоногт хоёр удаа, машинаар нэг удаа ирнэ. Шуудан холбооны газраар дамжуулан шууд борлуулдаг. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл.

Хамгийн олон захиалагчтай сонин

Өдөр тутмын бус сонин

“Хүмүүс”
“Сэрүүлэг”
“Зиндаа”

Өдөр тутмын сонин

“Зууны мэдээ”
“Өдрийн сонин”

Эх сурвалж: шуудан холбооны ажилтан

Телевиз

Үндэсний таван сувгийг кабелиар хүлээн авах боломжтой. Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ-5/ТВ-9 болон UBS/25 äóãàä суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг сансрын холбоогоор өнжөөд нэг солбиж үзнэ.

6.1.2. Орон нутгийн ХМХ

Телевиз

“Шинэ суваг” ТВ
Захирал: С.Дэлгэр

Гурван цагийн өргөн нэвтрүүлгийг 19.00-22.00 цагийн хооронд газрын хүлээн авах, дамжуулах станцаар, орон нутгийн Хэрлэн, Цацраг кабелийн телевизийн сувгийн аль алианаар дамжуулдаг. Сансрын холбоо ашигладаггүй. Өргөн нэвтрүүлгийг зөвхөн аймгийн төвд цацна. “Шинэ суваг” телевиз нь орон нутгийн кабелийн суваг ашигласны төлбөр төлнө.

“Шинэ суваг” телевиз 2001 онд байгуулагдсан, орон тооны хоёр ажилтантай. Оюутнууд хагас цагаар тусалдаг. Телевизийн захирал нь МХХ-ийн сургалтад хамрагдсан. Телевизийг байгуулсан эхний үед тэрээр орон нутгийн засаг захиргааны зүгээс улс төрийн шахалт хавчлагад өртөж, тоног төхөөрөмжөө нэг жил шахам хугацаанд хураалгасан байна. Асуудал одоо шийдвэрлэгдэж, нутгийн засаг захиргаа түүнийг зөнд нь орхисон ажээ.

Хөтөлбөр нь, орон нутгийн мэдээ, орон нутгийн захиргаа, бизнесийн зарлал, зохиогчийн зөвшөөрлийг аваагүй уран сайхны кино, эмгэнэл, дэлгэц дээр өгсөн тайлбарыг далдаас унших зэргээс бүтнэ. Түүнчлэн хүүхдийн нэвтрүүлгийг Их Британы “Хүүхдийг Ивээх сан”-гийн санхүүгийн дэмжлэгээр орон нутагтаа бэлтгэж, сард хоёр удаа цацдаг.

Телевизийг гол төлөв сонгуулийн үед улс төрийн нам, нэр дэвшигчид, бусад үед газар өмчлөгч, ажлын байр санал болгогчид үндсэн зар сурталчилгаагаар хангагчид байна. Улс төрчид төлбөртэй зарлал явуулдаг.

“Хэрлэн” ТВ

“Хэрлэн” телевиз нь “Хэрлэн” кабелийн телевизийн бүтцэд багтдаг. Орон нутгийн нэвтрүүлгийн цаг нь тогтмол бус.

Кабелийн сүлжээ

“Хэрлэн” КаТВ

“Хэрлэн” кабелийн телевизийг 2005 оны 5 сард Цахилгаан Холбооны газрын дарга Л.Баярмагнай байгуулсан. Одоо захирлаар нь Д.Дариймаа ажилладаг. Орон тооны таван ажилтантай. 1800 хэрэглэгчтэй. Долоо хоногийн зургаан өдөр монгол, орос, DW, Arirang зэрэг 20 сувгийг дамжуулдаг.

Орон сууцны хэрэглэгчийн сарын хураамж 1800 төгрөг.

“Цацраг” КаТВ

600 хэрэглэгчтэй, 30 сувагтай.

Гэр хорооллын хэрэглэгчийн сарын хураамж 2500 төгрөг.

Радио

“Талын Монгол” ФМ-107.5

Захирал: С.Бадарч,

Өргөн нэвтрүүлгээ 08:30-23:00 цагийн хооронд дамжуулдаг. Хоёр хөтлөгч нь ангилсан зар мэдээг хоёр цаг тутам дамжуулдаг. Өдрийн хөгжмийн хөтөлбөрийн дууг мөн өөрсдөө сонгож явуулна. 2003 онд “Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага” хөтөлбөр бусад хувийн хөрөнгө оруулагчдын дэмжлэгээр байгуулагдсан.

Захирал нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын хэрэгжүүлж буй “Пакт Монгол” ᠔᠐᠔᠐᠑᠗᠑᠑ “Хөдөөгийн бизнес мэдээ” сонинд ажиллаж байсан. Саяхан ЮНЕСКО-ийн холын зайны сургалтад хамрагдсан.

Монголын Үндэсний Радио/Бүсийн Олон Нийтийн Радио

Захирал: С.Бадарч

“Талын Монгол” ФМ-107.5-ын захирал нь Монголын Үндэсний Радио/Бүсийн Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг явуулдаг.

Бүсийн Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг долоо хоногийн Мягмар, Баасан гарагийн 9.30-10.00 цагийн хооронд Монголын Үндэсний Радиогийн сувгийг ашиглан дамжуулдаг. Хөтөлбөр нь, орон нутгийн мэдээ, зарлал, орон нутгийн засаг захиргааны мэдээ зэргээс бүтнэ. Тэрээр Монголын Үндэсний Радиогоос цаг түрээсэлж, зар сурталчилгаа, төлбөрт нэвтрүүлгээс олсон орлогоор зардлаа нөхдөг.

Сонин

“Дорнод” сонин

Эрхлэгч: Б.Туяа

Сонин нь “Эгэл” ХХК (Орон нутгийн Сонинуудын Нэгдсэн Холбоо)-нд харъяалагддаг. Тэд хэвлэх үйлдвэрт хэвлүүлэх, Улаанбаатарт зар худалдах зэрэгт зохион байгуулалтын туслалцаа үзүүлдэг. Гэхдээ сонин нь хараат бус ажиллаж, ашгаа өөртөө авдаг.

600 хувиар сард гурван удаа хэвлэгддэг. Дизайнертай нийлээд орон тооны дөрвөн ажилтантай. Сонины ихэнх хувийг аймгийн төвд, үлдсэн хэсгийг 13 суманд тус бүр хорь орчим хувиар түгээдэг. Түүнийг МХХ-ээс 2003, 2004 онд “Оны шилдэг орон нутгийн сонин”-оор хоёр удаа шалгаруулж байжээ.

Сонины бүх хувийг захиалгаар нийлүүлдэг. Зөвхөн Шуудан Холбооны газар дээр борлуулдаг. Хувийн худалдааны жижиг цэгүүдээр сониноо борлуулбал уншигчид захиалахаа больж, улмаар захиалагчийн тоо буурна гэж айдаг тухайгаа Б.Туяа ярьсан.

“Дорнод” сонины улирлын захиалгын үнэ 2700 төгрөг.

“Дорнодын хүүхдүүд” сонин

Эрхлэгч: М.Одгэрэл

“Дорнодын хүүхдүүд” сонин нь хүүхдэд зориулсан, хоёр долоо хоног тутам гардаг. М.Одгэрэл Их Британы “Хүүхдийг Ивээх Сан”-гийн санхүүжилтээр байгуулсан. 1000 хувиар хэвлэгддэг. Улирлын захиалгын үнэ 1800 төгрөг.

“Дорнод таймс” сонин

Ардчилсан намаас гаргаж байсан энэ сонин татан буугдсан.

Интернэт/ Үүрэн телефон

Интернэт

12 сургуулийн тав нь интернэтэд холбогдсон.

Micom 80 + байгууллагууд (Монголын Цахилгаан холбоо)

“Дорнод NET” 20 + байгууллагууд; 20 + өрхүүд (орон нутгийн)

“Дорнод Тэмцэл” (энэ талаар мэдээлэл байхгүй) (хувийн)

Үүрэн телефон

Аймгийн төвийн оршин суугчдын 20 хувь буюу 10,000 үүрэн телефон хэрэглэгчтэй. Үүрэн телефоны Юнител, Мобиком, Скайтелын үйлчилгээ нэвтэрсэн.

6.1.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Сүүлийн нэг жилд хэвлэлийн эрх чөлөөнд халдсан зарим нэг зөрчил гарсан байна. “Дорнод” сонин нэг дугаартаа сэтгүүлчтэй хамт нэг байшинд амьдардаг орон нутгийн төрийн албан хаагчтай холбоотой авилгыг шүүмжилсэн нийтлэл бичжээ. Нийтлэлийг бичихээс өмнө, бичсэний дараа түүнд дурдагдсан этгээд сэтгүүлч рүү заналхийлсэн мессежийг удаа дараа илгээж байжээ. Уг хэрэг “Глоб Интернэшнл” ТББ-д шуурхай мэдээлэгджээ.

Сургалт, харилцаа холбоогоор дутмаг гэж болно. Урьд нь МХХ жил бүр сургалт явуулж байсан. Өнгөрсөн жил МХХ-гээс ямар нэг сургалт зохион байгуулаагүй байна.

6.2 СҮХБААТАР АЙМАГ

Нутаг дэвсгэр: 82,900 км²

Хүн ам: 52,400; аймгийн төв Баруун-Уртад 14,000

Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 1288,3 төгрөг

6.2.1. Үндэсний ХМХ

Сонин

Аймгийн төвд өдөр бүр Улаанбаатараас сонин хэвлэл ирдэг. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл. Сумдад долоо хоногт хоёр удаа машинаар хэвлэлээ хүргэдэг.

Хамгийн олон захиалагчтай сонин

Өдөр тутмын бус сонин

“Хүмүүс”

“Зиндаа”

“Сэрүүлэг”

Өдөр тутмын сонин

“Өдрийн сонин”

“Зууны мэдээ”

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн телевиз, мөн ТВ-5/ТВ-9 болон UBS/25 2003 онд суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

6.2.2. Орон нутгийн ХМХ

“Талын долгион” Телевиз

Захирал: С.Батсайхан

Орон нутгийн телевиз нь коммунист дэглэмтэй байсан 80-аад онд орон нутгийн засаг захиргааны санхүүжилтээр байгуулагдсан ч, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай 2002 онд батлагдсанаар үйл ажиллагаа нь зогсчээ.

Тэнд ажиллаж байсан С.Батсайхан 2003 оны 1 сард сараас телевизийг дахин ажиллуулж эхэлжээ. Тэрээр “Залуучуудын Холбоо” ТББ-ын тэтгэлэг, УИХ-ын гишүүнээс зээлээр, орон нутгийн засаг захиргаанаас телевизийн тоног төхөөрөмжийг түрээслэн авч, ажлаа эхэлсэн байна.

Өргөн нэвтрүүлгээ Бямба, Ням гарагийн 09.00-11.00 цагийн хооронд дамжуулдаг. Ням гарагт урд өдрийнхөө хөтөлбөрийг давтана. Орон нутгийн мэдээ, засаг захиргааны зарлал, түүнчлэн ТВ-5, ТВ-9 телевизийн өргөн нэвтрүүлгийг дамжуулдаг. Дамжуулалтын радиус 20 км.

Телевиз ЗДТГ-ын байранд байрладаг. Гурван ажилтантай. 2003, 2005 онд МХХ-ийн сургалтад хамрагдсан. Орон нутгийн засаг захиргааны төлбөртэй мэдээ, бизнес мэдээ, зар мэдээний орлогоор ихэвчлэн санхүүждэг.

Кабелийн сүлжээ

Одоогоор кабелийн сүлжээгүй. Кабелийн өргөн нэвтрүүлэгтэй болох сонирхолтой ч санхүүжилт хомс, хэрэглэгчийн тоо цөөн байдаг нь гол хүндрэл гэж орон нутгийн албан тушаалтнууд ярьж байлаа.

Сонин

“Шинэ Сүхбаатар” сонин

Эрхлэгч: С.Амартайван

“Шинэ Сүхбаатар” сонинг 2000 онд Ардчилсан намын гишүүн, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Амартайван байгуулжээ. 1000 хувиар, сард нэг удаа хэвлэгддэг. ЗДТГ (МАХН)-ын байранд байдаг.

Засаг захиргааны төлбөртэй нийтлэл, олон улсын байгууллагын төслүүд, зар мэдээний орлогоор санхүүждэг. Нэг нүүр нь 100000 төгрөг. 1000 хувь хэвлүүлэхэд 126000 төгрөг зардаг. Үүн дээр тээврийн зардал нэмэгдэнэ. Сонгуулийн үеэр зар сурталчилгааны орлого тогтмол өсөлттэй байдаг.

С.Амартайван Улаанбаатар хотод 6 сарын хугацаагаар Удирдлагын Академийн Орлогоор бодлогын хэлтсийн дарга С.Амартайван байгуулжээ. 1000 хувиар, сард нэг удаа хэвлэгддэг. ЗДТГ (МАХН)-ын байранд байдаг. Засаг захиргааны төлбөртэй нийтлэл, олон улсын байгууллагын төслүүд, зар мэдээний орлогоор санхүүждэг. Нэг нүүр нь 100000 төгрөг. 1000 хувь хэвлүүлэхэд 126000 төгрөг зардаг. Үүн дээр тээврийн зардал нэмэгдэнэ. Сонгуулийн үеэр зар сурталчилгааны орлого тогтмол өсөлттэй байдаг.

С.Амартайван Улаанбаатар хотод 6 сарын хугацаагаар Удирдлагын Академийн Орлогоор бодлогын хэлтсийн дарга С.Амартайван байгуулжээ. 1000 хувиар, сард нэг удаа хэвлэгддэг. ЗДТГ (МАХН)-ын байранд байдаг. Засаг захиргааны төлбөртэй нийтлэл, олон улсын байгууллагын төслүүд, зар мэдээний орлогоор санхүүждэг. Нэг нүүр нь 100000 төгрөг. 1000 хувь хэвлүүлэхэд 126000 төгрөг зардаг. Үүн дээр тээврийн зардал нэмэгдэнэ. Сонгуулийн үеэр зар сурталчилгааны орлого тогтмол өсөлттэй байдаг.

Радио

“Талын цуурай” ФМ радио

Захирал: Д.Мөнхбат

“Талын цуурай” ФМ радио 2002 онд Соросын сангийн санхүүжилтээр байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 09.00-20.00 цагийн хооронд дамжуулдаг. Гол төлөв дуу хөгжим, ток-шоу нэвтрүүлэг бэлтгэж явуулдаг. Мягмар, Пүрэв гарагийн шөнө нээлттэй сэдвээр, тухайлбал, гудамжны гэрэлтүүлгийн хулгайн асуудлаар шууд ярилцлага гэх мэт, Бямба гарагт дууны уралдаан явуулдаг.

Төлбөрт нэвтрүүлэг, зарлал, зар мэдээ, түүнчлэн шууд утас, дуу захиалгын орлогоор санхүүждэг. Зарлалын нэг үг 15 төгрөг байснаа сонгуулийн үед нэг минут нь 300 төгрөг болтлоо өсч байжээ. Өдөрт дунджаар, 200000 төгрөгийн орлого олдог.

Орон тооны хоёр ажилтантай. Ярилцлага өгсөн хөтлөгч орон тооны ажилтан болохоосоо өмнө уг радиод дадлагажигчаар ажиллаж байжээ. Тэрээр Улаанбаатар хотод спортын чиглэлээр сурч байсан ч, дуу хөгжим сонирхдог юм байна.

Интернэт/ Үүрэн телефон

Үүрэн телефон

Мобиком, Юнител, Скайтелийн сүлжээтэй. Сүлжээ аймгийн төв, гурван суманд барьдаг. Скайтелийн 4000 хэрэглэгчтэй.

Интернэт

Энэтхэгийн засгийн газрын санаачлагаар байгуулагдсан интернэт кафе ЗДТГ-ын байранд ажилладаг. Монголын Цахилгаан Өй Ажлын Компаний салбар интернэт кафетай. Мөн хоёр сургууль интернэтэд холбогджээ.

6.2.3. Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Хэвлэл мэдээлэл нь Орон нутгийн засаг захиргааны гар хөл болсоор байгаа ажээ. Тэдгээр нь ЗДТГ-ын байранд байдаг. Үг хэлэх эрх чөлөөний зөрчлийн талаар мэдээлэл байхгүй. Юу бичих тухайгаа байнга заалгадаг байсан коммунист тогтолцооны үед бэлтгэгдсэн орон нутгийн ихэнх сэтгүүлч төлбөрт нийтлэлийг хүлээн зөвшөөрдөг. Залуу үеийнхэн Хэвлэлийн эрх чөлөөний тухай мэдлэгтэй ч туршлагагүй ажээ. Зөвхөн дуулсан шуугиантай мэдээг сонирхож, баримт сэлтийг шалгахгүйгээр цуурхал тараадаг нь хуучин, шинэ залуу сэтгүүлчдийн гол ялгаа гэж нэгэн сэтгүүлч ярьсан юм.

6.3 ХЭНТИЙ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 82,000 км²
Хүн ам: 68,100; аймгийн төв Өндөрхаанд 17,300
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 1868,5 төгрөг

6.3.1 Үндэсний ХМХ

Сонин

Сонин хэвлэлийг хэвлэгдсэнийх нь маргааш, өдөр бүр автобусаар хүргэдэг.

Хамгийн олон захиалагчтай сонин

Өдөр тутмын бус сонин

“Хүмүүс”
“Зиндаа”
“Сэрүүлэг”

Өдөр тутмын сонин

“Өдрийн сонин”

“Зууны мэдээ”

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ-5/ТВ-9 болон UBS/25 аймаг суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

Кабелийн телевиз 14 сувагтай.

6.3.2 Орон нутгийн ХМХ

Телевиз

“Санбүрд” ТВ

Захирал: Р.Наранчимэг

“Санбүрд” телевизийг Б.Пүрэвбанзрагч 2004 онд байгуулжээ. Гурван сэтгүүлч, бусад ажилтан гээд нийт 14 ажилтантай. Өдөрт 10 цагийн өргөн нэвтрүүлэг явуулдаг. Ням гарагт дөрвөн цагийн мэдээний хөтөлбөр, үлдсэн цагт нь уран сайхны кино, цэнгээнт нэвтрүүлэг, зар сурталчилгаа явуулна. Телевизийн эзэн, хөрөнгө оруулагч нь Улаанбаатар хотод амьдардаг, МАХН-ын гишүүн юм. 2004 оны сонгуулийн үеэр байгуулагдсан, “Санбүрд” кабелийн телевизийн бүтцэд багтдаг. Нэг байранд байдаг.

Кабелийн сүлжээ

“Санбүрд” КаТВ

1500 хэрэглэгчтэй. Монгол сувгуудтай нийлээд 14-16 сувагтай. Сарын хураамж 2900 төгрөг. Мөн “Санбүрд” телевизийг өмчилдөг.

Сонин

“Хэнтийн сонин” сонин

Эрхлэгч: И.Байгальмаа

“Глоб Интернэшнл” ТББ-ын зүүн бүсийн шуурхай мэдээний сурвалжлагч

“Хэнтийн сонин” сонин 2002 онд байгуулагдсан. 500 хувиар хэвлэдэг. 100 захиалагчтай. Урьд нь “Хэнтийн сонин” сард 2-3 удаа хэвлэгддэг байжээ. Гэвч санхүүгийн хүндрэлээс болж зар сурталчилгаа, төлбөрт материалаа 2 нүүрний хэмжээнд хүрэхээр нь л хэвлүүлж байна. Засаг

захиргааг нь мөнгөөг эзэр авч, бусдын захиалгаа баталгаажуулдаг.

“Зөвхөн захиалгын орлогод найдаж үйл ажиллагаагаа явуулснаас сонин зогсонги байдалд орсон” гэж И.Байгальмаа ярих. Гол зардал нь хэвлэлтийн зардал. Аймагт хэвлэх үйлдвэргүй учир Улаанбаатар хотод өндөр зардлаар хэвлүүлж, бүх мөнгөө шавхдаг тухай И.Байгальмаа цохон хэлж байлаа.

И.Байгальмаа нь “Глоб Интернэшнл” ТББ-ын зүүн бүсийн шуурхай мэдээний сурвалжлагч, МХХ-ийн зохицуулагч, нэлээд олон сургалтад хамрагджээ. Тэрээр орон нутгийн сэтгүүлчдийн манлайлагч болох нь харагдаж байлаа.

“Урагшаа” сонин

Эрхлэгч: Д.Аюурбунь

“Урагшаа” сонинг орон нутгийн засаг дарга Н.Ням-Осор 2004 онд ТББ-ын статустай байгуулжээ. Энэхүү тайланг бичих үед, засаг захиргааны мэдээллүүд нийтлэгдсэн хоёр дугаар гарсан байлаа. Өөр нэгийг Ардчилсан намд талтай гэлцдэг.

Радио

“Дөлгөөн хэрлэн” ФМ 106.2

Захирал: Б.Адъяахүү

“Соросын сан”-гийн тусламжаар 2002 онд байгуулагдсан. “Дөлгөөн хэрлэн” ФМ, Сүхбаатар аймгийн “Талын Цуурай” ФМ радиог байгуулахад нийт 40,000 ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 07:00-23:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөр нь, орон нутгийн, үндэсний мэдээ, цаг тутмын цэнгээнт нэвтрүүлэг зэргээс бүтнэ. “Төлбөрт нэвтрүүлэг, зарлал, зар мэдээнээс сард 300 орчим ам.долларын орлого олдог” гэж радиогийн эзэн Б.Адъяахүү ярьжээ.

“Эрдэс” ФМ 101

Захирал: О.Насантогтох

“Эрдэс” ФМ-101 радио 2001 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгийг өдөр бүр, 09:00-12:00 цагийн хооронд дамжуулдаг. Одоогоор хөтөлгөчтэйгээ нийлээд дөрвөн ажилтантай. Хөтөлбөр нь, дуу хөгжим, хайрын шүлэг, утсаар шууд холбогдох нэвтрүүлэг зэргээс бүрддэг. Орлогынхоо ихэнх хэсэг нь 60 хувийг зар мэдээ, засаг захиргааны мэдээнээс олно. Нэвтрүүлэгт шууд холбогдох утас тавиулахаар хүсэлт гаргаад байгаа гэнэ.

Интернэт/ Үүрэн телефон

Үүрэн телефон

Мобикомын 5000 орчим, Скайтелын 1000 орчим хэрэглэгчтэй. Зургаан суманд үүрэн телефоны сүлжээ барьдаг.

Интернэт

Энэтхэгийн засгийн газрын дэмжлэгээр байгуулагдсан, дөрвөн компьютертэй интернэт кафе Монголын Цахилгаан Компаний салбар дээр ажиллаж байна.

6.3.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Энэ аймагт үг хэлэх эрх чөлөөнд шахалт дарамт байсаар байна. Ардчилсан намын “Урагшаа” сонинд ажиллаж байсан Батцэцэг гэдэг эмэгтэй МАХН-ын гишүүн докторын тухай бичсэнийхээ төлөө ажлаасаа халагджээ. Тэрээр одоо орон нутгийн телевизэд ажиллаж байна.

Энэ тухай “Глоб Интернэшнл” ТББ-д шуурхай мэдээний сүлжээгээр мэдээлсэн. Гэсэн ч Батцэцэг телевизийн шинэ ажлаа алдахаас айж, нийтэд мэдээлэхээс татгалзсан юм.

Ардчилсан намын бодлого, улс төрчид (Хэнтий аймгийн эрх баригч нам)-ийн тухай Улаанбаатар хотын өдөр тутмын бус сонинуудаар гаргахаар сөрөг, хуудуутай материал бичүүлэхээр тэтгэвэрт гарсан сэтгүүлчдийг орон нутгийн МАХН-аас мөнгөөр тэтгэдэг тухай энд мөн мэдээлжээ. Эдгээр нийтлэл нь ихэнхдээ худлаа байлаа ч хэвлэгддэг байна.

᠒ рон нутгийн хэвлэл мэдээлэл нь улс төр, бизнесийн гарт байдаг гэдгийг үрилцлагад оролцогчид хэлж байв. Энэ байдал нь сонгуулийн бус үед төдийлөн үр дагавар учруулдаггүй ч, сонгуулийн үед нэлээд нөлөөтэй.

БАГИЙН АЯЛАЛ

Хэнтийн бор өндөр

25 гаруй жилийн түүхтэй Монгол-Орос-Хятадын хамтарсан уурхайтай, Улаанбаатар хоттой төмөр замаар холбогдсон.

Хүн ам: 10,000

Хэвлэл мэдээлэл:

“Дэлхийн Зөн”-гийн ФМ радио

“Эрднэсийн гайхамшиг” ФМ

2006 оны 2 дугаар сард ажлаа эхлээд туршилтын үе шатандаа байгаа. Улаанбаатар хотоос зөвшөөрөл хүлээж байна. Үүсгэн байгуулагч нь шашны байгууллага учраас зөвшөөрөл нь бодож байснаас илүү саатаж байгаа бололтой. Улаанбаатар хотоос ФМ-ийн продюсер хөлсөлж авсан, тоног төхөөрөмж бэлэн, сургалт эхлэлийн шатандаа байгаа юм байна.

Өөтөлбөр нь иргэдийн боловсрол, компьютер, англи хэлний хичээл, эрүүл мэндийг сэдэв, олон улс, орон нутгийн мэдээ, янз бүрийн насныханд зориулсан дуу хөгжим, хөгжлийн тухай нэвтрүүлэг зэргээс бүтэх ажээ. Мөн Хэнтий, Говь-Сүмбэр аймгийн бусад ФМ радиотой хамтран ажилладаг. Сургалтаа МХХ-тэй хамтран явуулна.

Бидний томилолтоор ажиллахдаа танилцсан бусад ФМ радиотой харьцуулахад тоног төхөөрөмж, ажиллах хүчний хувьд хамгийн сайн радиогийн нэг байлаа. Өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зорилготой. **Одоогоор “Дэлхийн Зөн”** олон улсын байгууллагын төслөөс бүрэн санхүүжиж байна.

6.4 ГОВЬ-СҮМБЭР АЙМАГ

Нутаг дэвсгэр: 5.540 км²
Хүн ам: 12,230: аймгийн төв Сүмбэрт 6,000
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 604,5 төгрөг

6.4.1 Үндэсний ХМХ

Сонин

Үндэсний хэмжээний ихэнх сонинг авах боломжтой. Урд чиглэлийн төмөр зам аймгийн төвөөр дамжин өнгөрдөг тул галт тэргээр сониноо хүргэдэг.

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ-5/ТВ-9 болон UBS/25-р суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

6.4.2 Орон нутгийн ХМХ

Телевиз

Орон нутгийн телевиз 2005 онд хаагдсан. ФМ радио, орон нутгийн “Жанжин Чойр” шинэ сонины эзэн Д.Уранцэнгэл телевиз байгуулахаар төлөвлөж байна. Энэ тухай дор дэлгэрэнгүй дурдав.

Кабелийн сүлжээ

Кабелийн телевиз 15 сувагтай. Энэ тухай өөр мэдээлэл байхгүй.

Сонин

Орон нутгийн хоёр сонинтой. Гурав дахь нь дөнгөж эхлэлийн шатандаа байна. Энэ хоёр сонины гаралт тогтмол бус учраас хоорондоо нэгджээ.

“Жанжин чойр” сонин

Эзэн/эрхлэгч: Д.Уранцэнгэл, МАХН-ын гишүүн

2006 оны 6 сард байгуулагдсан. Долоо хоног тутам А5 бүтэцтэй, 8 нүүрээр хэвлэгдэнэ.

Улаанбаатар хотод “Чөлөөт Хэвлэл” сан хэвлэх үйлдвэр 500-аас доош хувиар сонин хэвлэдэггүй. Үүнээс цөөхөн захиалагчтай учраас сониноо принтерээр хэвлэж байна. Сонинд орон нутгийн “эерэг” мэдээллийг нийтэлдэг. Нэгдүгээр нүүрт засаг захиргааны мэдээ, хоёрдугаар нүүрт эерэг ярилцлага, гуравдугаар нүүрт шүлэг, 4 дүгээрт нүүрт нийтийн эрүүл мэнд зэрэг амьдрал, хөгжлийн асуудлын тухай, үлдсэн бусад нүүрт зар мэдээ, зар сурталчилгаа нийтэлдэг. Сонины борлуулалтын үнэ 300 төгрөг. Зар мэдээ, зар сурталчилгаанаас орлогоо бүрдүүлнэ.

“Нутгийн мэдээ” сонин

Эзэн/эрхлэгч: Г.Баасансүрэн

2004 оны сонгуулийн өмнө “Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага” хөтөлбөрийн дэмжлэгээр байгуулагдсан. Зөвхөн орон нутгийн мэдээлэл нийтэлдэг. 500 хувь хэвлэгддэг сонин нь 200 захиалагчтай байсан ч тоо нь буурч 60 болжээ. Өмнөх дугаарын алдагдлын улмаас 2006 оны 8 сард хэвлэгдээгүй.

“Чойр 54” сонин

Эрхлэгч: Г.Баасансүрэн

2000 онд байгуулагдсан. Сонины сүүлийн дугаар нь 2006 оны 7 сард хэвлэгдсэн. “Сониноо хэвлүүлэх бодолгүй байгаа ч, зар сурталчилгаа олдвол хэвлэж магадгүй” гэж эрхлэгч нь ярьсан.

Радио

“Боржигон нутаг” ФМ-102.5

Захирал: Д.Уранцэнгэл

УИХ-ын гишүүн Л.Одончимэд 2005 оны 8 сард байгуулсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 08:00-23:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөр

нь, ярилцлага (65 ярилцлага бэлтгэсэн), таавар, танин мэдэхүйн шоу, цаг тутмын орон нутгийн мэдээ зэргээс бүрдэнэ. Залуучуудад төдийгүй, бусад бүх насныханд зориулагдсан.

Интернэт/ Үүрэн телефон

Үүрэн телефон

Хоёр интернэт кафетай. Нэг нь дунд сургууль дээр, нөгөө нь Монголын Цахилгаан Компаний салбар дээр байрладаг.

Үүрэн телефон

Мобиком 1500, Скайтел, Юнител нийлээд 3000-4000 хэрэглэгчтэй.

6.4.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Говь-Сүмбэр нь цөөн хүн амтай, шинэ аймаг.

Орон нутгийн сониноо Улаанбаатар хотод хэвлүүлбэл, “Чөлөөт Хэвлэл” сан хэвлэх үйлдвэр хамгийн бага тоо нь 500 хувиар хэвлэдэг тул энэ аймагт хэтэрхий ихдэх юм. Иймд “Нутгийн Мэдээ”, “Чойр-54” сонин зарим дугаараа нэгтгэж, нэг сонин нь дотор нүүрүүдийг, нөгөө нь гаднах нүүрүүдийг ашиглан хэвлүүлдэг. Гэсэн ч санхүүгийн байдал хүндрэлтэй хэвээр байна.

“Жанжин Чойр” сонины эрхлэгч Д.Уранцэнгэл нь янз бүрийн арга хэрэглэж, сониноо компьютерээд хэвлэж байна. Тэрээр прагматик сэтгэлгээ, эрсдэлтэй ч хийж үзэх хүсэл эрмэлзлэлээрээ хэвлэл мэдээллийн хэрэгслийг байгуулж, санхүүгийн хувьд тогтвортой байлгахаар чармайн ажиллаж байна. Д.Уранцэнгэл нь одоогоор хоёр ХМХ (ФМ радио, сонин) өмчилдөг. Удахгүй телевиз байгуулах бодолтой. Эрхлэгч Д.Уранцэнгэл нь Монголын Үндэсний Телевиз, Радиод орон нутгийн сурвалжлагчаар ажиллаж байсан. 2005 оноос ТВ-9 телевизэд мэдээ дамжуулж байгаа ажээ. Тэр үеэс, тухайлбал 1998-2005 онд тэрээр орон нутгийн телевизэд (гурван хүний) орон тооны ажилтан байсан ч, тодорхой бус шалтгаанаар халагджээ. Орон нутгийн телевизийн үйл ажиллагаа 2005 онд зогссон.

“Орон нутгийн телевизээс халагдснаасаа хойш Говь-Сүмбэр аймагт хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилтэй болох зорилго тавьсан” гэж Д.Уранцэнгэл яриу. Тэр телевиз, радио, сонинтой болж аймгаа дэлхий дахинд сурталчлах хэтийн зорилго тавьжээ. Хэвлэл мэдээллийн гурван хэрэгслийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй. Банкнаас санхүүжилт авсан. Одоогийн байршлаа алдахгүйн тулд эндээ ажлын байр барих зорилготой гэдгээ бас дурдсан юм.

6.5 ДОРНОГОВЬ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 115,200 км²
Хүн ам: 53,300; аймгийн төв Сайншандад 19,600
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 2074,7 төгрөг

Үндэсний ХМХ

Сонин

Сонин хэвлэлийг хэвлэгдсэнийх нь маргааш, өдөр бүр галт тэргээр хүргэдэг. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл.

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ5/ТВ9 болон UBS/25-р суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

6.5.2 Орон нутгийн ХМХ

Телевиз

“Дорноговь” ТВ

Захирал: Ч.Дүүрэн

1995 онд МАХН байгуулсан. Долоо хоногийн Даваа, Лхагва, Баасан, Бямба гарагт 30 минутын өргөн нэвтрүүлгийг (хоёр давталтайгаар) 18:30-19:00 цагийн хооронд дамжуулдаг. Зөвхөн аймгийн төвд 10 км-ын радиуст өргөн нэвтрүүлгээ дамжуулдаг, Тоног төхөөрөмжийн чанар муудсанаас дамжуулагч байнга эвдэрдэг байна.

“Дорноговь” телевиз нь өнөө хэр *íòðæéí* засаг захиргааны харъяалалд байна. Түүнийг худалдаж авах хүнгүй ажээ. Бүх тоног төхөөрөмж нь засаг захиргааны өмч. Тухайлбал, дамжуулагчийг 2001 онд 4000 ам.доллараар худалдаж авчээ. Төрийн албаны цалингийн сүлжээгээр цалинждаг. Телевизийн гол түншийн хувьд орон нутгийн засаг захиргаа түүний санхүүжилтийн 90-95%-ийг хангах гэрээтэй. Хариуд нь телевиз орон нутгийн засаг захиргааны мэдээг дамжуулдаг.

Зар сурталчилгааны орлого нь бага зах зээлээ дагаад бага хувь эзэлнэ. Энд орон нутгийн том компаниуд байдаггүй. Телевизийн ажилтны дурдсанаар, засаг захиргаа нь юу мэдээлэхийг заадаггүй ч тухайн долоо хоногийн арга хэмжээний тухай мэдээллийг түлхүү түгээдэг ажээ. Ардчилсан намаас мөн мэдээлэл ирдэг ч арга хэмжээ нь хааяа зохион байгуулагддаг.

Аль ч аймгийн ХМХ бүрэн хараат бус ажиллах боломжгүй гэж Ч.Дүүрэн үздэг. Засаг захиргаанаас өөр бусад орлогын эх үүсвэртэй Улаанбаатар, Дархан зэрэг хүн ам төвлөрсөн хотуудад бол энэ нь боломжтой. Монголын Үндэсний олон нийтийн телевиз ч гэсэн засгийн

газраас мөнгө авдгийн хувьд аливааг мэдээлэхдээ бүрэн чөлөөтэй бус гэж ярив.

Ч.Дүүрэн Монгол Улсын Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимд суралцан, 24 жил сэтгүүлчээр ажиллаж байна. Телевизийн хөтөлбөр нь бүрэн хараат ч гэлээ, зургаа авах, мэдээ эвлүүлэх талаар сайн мэдлэгтэй зураглаачтай тул нэвтрүүлэг нь чанар нь сайнтай гэнэ.

Кабелийн сүлжээ

“Нарны эрчим” КаТВ (ФМ-101.5 радиогийн өмчлөгч)

Захирал: Б.Зоригтбаатар

1998 онд байгуулагдсан. Хэрэглэгчиддээ гурван түвшний үйлчилгээг санал болгодог. Үүнд:

1. Зөвхөн монгол таван суваг үзвэл сарын хураамж 500 төгрөг
2. 24 суваг үзвэл сарын хураамж 3450 төгрөг
3. 28 суваг үзвэл сарын хураамж 3450 төгрөг (Зөвхөн орон сууцанд)

Аймгийн төвд 3000 хэрэглэгчтэй. Хятадын суваггүй. Хэрэглэгчдийн хүсэлтээр Оросын сувгуудыг түлхүү үзүүлдэг. Монгол, Орос, Солонгос, Герман, Францын гэх мэт суваг үзэх боломжтой.

Сонин

Орон нутгийн сонингүй. Хэдэн жилийн өмнө нэг хэсэг хүмүүс санаачлан сонин байгуулсан ч, санхүүгийн хүндрэлийн улмаас хаагдсан.

Радио

“Миний нутаг” ФМ-101.5 (мөн КаТВ-ийн эзэн)

Захирал: Б.Зоригтбаатар, эрхлэгч: Д.Отгонтөгс

2002 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 07:00-03:00 цагийн хооронд дамжуулдаг. Орон тооны зургаан ажилтантай. Хөтөлбөр нь хөтөлгөчийн цаг, орон нутгийн мэдээ, дууны уралдаан, утсаар шууд холбогдох нэвтрүүлэг зэргээс бүтнэ. Өнгөрсөн онд судалгаа хийсэн. Өдрийн янз бүрийн цагт бүхий л насныхны сонсох дуртай радио байхаар чармайн ажилладаг. Радио орон нутгийн хамрах нутаг дэвсгэрийн хүрээг өргөжүүлэхээр судалж байна. 300 км-ийн радиуст дамжуулах боломжтой тоног төхөөрөмж худалдаж авсан ч, зохих хүчин чадал бүхий цахилгааны эх үүсвэр дутагдалтай тул суурилуулж чадахгүй байна. Орлогоо ихэвчлэн зар сурталчилгаа, зар мэдээнээс олдог.

Кабелийн телевизийн сүлжээтэй тул ФМ радио ажиллуулах нь хялбар гэж Б.Зоригтбаатар эхэндээ найдаж байжээ. Гэвч, ялангуяа зар сурталчилгааны үнээр өрсөлддөг “Элгэн нутаг” ФМ (үүний тухай дор дурьдсан) байгуулагдсанаас хойш санхүүжилтийн төлөө тэмцэл үргэлжилсээр байна. Энэ судалгааг хийж байх үед, Монголын Цахилгаан Холбоо Компаний салбарын мэдэлд байсан “Элгэн нутаг” ФМ-д орон нутгийн засаг захиргаанаас санхүүгийн дэмжлэг үзүүлж байв.

Эхэн үедээ энэ нь маш хурц өрсөлдөөн байжээ. Одоо тэд хөтөлбөртөө эргэн дүгнэлт хийх, сонсогчдын судалгаа явуулах, шинэ хөтөлгөч авч ажиллуулах зэргээр өөрчлөлт хийхэд хүргэсэн тул өрсөлдөгчтэй байхыг давуу тал гэж үздэг болжээ.

Захирал нь эрсдэлийг сайн тооцдог, МАХН-ын гишүүн, намын хүчтэй дэмжигч юм. Тэрбээр “улс төргүй ХМХ байхгүй” гэж хэлэв. 2000 онд МАХН-д маш их дэмжлэг үзүүлсэн. Одоо илүү тэнцвэртэй байхыг эрмэлздэг ажээ.

“Элгэн нутаг” ФМ-105.5

Захирал: Б.Наран

Монголын Цахилгаан Холбоо компанийн салбар, Улаанбаатарт нэртэй “Элгэн нутаг” радиогийн өмчлөлд байдаг.

2005 онд орон нутгийн Цахилгаан Холбоо компаний салбарын захирал Баянхүү байгуулжээ. Сонсогчид нь дунд насныхан. Засаг захиргаатай удаан хугацаанд хэлэлцэж тохиролцсоны дүнд хэлэлцээр ёсоороо орон нутгийн мэдээ дамжуулах гэрээ байгуулсан. Монголын Цахилгаан Компаний салбарт кабелийн шугамтай. Монголын Цахилгаан Компаний салбар Монголын радиогийн нэвтрүүлгийг урьдын адил цацаж, кабелийг өөрийн байранд байршуулснаас харахад, гэрээ нь улс төрийн гэхээсээ илүү дэд бүтцийн шинжтэй байна.

Интернэт/ Үүрэн телефон

Үүрэн телефон

Аймгийн төв, дөрвөн суманд сүлжээтэй. Ойролцоогоор 10000 хэрэглэгчтэй.

Интернэт

Аймгийн төв хоёр интернет кафетай. Адилхан 16 компьютертэй нэг кафе нь Монголын Цахилгаан Компаний салбар дээр, нөгөө нь Монголын төмөр зам компани дээр байрладаг. Монголын төмөр замын шугам илүү хурдтай ажээ.

СУМЫН СУДАЛГАА:

Сайхандулаан сум

Хүн ам: 1000 гаруй
Суманд сонин захиалагчийн тоо: 60

Хамгийн их захиалагчтай сонин:

3. “Зууны мэдээ”, “Үнэн” (өдөр тутмын)
4. “Хүмүүс”, “Хань”, “Сэрүүлэг” (өдөр тутмын бус)

Мандах сум

Хүн ам: 1700 хүн амтай.

Телевиз: Монголын Үндэсний Телевизийн өргөн нэвтрүүлгийг 20:00-24:00 цагийн хооронд хүлээн авах боломжтой. Зөвхөн энэ цагаар дизелийн станц цахилгаанаар хангадаг.

Хураамж: Хэрэглэгчээс сард 600 төгрөг.

Сонин хэвлэлийг долоо хоногт нэг удаа хүргэнэ. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл. Малчдын захиалсан хэвлэлийг багийн дарга хүргэнэ.

6.6. ӨМНӨГОВЬ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 165,000 км²
Хүн ам: 46,300, аймгийн төв Даланзадгадад 14,700
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 4208,9 төгрөг

6.6.1. Үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслүүд

Сонин

Сонинг онгоцоор долоо хоногт хоёр удаа хүлээн авдаг. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл.

Телевиз

Үндэсний таван Монгол суваг (Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ5/ТВ9 болон UBS/25-р суваг телевиз), Оросын нэг, Хятадын нэг суваг үзэх боломжтой.

6.6.2. Орон нутгийн ХМХ

Телевиз

“Алтанговь” ТВ

Захирал: С.Номинцэцэг (мөн сонин, ФМ, КаТВ-тэй)

“Алтанговь” телевиз 2003 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 17:00-22:00 цагийн хооронд дамжуулдаг. Даваа, Лхагва, Баасан гарагуудад мэдээний хөтөлбөртэй. Одоогоор орон тооны найман ажилтантай. Хөтөлбөр нь, 30 минутын орон нутгийн мэдээ, хүүхдийн, ярилцлага, төлбөрт мэдээ (30 минут хүртэл) зэргээс бүрдэнэ. Телевиз хоёр долоо хоногийн хөтөлбөрөө нэг удаа давтан үзүүлдэг.

Орлогынхоо 80 хувийг нь зарлал (1 үг 70 төгрөг), зар мэдээнээс, үлдсэн хувийг төлбөрт нэвтрүүлгээс олдог.

“Говь” ТВ

Эзэн/захирал: М.Цоомоо

“Говь” телевиз 2003 оны 11 сард байгуулагдсан. Орон тооны дөрвөн ажилтантай. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 19:00-22:00 цагийн хооронд дамжуулдаг.

Кабелийн сүлжээ

“Алтан говь” КаТВ

Захирал: С.Номинцэцэг (өмнө дурдсан)

Телевиз 2006 оны 7 сард байгуулагдсан. Одоогоор 70 хэрэглэгч, 24 сувагтай. Сарын хураамж 2800 төгрөг.

“Говийн наран” КаТВ

Эзэн/захирал: М.Цоомоо

“Говийн наран” кабелийн телевиз нь 2005 оны сүүлээр байгуулагдсан. Монгол, гадаадын 12 сувагтай. Хэрэглэгчийн тооны талаар мэдээлэл байхгүй.

Сонин

Орон нутгийн хоёр сонинтой.

“Монгол говь” сонин

Эрхлэгч: Ц.Бат-Олзий

“Монгол говь” сонин 2001 онд байгуулагдсан. Хөдөөгийн голдуу 200 захиалагчтай, 10 хоног тутам хэвлэдэг. Сонин таван ажилтантай. Орон нутгийн хуучин сонины буурь дээр, өөр нэрээр үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн байгуулсан. МАХН-д үйлчилж, нэг талыг барьдаг ажил байна.

Өнгөрсөн жилүүдэд удирдлага нь хэд хэд солигдож, олон тооны бэрхшээлтэй тулгарч байгаа ажээ. Саяхан гэхэд л, дарга нь ажлаасаа гарахдаа ихэнх тоног төхөөрөмжөө хулгайлчихсан гэнэ. Сонин “Эгэл” ХХК (Орон Нутгийн Сонинуудын Холбоо)-ны өмч, түүний бүтцэд байдаг. “Эгэл” ХХК-наас шинэ тоног төхөөрөмжөөр хангасан. Сонин тогтмол хэвлэгдэхгүй байснаас захиалагчдаа алдсан нь томоохон бэрхшээл учруулж байна.

Дугаар бүрт засаг захиргаанаас 100,000 төгрөгийн татаас авдаг. Дээр нь захиалга, борлуулалт, зар сурталчилгаа, зар мэдээний нэмэлт орлогоор санхүүждэг. Засаг захиргааны мэдээллийг нийтэлдэг. Гэхдээ, засаг захиргаа юу нийтлэхийг нь шууд заадаггүй хэмээн цохон тэмдэглэж байсан. Сумдын албан хаагчид нь мэдээллээ аймгийн засаг захиргаа руу илгээдэг, тэндээс сонинд ирдэг байна.

”Алтан нутгийн мэдээ” сонин

Эрхлэгч: С.Номинцэцэг

Сонин 2006 оны 7 сард байгуулагдсан. Сар бүрийн 10, 20, 30-нд гардаг. 200 захиалагчтай. Улаанбаатар хотод “ОБИ Капитал” хэвлэх үйлдвэрт 1000 хувиар хэвлэгддэг.

Орон тооны хоёр сурвалжлагч нь янз бүрийн сэдэв, булан ажиллуулдаг, агуулга сайтай. Ардчилсан намыг дэмжигч сонин гэлцдэг.

Радио

”Говийн долгион” ФМ 103.6, ТББ (мөн бүсийн радиотой)

Захирал: Д.Нарангэрэл

2000 онд Соросын сангийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан. Даваагаас Бямба гарагт, 09:00-21:00 цагийн хооронд нэвтрүүлгээ дамжуулдаг. Ням гарагт зургаан цагийн нэвтрүүлэгтэй. Хөтөлбөр нь, орон нутгийн мэдээ, боловсролын нэвтрүүлэг, түүхий эдийн үнэ ханш, цаг агаар, зарлал, цаг үеийн асуудал, Америкийн дуу хоолой радиогийн нэвтрүүлэг зэргээс бүрдэнэ. Өглөөний хөтөлбөрөө үдээс хойш давтдаг.

Орлогынхоо дийлэнх хэсгийг төлбөрт мэдээ (бүсийн радиогоос урт хугацаагаар), зарлал (1 үг 20 төгрөг)-аас олно.

“Говийн Долгион” Бүсийн Олон Нийтийн Радио (ФМ 103.6)/ТББ

Захирал: Д.Наранчимэг

2000 онд хараат бус ТББ-ын статусдаар байгуулсан. Бүсийн өргөн нэвтрүүлгээ Өмнөговь аймгийн 15 суманд Монголын Үндэсний Радиогийн сувгийг ашиглан дамжуулдаг. Сарын түрээсийн төлбөрт 120,000 төгрөг төлнө. Долоо хоногт хоёр удаа, Даваа, Баасан гарагийн 08:00-08:40 цаг, 18:00-18:40 цагийн хооронд нэвтрүүлгээ явуулна. Хөтөлбөр нь, засаг захиргаа, орон нутгийн мэдээ, “Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага” төслийн зах зээлийн үнэ ханшийн мэдээ, хууль эрх зүйн, мөн бусад зарлал, цаг агаарын мэдээ зэргээс бүрдэнэ.

Орлогоо төлбөрт мэдээ, зарлал, зар мэдээ (1 үгийг 50 төгрөг)-нээс бүрдүүлнэ.

“Говийн Долгион” ФМ, “Говийн Долгион” бүсийн радио нь ТББ хэлбэрээр “Соросын сан”, “Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага” төслийн хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаагаа эхэлжээ. “Америкийн дуу хоолой” радиогийн Англи хэлний хичээлийг хүлээн авч, дамжуулах тоног төхөөрөмжийг авахад нь АНУ-ын Азийн сангаас тусалсан, одоо санхүүжилт авч байгаа ажээ.

Энэ аймагт нийтлэг болсон гар аргаар алт олборлогч “Нинжа” нарт байгаль орчны боловсрол олгох зорилго бүхий радио цуврал нэвтрүүлэг бэлтгэхэд АНУ-ын Азийн сан сургалт, санхүүжилт олгож байна. Радиогийн цуврал нэвтрүүлгээр уурхайд очиж, алт олборлогч, малчдаас ярилцлага авч, оруулдаг байна.

“Миний Говь” ФМ-104.1 радио

Захирал: С.Номинцэцэг

2003 оны 12 сард “Ажнай” корпораци үүсгэн байгуулсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр 09:00-22:00 цагийн хооронд дамжуулдаг. Орон тооны нэг ажилтантай.

“Мөрөөдлийн ФМ 102.6” радио

Эзэн/захирал: М.Цоомоо

М.Цоомоо 2003 оны 11 сард энэ радиог үүсгэн байгуулсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 09:00-21:00 цагийн хооронд дамжуулдаг. Орон тооны нэг ажилтантай.

Интернэт/ Үүрэн телефон

Үүрэн телефон

Үүрэн телефон хэрэглэгчдийн тоог гаргах боломжгүй. Гэсэн ч, аймгийн төв, хоёр сум, “Айвонхоу Майнз Монгол” үйлдвэрт Мобикомын сүлжээ барьдаг.

Интернэт

Саяхнаас аймгийн төв, зарим сум шилэн кабельд холбогдсон. Аймгийн төвд дунд сургууль, ЗДТГ, Цахилгаан Холбоо компаний салбар, Номын сан гээд нийт дөрвөн интернэт кафетай.

6.6.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Судалгаанд оролцсон хэвлэл мэдэээлийнхний ярьснаар, орон нутгийн засаг захиргаа төдийлөн дарамт шахалт учруулдаггүй гэнэ. “Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд МАХН, Ардчилсан Нам гэж талцдаг ч, сонгууль болоогүй үед нэг их туйлширдаггүй” гэж өмнө нь радиод ажиллаж байсан хөндлөнгийн ажиглагчид хэлэв.

“Алтан Говь Групп” (телевиз, радио, сонин, кабелийн телевиз)

Ардчилсан намын энэ аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүний өмч ажээ.

“Өмчлөгч нь анх УИХ-ын сонгуулийн сурталчилгаандаа зориулж байгуулсан ч, одоо илүү тэнцвэртэй ажилладаг” гэж ярилцлага өгсөн менежер нь хэлсэн. Ардчилсан намаас санхүүждэг гэсэн ойлголт хэвээр байна.

Орон нутагт МАХН-ын эрх барьж буй засаг захиргаанаас санхүүгийн дэмжлэг авдаггүй тул янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүжилт, мөн мэргэжлийн ур чадвар бүхий боловсон хүчин дутмаг нь эдний хувьд хамгийн том бэрхшээл ажээ. Малчдад хүрч үйлчлэхийн тулд хамгийн сүүлд сонин байгуулан, радио, телевизийнхээ орлогоор дэмжлэг үзүүлж байна.

СУМЫН СУДАЛГАА

“Хан Хонгор” сум

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, ТВ-5 ба ТВ-9 телевизийн гурван суваг үздэг. Сарын хураамж 600 төгрөг. Байнга цахилгаантай, үүрэн телефоны сүлжээ барьдаг.

“Цогт Овоо” сум

Монголын Үндэсний Олон Нийтийн телевизийн нэвтрүүлгийг үзнэ. Сарын хураамж 600 төгрөг. Оройн 21:00-24:00 цагийн хооронд үзэх боломжтой. Дизель станц энэ цагаар ажилладаг. Долоо хоногт нэг удаа сонин хүлээн авдаг.

6.7. ДУНДГОВЬ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 78,000 км²
Хүн ам: 49,400; аймгийн төв Сайнцагаанд 13,800
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 1348,7 төгрөг

6.7.1. Үндэсний ХМХ

Сонин

Сонин хэвлэлийг Улаанбаатар хотоос аймагт долоо хоногт дөрвөн удаа, аймгийн төвөөс сумдад долоо хоногт гурван удаа шуудангийн машинаар хүргэдэг.

Хамгийн олон захиалагчтай сонин

Өдөр тутмын бус сонин

- "Хүмүүс" – 600-1000 захиалагчтай. Захиалагчдын 60 орчим хувь нь сумдад байдаг. Захиалга улирлаас хамаарна.

- "Зиндаа"
- "Сэрүүлэг"

Өдөр тутмын сонин

- "Зууны мэдээ" 60-70 захиалагчтай. Аймгийн төв, сумдын төрийн албан хаагчид гол төлөв захиалдаг.
- "Өдрийн сонин"

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ-5/ТВ-9 болон UBS/25 аймаг суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг сансрын холбоогоор өнжөөд нэг солбиж үзнэ.

6.7.2 Орон нутгийн ХМХ

Телевиз

"Дундговь" ТВ

Захирал: Т.Отгонтуяа

Долоо хоногт гурван удаа Даваа, Лхагва, Бямба гарагт 18:30 цагаас гурван цагийн нэвтрүүлэг явуулах хуваарьтай. Энэ нь тогтмол бус ч, долоо хоногт дунджаар хоёр удаа өргөн нэвтрүүлгээ дамжуулдаг. Хөтөлбөр нь, нэг цагийн орон нутгийн мэдээ, уран сайхны кино, зар мэдээ зэргээс бүтнэ. Орон тооны хоёр ажилтантай, орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг авдаг.

Кабелийн сүлжээ

“Хорол” КаТВ

18 сувагтай, сарын хураамж 2500 төгрөг

Сонин

“Говийн амьдрал” сонин

Эрхлэгч: С.Буджав

“Говийн амьдрал” сонин нь 2005 оны эхээр байгуулагдсан, 10 хоног тутам гардаг. АЗ хэмжээтэй, 4 нүүр нь өнгөт. Сонин аймгийн засаг захиргаанаас бүрэн санхүүждэг. Эрхлэгч нь Засаг даргын тамгын газрын Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого зохицуулалтын хэлтсийн даргын алба хашдаг. Сонин аймгийн ЗДТГ-ын байранд байдаг. Орон нутагт МАХН эрх барьдаг

“Хадаг” сонин

Эрхлэгч: С.Пүрэвсүрэн

“Хадаг” сонин 1991 онд байгуулагдаж, 1000-1500 тогтмол захиалагчтай байжээ. Гэвч, 2005 оноос санхүүгийн байдал дордож, хаагдахад хүрээд байна. Эрхлэгч С.Пүрэвсүрэн зар сурталчилгаа, тухайлбал, аль нэг байгууллагын ой гэх мэтэд зориулан 200,000 төгрөг төлөх ивээн тэтгэгч олдвол сониноо хэвлүүлдэг гэнэ. С.Пүрэвсүрэн одоо аймгийн Улсын Мэргэжлийн Хяналтын Албанд ажилладаг. Аймгийн ЗДТГ-т ажиллаж байжээ. Захиалагчийнхаа тоог бууруулахгүйгээр хадгалж байх үедээ “Хадаг” сонин орон нутгийн засаг захиргаанаас төлбөрт мэдээ авч хэвлэдэг байв.

“Хадаг” сонин хамгийн сүүлд 2005 оны 7 сард аймгийн Эрчим хүчний байгууллагын 50 жилийн ойд зориулж дугаар гарган, ажиллагсдад нь үнэгүй тараасан байна. С.Пүрэвсүрэн нь төрийн албан байраа “Хадаг” сониноо гаргахад ашигладаг. Тэрээр МАХН-ын гишүүн.

“Өглөө” сонин

Эрхлэгч: Ч.Түмэннаст

“Өглөө” сонинг саяхнаас Ч.Түмэннаст эрхлэн гаргаж эхэлжээ. Хүүхдэд зориулсан сар тутмын сонин.

Радио

Аймгийн төвд орон нутгийн хоёр ФМ радиотой.

“Говийн тэнгэр” ФМ-101.9 радио

Эрхлэгч: П.Цолмонтөгс

2003 оны 5 äóãàäð сард П.Цолмонтөгс үүсгэн байгуулсан. Эрхлэгчээсээ гадна орон тооны дөрвөн ажилтантай, тогтмол ажиллагаатай. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 08:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөр нь, гол төлөв дуу хөгжим, зар мэдээ, зарлал зэргээс бүтнэ.

“Мандалговь” ФМ-107.5 радио

Захирал: С.Оюунчимэг

“Наранцацралт сан” ТББ 2004 оны 6 äóãàäð сард үүсгэн байгуулсан. Орон тооны нэг ажилтантай. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 09:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг.

Интернэт/ Үүрэн телефон

Үүрэн телефон

Ойролцоогоор 2000 орчим үүрэн телефон хэрэглэгчтэй. Аймгийн төв, нэг суманд сүлжээ барьдаг.

6.8 ТӨВ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 81,000 км²
Хүн ам: 99,200; аймгийн төв Зуун модод 14,800
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 3418.0 төгрөг

6.8.1. Үндэсний ХМХ

Сонин

Улаанбаатар хотод хамгийн ойрхон учраас сонин хэвлэлээ тогтмол хүлээн авдаг. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл.

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ-5/ТВ-9 болон UBS/25 äóãàäð суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг сансрын холбоогоор өнжөөд солбиж үзнэ.

6.8.2. Орон нутгийн ХМХ

Телевиз

“Зуун мод” ТВ

Захирал: Ж.Энхбаатар

“Зуун мод” телевизийг Ж.Энхбаатар 2005 оны 4 ä¿ãýð сард байгуулсан. Долоо хоногт гурван удаа кабелиар өргөн нэвтрүүлгээ цацдаг. Орон тооны нэг ажилтантай.

Кабелийн сүлжээ

”Од” КаТВ

Захирал: Ж.Болдбаатар

Ж.Болдбаатар 2001 онд үүсгэн байгуулжээ. Өдөр бүр, 24 цагаар нэвтрүүлэг дамжуулдаг. 21 сувагтай.

Радио

“Зуун мод” ФМ-106.5 радио

Захирал: Мөнхтүвшин

Мөнхтүвшин 2004 онд үүсгэн байгуулсан. Орон тооны нэг ажилтантай. Өдөрт 18 цагийн нэвтрүүлэг явуулдаг.

“Мишээл” ФМ-99.3 радио

Захирал: С.Өлзийтогтох

С.Өлзийтогтох 2004 онд үүсгэн байгуулсан. Орон тооны нэг ажилтантай. Өдөрт 24 цагийн нэвтрүүлэг явуулдаг.

Сонин

”Төв таймс” сонин

Эрхлэгч: Ж.Энхбаатар

Ж.Энхбаатар 2005 оны 4 ä¿ãýð сард үүсгэн байгуулсан. Орлогч эрхлэгч нь Н.Хишигсүрэн. Эрхлэгчээс гадна орон тооны хоёр ажилтантай. 10 хоног тутам 1000 хувиар хэвлэгдэнэ.

6.9 СЭЛЭНГЭ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 43,000 км²
Хүн ам: 102,000; аймгийн төв Сүхбаатарт 29,000
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 2600.0 төгрөг

6.9.1. Үндэсний ХМХ

Сонин

Улаанбаатар хотоос Оросын Холбооны Улс хүртэлх хатуу хучилттай зам дээр оршдог. Сонин хэвлэл хүргэлт тогтмол бус. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл.

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн мөн ТВ-5/ТВ-9 болон UBS/25 äóäääð суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд солбиж үзнэ.

6.9.2. Орон нутгийн ХМХ

Телевиз

“Сэлэнгэ” ТВ

Захирал: Д.Балдан

Аймгийн ИТХ 1995 оны 10 äóäääð сард байгуулсан. “Сэлэнгэ” телевиз коммунист дэглэмтэй байсан үеэс л өргөн нэвтрүүлэг явуулж байжээ. Одоо орон тооны дөрөв, орон тооны бус хоёр ажилтантай. Орон нутгийн засаг захиргаатай ойрын холбоотой. Д.Балдан Сэлэнгэ аймгийн театрын даргын алба хашдаг. Орон нутгийн засаг захиргааны санхүүжилттэй.

Өргөн нэвтрүүлгээ 06:00-20:30 цагийн хооронд газрын хүлээн авах, дамжуулах станц, “Цолмон” кабелийн телевизийн сувгаар дамжуулдаг. Судалгааны үеэр, дамжуулагч нь ажиллахгүй болсон тул нэвтрүүлэг дамжуулахгүй байсан. Дамжуулагч хэзээ ажилд орох нь тодорхой бус байв.

Хөтөлбөр нь, 30 минутын орон нутгийн мэдээ, сурвалжлага, ярилцлага, өдрийн онцлох үйл явдал, цаг агаарын мэдээ зэргээс бүрдэнэ. Телевизийн төсөв жилд 1-1.5 сая төгрөг хүрдэг. Үүнийг бараг 100% МАХН-ын эрх барьж буй орон нутгийн аймгийн засаг захиргаанаас олгодог.

“Нарны хүлэг” ТВ (мөн “Нарны Хүлэг” КаТВ-ийг өмчилдөг)

Эзэн/захирал: Ч.Наранцэцэг

Ч.Наранцэцэг 1999 онд байгуулсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 08:00-23:00 цагийн хооронд дамжуулдаг. 12 ажилтантай. Одоогоор зөвхөн

кабелийн сүлжээ ажиллаж байна. Өөрийн хүлээн авах, дамжуулах станцтай байснаа саяхан худалджээ. Хөтөлбөр нь, орон нутгийн мэдээ, сонирхолтой түүх намтартай хүн оролцсон нэвтрүүлэг зэргээс бүтнэ.

Орон нутгийн засаг захиргаанаас санхүүжилт авдаггүй. Гэхдээ санхүүжилт авахаар хөөцөлдөж байна. Одоохондоо кабелийн хэрэглэгчийн хураамжаар санхүүждэг. Энэ жилээс кабелийн телевиздээ түлхүү анхаарч, орон нутгийн телевизийн өргөн нэвтрүүлгээ долоо хоногт хоёр удаа болгон багасгажээ.

“Миний Монгол” ТВ (мөн кабелийн телевиз, ФМ радиотой)

Захирал: Д.Ганболд

Телевизийг 2006 оны 2 ᠗᠐᠗᠗ сард Д.Ганболд байгуулсан. Өргөн нэвтрүүлгээ долоо хоногт гурван удаа, дараагийн өдөр нь давталттайгаар дамжуулдаг. Лхагва, Баасан гарагт ерөнхийдөө мэдээ, Даваа гарагт зочины ярилцлага явуулдаг.

Орлогынхоо 80%-ийг зарлал, зар мэдээнээс (1 үг 70 төгрөг), үлдсэн хэсгийг төлбөрт нэвтрүүлгээс олдог.

“Миний Монгол” хэвлэл мэдээллийн групп

Орон нутгаас УИХ-д сонгогдсон Ардчилсан Намын гишүүн “Миний Монгол” кабелийн телевизийн сүлжээг 2005 оны сүүлээр худалдаж авсан. 2005 оны 12 сараас 2006 оны 2 ᠗᠐᠗᠗ сар хүртэлх маш богино хугацаанд ФМ радио, телевизийг тус тусад нь ажиллуулж эхэлсэн. Энэ судалгааг хийж байхад, хэвлэл мэдээллийн групп улс төржихгүй байгаа ч, ирэх 2008 оны сонгуулийн үеэр юу болох бол гэдэгт эргэлзэж байгаага ажилтнууд нь ярьж байлаа. Групп нь нийт 6-8 ажилтантай.

Кабелийн сүлжээ

“Цолмон” КаТВ (“Сэлэнгэ” ТВ-тэй ажилладаг)

Зөвхөн гэр хорооллийн хэрэглэгчтэй. Тоо нь тодорхой бус. Ойролцоогоор 20 сувагтай.

“Нарны хүлэг” КаТВ

2001 онд байгуулагдсан. Орон сууцны 800 хэрэглэгчтэй. Сарын хураамж 3,000 төгрөг, 14 сувагтай.

“Миний Монгол” КаТВ

Захирал: Д.Ганболд

2006 онд байгуулагдсан. Зөвхөн орон сууцны хэрэглэгчтэй. Сарын хураамж 3,000 төгрөг. Орос, Хятад, Герман, Франц, Солонгосын гэх мэт 28 сувагтай.

Сонин

“Сэлэнгийн мэдээ” сонин

Эрхлэгч: Ж.Оюунмаа

“Эгэл” ХХК 2002 оны 9 сард байгуулсан, Орон Нутгийн Сонинуудын Холбооны бүтцэд багтдаг. Аймгийн төвийн анхны хараат бус сонин. Орон тооны гурван ажилтантай. Ж.Оюунмаа коммунист дэглэмийн үед сонинд ажиллаж байсан, олон жилийн туршлагатай.

Долоо хоног тутам, 900-1,000 хувиар хэвлэдэг. 1,000 хувийн ихэнхийг хөдөөд тараадаг. Ерөнхийдөө орон нутаг, засаг захиргаа, бизнесийн мэдээг хүний сонирхол татахуйц байдлаар нийтэлдэг.

Орлогынхоо 60 хувийг захиалгаас (3 сар нь 2700 төгрөг), 20 орчим хувийг төлбөрт материалаас, үлдсэн хувийг зар сурталчилгаа, зар мэдээнээс олдог. Сонин засаг захиргаанаас байгуулагдсаны дараах 2 жилд сар бүр 200,000 төгрөг, түүнээс хойш 100,000 төгрөгийн татаас авдаг болжээ. Уг судалгааг хийж байхад 2006 оныхоо мөнгийг аваагүй байв.

Өнгөрсөн сонгууль тэдний хувьд хамгийн сайн орлоготой үе болж, компьютер, мөн зарим шинэ тоног төхөөрөмж авах боломж олгосон гэнэ. Улс төрийн янз бүрийн нам хааяа ивээн тэтгэдэг. Тус аймагт зар сурталчилгаа хийлгэх чадвартай үйлдвэр цөөн, санхүүжилт бага нь өнөөдөр тэдний хамгийн тулгамдсан бэрхшээл ажээ.

“Гэгээ” сонин

Эрхлэгч: Л.Бямбаа

2005 оны 4 сард байгуулагдсан. Сард хоёр удаа гардаг. Ар, өвөр нүүр өнгөт, дотор тал нь хар цагаанаар, 1000 хувиар хэвлэгддэг. Нийтлэлийн бодлого нь хүмүүсийг зоригжуулсан мэдээ түгээх, төлбөрт мэдээ, хүний сонирхолтой түүх намтар нийтлэхэд чиглэдэг.

Орлогын ихээхэн хэсэг нь төлбөрт нийтлэлээс бүрддэг. Жишээ нь, хамгийн сүүлд гарсан дугаарыг нэг сумын 80 жилийн ойд зориулж, 350,000 төгрөг авсан ажээ. 200,000-300,000 төгрөгийн орлогоор амиа аргацаана гэж байв.

Сонингоо Улаанбаатар хотод хэвлүүлээд, Монгол Шуудан Компаниар сумдад түгээдэг.

Радио

“Миний Монгол” ФМ-107.5 радио

2005 оны 12 сард байгуулагдсан. Нэг хөтлөгч ажилладаг. Телевиз, кабелийн телевизтэйгээ хамт нэг газар байрладаг. Гол төлөв зар сурталчилгаа, төлбөрт нэвтрүүлэг, утаснаас орлогоо бүрдүүлдэг.

“Өргөн Сэлэнгэ” ФМ-104

Захирал: Р.Бумдарь

1999 онд Соросын сангийн дэмжлэгээр ТББ-ын статустай байгуулсан. Өргөн нэвтрүүлгээ 10:00-18:00 цагийн хооронд дамжуулна. Нэг хөтлөгч ажилладаг. Радиогийн үүсгэн байгуулагч, захирал нь орон нутгийн засаг захиргаанд орон тооны ажилтан. Мөн МОНЦАМЭ-ийн төлөөлөгч. Сүүлийн дөрвөн жилд ажиллаж буй хөтлөгчийн хэлснээр бол сургалт хамгийн гол бэрхшээл байв. Тэрээр мөн радиод орон тоогоор хүн ажиллуулах нь хэцүү тул, зөвхөн дадлагажигчаар авдаг гэсэн юм. Хөтлөгч нь Дарханд нэг өдрийн сургалтад хамрагджээ. Хөтөлбөр нь, асуулт хариултын шоу, мэдлэгт тулгуурласан нэвтрүүлгүүд, мэдээ (ихэвчлэн сонинууд мэдээллийн эх сурвалж болдог) зэргээс бүрдэнэ. ФМ-ийн захирал мөн мэдээгээр хангадаг байна.

Интернэт/ Үүрэн телефон

Үүрэн телефон

Аймгийн төв, 17 сумын 11-д нь үүрэн телефоны сүлжээ барьдаг.

Интернэт

Монголын Цахилгаан Холбоо компаний салбар, Төмөр зам, зочид буудал зэрэг гурван газар интернет кафетай.

6.9.3. Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Сэлэнгэ аймгийн хэд хэдэн сум өөрийн ХМХ-тэй. Аймгийн төвд үйлдвэр цөөн учраас хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төвлөрч ажиллахад хүндрэлтэй. Гэхдээ эдийн засгийн хувьд илүү боломжтой Сайхан, Мандал, Цагааннуур, Ерөө, Түшиг зэрэг сум өөрийн телевизийн өргөн нэвтрүүлэгдүй болжээ.

6.10 ДАРХАН-УУЛ АЙМАГ

Нутаг дэвсгэр:	3,280 км ²
Хүн ам:	94,280; аймгийн төв Дарханд 81,000
Эдийн засаг:	Төсвийн орлого: (саяар) 1845,7 төгрөг

6.10.1. Үндэсний ХМХ

Сонин

Дархан хот Улаанбаатараас Орос хүртэлх хатуу хучилттай зам дагуу оршдог учир сонин хэвлэл тогтмол хүлээн авдаг. Дийлэнх нь өдөр тутмын бус сонин хэвлэл.

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ5/ТВ9 болон UBS/25-р суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

6.10.2. Орон нутгийн ХМХ

Телевиз

“Ди-Би-Эс” ТВ (мөн КаТВ, ФМ, Интернэт төвтэй)

Захирал: А.Түвшинбат

2004 онд байгуулагдсан, мөн ФМ радио, кабелийн хамгийн том телевизийн сүлжээ, интернэт үйлчилгээний төв байгуулсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 06:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Орон тооны 16 ажилтантай.

“Ди-Би-Эс”-ийн тухай

Телевиз, КаТВ, ФМ радио өмчилж, интернэт үйлчилгээ үзүүлэх бизнес эрхэлж, түүнчлэн телевизийн уран бүтээл хийдэг компани юм. МАХН-д талтай нь харагдсан. Орлогынхоо 60 хувийг кабелийн телевизийн хэрэглэгчдийн хураамж, 40 хувийг зар сурталчилгаанаас олдог.

“Лха” ТВ (мөн КаТВ, ФМ-тэй)

Эзэн/захирал: Ч.Лхагвадорж

“Лха” телевизийг Л.Лхагвадорж 2001 онд байгуулсан. 1996 онд байгуулагдсан КаТВ станцын бүтцэд багтдаг. Тэд Ардчилсан намыг түшиж үйл ажиллагаа явуулдаг нь харагдсан.

Өдөр бүр 06.00-24.00 цагийн хооронд нэвтрүүлгээ дамжуулдаг. Орон тооны 12 ажилтантай. Хөтөлбөр нь, 20 минутын өдөр тутмын мэдээллийн хөтөлбөр, монгол хэл үрүү орчуулж, уншдаг Оросын цэнгээнт нэвтрүүлэг,

А.Батзаяа 2003 онд үүсгэн байгуулсан. Орон тооны хоёр ажилтантай. 800 хувиар хэвлэгддэг.

“Дархан зар” сонин

Эрхлэгч: З.Адъяа

З.Адъяа 2006 онд үүсгэн байгуулсан. Орон тооны гурван ажилтантай. 1200 хувиар хэвлэгддэг.

Радио

“Орхон” ФМ-106 радио

Захирал: О.Хишигсүрэн

Соросын сангийн санхүүжилтээр 1999 онд байгуулсан. О.Хишигсүрэн хүлээн авагчдынхаа дунд судалгаа явуулж, дүн шинжилгээ хийн, тэдний хэрэгцээ шаардлагыг тодорхойлдог. Менежментийн ур чадвар дутмаг нь орон нутгийн радионуудыг бэрхшээлд оруулж буйг ойлгосон учир радиогоо өөрөөр ажиллуулахыг хүсдэг ажээ. Тэр сонсогчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэвтрүүлгээ өөрчилдөг. Мөн нэвтрүүлгээ санхүүжүүлэх Олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллана. Түүнчлэн, ДОХ, авилга, эрүүл мэнд зэрэг өөрийн сонирхдог сэдвээр зохион байгуулагдсан сургалтад хамрагддаг.

О.Хишигсүрэн сургалтыг хамгийн чухал зүйл гэж үздэг учир радиогийн залуусаа сургалтад хамруулахыг хичээдэг. Гэвч, дараа нь залуучууд Улаанбаатар руу явчихдаг нь бас нэг бэрхшээл ажээ. Иймд, радиогоо гэр бүлийнхээ бизнес болгон хөгжүүлэхээр хичээж байна. Орон тооны зургаан ажилтантай.

Орлогынхоо 50 хувийг донор байгууллагууд, 20 хувийг зар сурталчилгаа, зар мэдээ, 30 хувийг төлбөрт нэвтрүүлэг, шууд утасны орлогоос бүрдүүлнэ.

“Ди-Би-Эс” ФМ

Захирал: А.Түвшинбат

Өргөн нэвтрүүлгээ 08:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Ихэнхдээ дуу хөгжмийн хөтөлбөр. Орлого хүндрэлтэй ч, зар сурталчилгааг нэг бус хэд хэдэн хэвлэл мэдээллээр (радио, телевиз) дахин давтах, тухайлбал, телевизэд өгсөн зарыг радиогоор дахиж явуулах зэргээр зар сурталчилгааны түншүүддээ боломжийн санал тавьдаг.

“Лха тэнгэр” ФМ 107.5

Эзэн/захирал: Ч.Лхагвадорж

1996 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 08:00-24:00 цагийн хооронд, Баасан, Бямба гарагт шөнийн 02:00 хүртэл дамжуулдаг. Орон тооны дөрвөн ажилтантай. Хөтөлбөр нь, дуу хөгжим, зугаа цэнгээнт, аялал, зурхай, хүүхдийн нэвтрүүлэг зэргээс бүрнэ.

“Бурхантын цуурай” радио

Захирал: Б.Норовсамбуу

Б.Норовсамбуу 1986 онд байгуулсан. Орон тооны хоёр ажилтантай. Хоёр цагийн өргөн нэвтрүүлгээ өдөр бүр МҮОНР-ийн сувгаар дамжуулдаг.

“Шинэ долгион” ФМ 102.5

Эзэн/захирал: А.Түвшинбат

2004 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 08:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Орон тооны тав, орон тооны бус хоёр ажилтантай.

Шинэ ФМ 107.5

Эзэн/захирал: Б.Ганбаяр

2005 оны 12 дугаар сард байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 08:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Орон тооны зургаа, орон тооны бус гурван ажилтантай.

Интернэт/ Үүрэн телефон

Интернэт

10-11 интернет кафетай. Албан байгууллага, айлууд интернетэд холбогдох боломжтой.

Үүрэн телефон

Мобиком 11,000, Скайтал 6,000, Юнител 11,800 хэрэглэгчтэй.

6.10.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Ерөнхийдөө Монгол дахь хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал сайжирч байгаа ч, засаг захиргаанаас санхүүждэг ХМХ аймгуудад олон байна. Уг нь энэ бол хуулиар хориглосон юм. Өөр нэг гол асуудал нь, хөдөөд мэргэшсэн, ур чадвартай сэтгүүлчид дутмаг байна. Тэднийг Улаанбаатар хотод сургалтанд явуулахаар эргэж ирдэггүй. Орон нутагтаа

үлдсэн хэсэг нь орон нутгийн сэтгүүл зүйн үнэлэмжийг дээшлүүлэх идэвхтэй сонирхол, зүтгэлгүй ажээ.

О.Хишигсүрэн хөтөлбөр солилцох, бусад ФМ радиотой идэвхтэй хамтран ажиллах явцдаа нэвтрүүлгийн чанар бол радиогийн амжилтын гол түлхүүр гэдэгт итгэжээ. 21 аймаг, Улаанбаатар хотын зарим радио нийлж, “Радиогийн нийгэмлэг” байгуулж эхлээд байна. Нийгэмлэг радио хоорондын хамтын ажиллагааг дэмжихэд чиглэнэ.

Орон нутгийн хэвлэл мэдээллийг чадавхижуулахын тулд Улаанбаатар хотын байгууллагуудаар дамжуулж бус, шууд газар дээр нь явуулах хэрэгтэй гэдгийг О.Хишигсүрэн онцолж байв.

6.11 ГОВЬ АЛТАЙ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 142,000 км²
Хүн ам: 65,000; аймгийн төв Алтайд 20,200
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 2730,5 төгрөг

Аймаг дизель станцын цахилгаан үүсвэртэй.

6.11.1 Үндэсний ХМХ

Телевиз

Аймгийн төв, зарим сум Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ5/ТВ9 болон UBS/25-р суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

Засаг захиргааны дүн мэдээгээр малчдын 50 орчим хувь нь сансрын тавган антентай ажээ.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна.

Үндэсний сонин

Үндэсний хэмжээний сонин хэвлэлийг аймагт долоо хоногт хоёр удаа онгоцоор, нэг удаа шуудангийн машинаар хүлээн авна. Аймгаас сумдад долоо хоногт нэг удаа, багуудад түүнээс цөөн удаа хүргэнэ.

Дийлэнх нь “Хүмүүс” зэрэг долоо хоног тутмын сонин хэвлэл.

Мэлээлэл Харилцааны Технологи

Засаг захиргааны бiгд хэлж байгаагаар интернетийн холболт муу ажээ. Засаг захирааны байгуулагуудаас гадна хоёр интернет кафетай, 20-30 хэрэглэгч утсаар интернэтэд холбогддог. Аймгийн төв, зургаан суманд үүрэн телефоны сүлжээ барьдаг.

6.11.2. Орон нутгийн ХМХ

Радио

“Алтанговь” ФМ-107.5 радио

Эзэн/захирал: Ж.Эрдэнэчимэг

“Алтанговь” хувийн радиог аймгийн мэдээлэл холбооны инженер Ж.Эрдэнэчимэг 2005 онд байгуулжээ. Үүсгэн байгуулагч, түүний дунд сургуулийн хоёр охин, нэг ажилтан, сайн дурын ажилтнууд радиог ажиллуулдаг. Өргөн нэвтрүүлгээ 09:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөрийнх нь 60 хувийг орчин үеийн, монгол ардын дуу, солонгос, орос зэрэг янз бүрийн дуу хөгжмийн нэвтрүүлэг эзэлдэг. Үлдсэн хэсэг нь зар сурталчилгаа, боловсрол, хүүхдийн нэвтрүүлэг зэргээс бүтнэ. Хатуу хучилттай замын нүхүүдийг арилгах талаар асуудал хөндсөн **“Өнөөдрийг хүртэл”** хэмээх сонсогчтой шууд холбогдон, санал бодлыг сонссон нэвтрүүлэг нь олон нийтэд хамгийн их хүрчээ.

Радио залуучуудад зориулагдсан. Өсвөр насны хөтлөгчдийн хэлснээр, дунд сургуулийн хүүхдүүдийн сонсох дуртай радио ажээ. Зар сурталчилгаа, утасны орлогоор санхүүждэг.

Монголын Үндэсний Радио/

Бүсийн Олон Нийтийн “Говь-Алтай” радио

Мэдээллийн төвийн дарга: Г.Чардаг

Олоо нийтийн радио нь аймаг, бүсийн мэдээ, зарлалыг долоо хоногт хоёр удаа, 30 минутаар МҮОНР-ийн сувгаар дамжуулдаг. Радио нь баруун таван аймгийг хамардаг. Зургаан ажилтны хоёр нь сэтгүүл зүйн мэргэжилтэй. Тоног төхөөрөмж хуучирч муудсан.

Орлогынхоо тал хувийг аймгийн захиргаанаас, үлдсэнийг зар сурталчилгаанаас олдог. Мэдээллийн төвийн даргын ярьснаар, өргөн нэвтрүүлгийг төрийнхөөс олон нийтийнх болгон өөрчилж, засаг захиргааны шууд хяналтаас гаргасан ч, радио тэдний дуу хоолой хэвээр байгаа ажээ.

Мэдээллийн төв орон нутгийн телевиз ажиллуулж байсан боловч, тоног төхөөрөмж хуучирч муудсаны улмаас хаагджээ.

Радио, Телевиз

ФМ радио, телевиз нь 2004 оны сонгуулийн өмнө МАХН-ын хөрөнгөөр байгуулагдсан. Захирлынх нь ярьж байгаагаар, одоо МАХН-аас хараат бус ажилладаг. Телевиз, радио үндсэндээ зар сурталчилгаа, утасны орлогоороо санхүүждэг.

“Бурхан буудай” ТВ

Захирал: Б.Дорж

Өргөн нэвтрүүлгээ Даваа, Пүрэв, Баасан гарагт, 19:00-23:00 цагийн хооронд дамжуулдаг. Эрхлэгчээс гадна орон тооны хоёр ажилтантай. Хөтөлбөр нь, мэдээ, цэнгээнт нэвтрүүлэг, уран сайхны кино, зар сурталчилгаа зэргээс бүтнэ.

“Хантайшир” ФМ 104.5

Захирал: Х.Алтаннар

Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 09:00-23:00 цагийн хооронд дамжуулдаг. Орон тооны нэг ажилтантай. Хөтөлбөрт дуу хөгжим зонхилж, цэнгээнт нэвтрүүлэг, орон нутгийн мэдээ, зарлал, зар сурталчилгаа зэргийг бэлтгэж дамжуулдаг.

Сонин

“Цахиур төмөр” сонин

Эрхлэгч: Д.Сэрээтэр

Хоёр сар тутмын, хувийн энэ сонинг Д.Сэрээтэр 1999 онд үүсгэн байгуулжээ. 500 хувь хэвлэгддэг. 100-аь оьæéí аймгийн төв, үлдсэнийг нь сумд, бусад газарт борлуулдаг. Эрхлэгч нь сониныхоо сурвалжлагчаас эхлээд нягтлан хүртэл бүх ажлыг °° ð°° гардан хееäýã

Албаны мэдээ, төлбөрт нийтлэл, орон нутагт болсон үйл явдлыг бичиж нийтэлдэг. Редакцийн нийтлэл, төлбөрт нийтлэл хоёрыг ялгаж зааглахгүйгээр нийтэлдэг.

6.11.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Орон нутгийн хэвлэл мэдээллийг засаг захиргаа, МАХН эзэмшсэн хэвээр байна. Яаж ч бодсон, орон нутгийн хэвлэл мэдээллүүд нь сэтгүүл зүйн шүүмжлэлт материал бэлтгэх, нийгмийн “хоточ нохой” байх үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх боломжгүй байна. Гэхдээ, хувийн ФМ радио илүү шинэ соргог хандлагатай, залуу сонсогчдод нэвтрүүлгээ зориулж байна.

6.12 ХОВД АЙМАГ

Нутаг дэвсгэр: 76,000 км²
Хүн ам: 91,000; аймгийн төв Ховдод 33,000
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 1389,8 төгрөг

Ховд аймагт үндэсний цөөнх нь казахууд ажээ. Аймгийн төв, зургаан сум Оросын Холбооны Улсаас эрчим хүч авдаг. Усан цахилгаан станц барьж байгаа.

6.12.1. Үндэсний ХМХ

Телевиз

Аймгийн төв, зургаан суманд Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, хүлээн авах, дамжуулах хоёр станцаар ТВ5/ТВ9 болон UBS/25-р суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

Засаг захиргааны дүн мэдээгээр малчдын 70 хувь нарны зай, 20 хувь сансрын хүлээн авагчтай. Тэдний олонх нь хоёроос таван суваг, тухайлбал, Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, ТВ5/ТВ9, UBS/25-р суваг, мөн Өвөр Монголын суваг хүлээн авдаг.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна.

Бүсийн Олон Нийтийн Радиогийн 30 минутын өргөн нэвтрүүлгийг долоо хоногт хоёр удаа, давталттайгаар Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн сувгаар Говь-Алтай аймгаас хүлээн авдаг.

Мэдээлэл Харилцааны Технологи

Аймаг 13,000 суурин телефон хэрэглэгчтэй. Аймгийн төв, гурван суманд үүрэн телефоны сүлжээ барьдаг. Үүрэн телефоны 6,000 хэрэглэгчтэй.

Телевиз

“Ховд” ТВ

Ү.Сахирал | Ү.Х.Алтантуяа

Н.Дамба 1997 онд орон нутгийн засаг захиргааны дэмжлэгээр байгуулсан. Хоёр цаг 30 минутын өргөн нэвтрүүлгийг өдөр бүр дамжуулдаг. Хоёр сэтгүүлч, хоёр зураглаачаа. Хөтөлбөр нь, орон нутгийн засаг

захиргаа, бизнесийн мэдээ, нийгмийн асуудлууд, боловсролын нэвтрүүлэг зэргээс бүтнэ.

Радио

“Хит” ФМ-107.1

Эзэн/захирал í ü Б.Номинчимэг

Хувийн радиог Б.Номинчимэг 2006 оны 7 äóäääð сард байгуулсан. Оүй ä çүсгэн байгуулагч, сэтгүүлч, дунд сургуулийн гурван хөтлөгч õççõõ, нягтлан áî äî ã- ажилладаг. Өргөн нэвтрүүлгээ 08:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөрийн 60 хувь нь орчин үеийн, монгол ардын, гадаадын дуу хөгжим эзэлдэг. Үлдсэн нь орон нутгийн үйл явдлын мэдээ, утсаар өгсөн саналууд, олон нийтэд зориулсан зарлал, зар сурталчилгаа зэргээс бүтнэ.

Радио өргөн нэвтрүүлэг дамжуулах цагаа худалддаг. Орон нутагт өргөн нэвтрүүлэг хөгжүүлэхэд үе радио хувь нэмрээ оруулна гэдэгт захирал нь итгэдэг ажээ. Гол төлөв залуучуудад зориулсан нэвтрүүлэг хийдэг. Зар сурталчилгаа, шууд утасны, төлбөрт нэвтрүүлгийн орлогоор санхүүждэг.

МАХН-ын санхүүжилтээр 2004 байгуулагдсан өөр нэг ФМ радио ярилцлагад оролцоогүй.

Сонин

“Ховдын мэдээ” сонин

Эзэн/эрхлэгч í ü А.Бямбасүрэн

Орон нутгийн сонин нь 10 хоног тутам, улирлаас хамааран 350-500 хувиар хэвлэгддэг. Сонины 40 хувийг Ховдод, үлдсэнийг сумд, бусад газарт борлуулдаг. “Ховдын мэдээ” сонин нь эзнээс гадна сэтгүүлч, дизайнер, нягтлан гэñуї гурван ажилтантай. А.Бямбасүрэн МХХ-ийн түргэвчилсэн сургалтад хамрагдсан, “Глоб Интернэшнл” ТББ-ын шуурхай мэдээний сурвалжлагч, МХХ-ийн баруун бүсийн зохицуулагчаар олон жил ажиллаж байна.

Хараат бус, хэн нэгэнд тал тохой татахгүйгээр ажиллахыг хичээдэг. Нийгэм, улс төрийн асуудлаар шүүмжлэлт, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн материал нийтэлдэг. “Айро Монгол” ХХК-д байсан авилгыг илчлэн бичжээ. Гэхдээ зарлал, аймгийн захиргаа, бусад эх үүсвэрээс өгсөн төлбөрт нийтлэлийг редакцийн нийтлэл, төлбөрт нийтлэлийн аль нь болохыг тодорхой зааг ялгаагүйгээр нийтэлж байв. Зар сурталчилгаа, засаг захиргааны мэдээлэл, төлбөрт нийтлэл, захиалгын орлогоор санхүүждэг.

Саяхан энэ аймагт хэвлэх үйлдвэр байгуулагдсан ч, АЗ-ийн уламжлалт хэмжээүүд хэвлэх боломжгүй аж. Хэвлэх үйлдвэр нь ном, гарын авлага зэргийг ө хэвлэдэг.

6.12.3. Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Орон нутгийн хэвлэл нь сэтгүүл зүйн хэм хэмжээг барьж ажилладаг. МХХ-гээс 2005 оны “Оны шилдэг орон нутгийн сонин”-оор 2005 онд шалгарууёжээ. Засаг захиргааны зүгээс удаа дараа сониныг дарж, номхруулахыг оролдсон ч энэ нь бүтэлгүйтжээ. Сэтгүүлчийг нэг удаа нэр төр гутаасан хэргээр сүрдүүлж, “Айро Монгол” ХХК-ны авилгын асуудлыг хөндөж бичсэнтэй нь холбогдуулан мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардсан байна. Харин “Глоб Интернэшнл” ТББ-ын шуурхай мэдээний дараа, “Айро Монгол” ХХК түүний мөрөөр судалгаа хийж, билетийн үнийг дамлан худалдаж байсан хоёр кассчинг ажлаас нь халжээ.

Бага санхүүжилттэй ФМ радионууд нь залуу сонсогчдыг татахад анхаарлаа хандуулж байна.

Аймгийн төвийн хэвлэл мэдээллийн байдал өргөн хүрээтэй байна. Шинээр байгуулагдсан хэвлэх үйлдвэр ФМ радио, телевиз байгуулахаар төлөвлөж байгаа учраас хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн нэмэгдэх рүү аажим аажим. Харин ХМХ бизнесийн хувьд гадны мэдэгдэхүйц эх үүсвэргүйгээр хэрхэн тогтвортой ажиллахыг тааварлахад бэрх.

6.13 АРХАНГАЙ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 55,300 км²
Хүн ам: 90,400; аймгийн төв Цэцэрлэгт 17,900
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 791,4 төгрөг

Аймгийн төв Цэцэрлэг, бүх сум 100%, багийн 30 хувь төвийн эрчим хүчнээ илүүдэл хангалттай холбогдсон.

Аймгаас Улаанбаатар хот руу шилжин суурьших хөдөлгөөн их байна.

6.13.1 Үндэсний ХМХ

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийг Цэцэрлэг дэх газрын хүлээн авах, станцаараа дамжуулдаг. Хоёрдугаар сувгаар орон нутгийн телевиз, Өвөр Монголын суваг хоёрыг солбиж үзүүлдэг. ЗДТГ-ын дүн мэдээгээр кабелийн холболт 10 хувьтай байна. Нэлээд олон сумд үндэсний хэмжээний телевизийн сувгуудын заримыг үзүүлдэг. ЗДТГ-ын мэдээлснээр, малчдын 40 хувь сансрын хүлээн авагчтай. 440 хэрэглэгчтэй, 14 сувагтай кабелийн телевизтэй. Сансрын 16 суваг утасгүй кабелиар 80 хэрэглэгч хүлээн авах боломжтой.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна.

Сонин

ЗДТГ үндэсний хэмжээний өдөр тутмын сонингоос 550 өдөр тутмын сонингоос захиалдаг. Өдөр тутмын бус, гол төлөв долоо хоног тутмын сонин 12,000 захиалагчтай. Захиалагчдын 60-70% нь аймгийн төвийнх. “Бэлэн мөнгөний хомсдол, малчид телевиз үзэх боломжтой болсон зэргээс хамааран сонины захиалга буурч байгаа” гэж ЗДТГ үздэг байна.

Мэдээлэл Харилцааны Технологи

1650 суурин телефонтойгоос 200 нь Цэцэрлэг хотын төвөөс бусад газарт байрладаг. Үүрэн телефоны 5000 гаруй хэрэглэгчтэй болсон нь сүүлийн хэдхэн жилийн хугацаанд суурин телефон хэрэглэгчдийн тооноос хол давжээ.

Цэцэрлэг, цөөн хэдэн сумд шилэн кабель тавигдсан. 2008 он гэхэд бүх сумыг шилэн кабельд холбох төлөвлөгөөтэй ажээ. Шилэн кабелийг эхний ээлжинд, үүрэн телефон, интернэт, аймаг, сумын эмнэлэг, сургууль гэх мэт төрийн үйлчилгээний байгууллагад ашиглана.

6.13.2 Орон нутгийн ХМХ

“ФМ 107.5” радио, “Тамир” ТВ, “Архангайн амьдрал” сонин
Үүрэн аймгийн Мэдээллийн төвийн дарга О.Амарзаяа

Аймгийн Мэдээллийн төв нь 2005 онд, өрсөлдөж байсан гурван хэвлэл мэдээллийн хэрэгслийн суурь дээр байгуулагдсан. Аймгийн төсвөөс авсан 30 сая төгрөгийн “зээл”-ээр санхүүжиж байгаа. Мэдээллийн төвийн дарга орон нутгийн засаг захиргаанаас зарим талаар хараат байдгаа хүлээн зөвшөөрч байна. Өмчлөл нь одоохондоо бүрэн тодорхой бус, энэ намар шийдвэрлэгдэх бололтой. Мэдээллийн төв сонин, ФМ радио, телевиз ажиллуулдаг. Тэдгээр нь ЗДТГ-ын байранд байдаг.

Хэвлэл мэдээллийн гурван хэрэгсэлд орон тооны найман хүн ажилладгаас хоёр нь бэлтгэгдсэн сэтгүүлч. “Санхүүгийн эх үүсвэр, сайн бэлтгэгдсэн боловсон хүчин хомсдолтой” гэж төвийн дарга хэлэв. Энд тэмдэглэж хэлэх нэг зүйл бол сонины өмчлөгч нь “Эгэл” ХХК нь хэдий ч, хэвлэл мэдээллийн гурван хэрэгслээс олсон бүх орлого нь үүний төвийн орлого болдог. “Эгэл” ХХК уг сонины санхүү, нийтлэлийн бодлогод оролцдоггүй.

Хэвлэл мэдээллийн гурван хэрэгсэл нь орон нутгийн эрх баригчдаас шууд хамааралгүй. Бусад олонхи аймагтай харьцуулахад ЗДТГ-ын албан

Санхүүгийн байдал сайнгүй ч, эзэн нь радиогоо ажиллуулах сонирхолтой санагдсан. Мэргэжлийн ур чадвар бүхий боловсон хүчин дутмаг тул эфир нь байнга тасалддаг байна.

6.13.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Архангай аймагт Мэдээллийн төвийн гурван ХМХ зонхилох байр суурьтай байна.

Орон нутгийн Хэвлэл Мэдээллийн төвийн дарга, эрхлэгч О.Амарзаяа нь сэтгүүл зүйн баримтад тулгуурласан, шүүмжлэлт сайн бүтээлээ хэвлэл мэдээллийн гурван хэрэгслээр дамжуулахын төлөө зүтгэж байна. Тэрээр Мэдээллийн төвийг хараат бус олон нийтийн статустай болгох, эсвэл хувьчлах саналыг аймгийн ИТХ-д тавиад байна.

Алслагдсан сум, малчдад ямар нэг байдлаар зөвхөн орон нутгийн сонин ё очдог ажээ.

6.14 ЗАВХАН

Нутаг дэвсгэр: 82,000 км²
Хүн ам: 79,000; аймгийн төв Улиастайд 16,100
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 2345,0 төгрөг

Аймгийн төв Улиастайд дизель станц цахилгаанаар хангадаг. Усан цахилгаан станц нь төлөвлөгдсөн хугацаандаа ашиглалтанд ороогүй.

6.14.1 Үндэсний ХМХ

Телевиз

Аймгийн төв, нэг сум нь хүлээн авах дамжуулах станцийн нэг сувгаар Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, хоёр дахь сувгаар орон нутгийн телевиз, мөн ТВ5, ТВ9 телевизийн өргөн нэвтрүүлгийг хүлээн авч, солбиж үздэг. Мэдээллийн төвийн даргын дүн мэдээгээр, кабелийн холболт 10 хүрэхгүй хувьтай байна.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна. Бүсийн Олон Нийтийн Радиогийн 30 минутын өргөн нэвтрүүлгийг долоо хоногт хоёр удаа, давталттайгаар Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн сувгаар Говь-Алтай аймгаас хүлээн авдаг.

6.13.2 Орон нутгийн ХМХ

“Завхан” ТВ

Захирал, аймгийн Мэдээллийн төвийн дарга: Д.Нацагмаа

ЗДТГ-ын мэдэлд байсан орон нутгийн телевизийг аймгийн ИТХ-аас ажиллуулж байгаа. Өмчлөлийг шилжүүлсний шалтгаан нь төр, түүний байгууллага өмчлөлдөө ХМХтэй байхыг хориглосон хууль батлагдсан явдал байв. Гэсэн ч, өмчлөлийг шилжүүлснээр өөрчлөлт гараагүй гэж Мэдээллийн төвийн дарга ярилаа. Редактор, сэтгүүлч, оператор, нийт гурван ажилтантай. Долоо хоногт хоёр удаа, 2-3 цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг.

Хөтөлбөр нь, зар сурталчилгаа, ЗДТГ, сумд, улс төрийн нам, янз бүрийн компаний гэх мэт захиалагчтай төлбөрт нэвтрүүлэг зэргээс бүтнэ.

Санхүүгийн хүндрэл тулгардаггүй ч, засаг захиргаанаас дэмжлэг авдаг учир эрэн сурвалжлах, хараат бус сэтгүүл зүйн бүтээл хийж чаддаггүй.

“Улиастай” КаТВ

Захирал: Г.Гантогтох

“Уран байгаль трэйд” ХХК 1998 онд байгуулсан. Орон тооны гурван ажилтантай. Орос, Өвөр Монгол, Энэтхэгийн гэх 13 сувгийг кабелийн сүлжээгээр дамжуулдаг.

Радио

“Улиастай” ФМ 106.5

Захирал: Б.Отгонбаяр

Хувийн “Улиастай” ФМ радиог худалдааны бизнес эрхлэгч ᠔᠘1 2006 онд үүсгэн байгуулсан. Мэдээлэл холбооны инженер мэргэжилтэй түүний хүү, өөр хоёр залуу хөтлөгчтэй хамтран ажиллуулдаг. Бэлтгэгдсэн сэтгүүлчтэй болох зорилготой.

Дуу хөгжим голдуу 16-18 цагийн өргөн нэвтрүүлгийг өдөр бүр явуулдаг. Телевизээс авсан үндэсний хэмжээний мэдээг дамжуулдаг. Орон нутгийн хараат бус мэдээллээр хангах зорилготой. Орлогоо зар сурталчилгаа, шууд утасны, төлбөрт нэвтрүүлгээс олдог.

“Этүгэн” ФМ 103.5

Эзэн/захирал: Д.Эрдэнэсайхан

Мэдээлэл холбооны инженер Д.Эрдэнэсайхан 2005 онд үүсгэн байгуулсан. Тэрээр телевиз, сонин ажиллуулах гэж оролдоод амжилт олоогүй ажээ. Өдөрт 16 цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг. Хөтөлбөр нь,

дуу хөгжим, мэндчилгээ, зарлал, зар сурталчилгаа, зугаа цэнгээнт, боловсролын нэвтрүүлэг, Улиастайн өдөр тутмын үйл явдал зэргээс бүтнэ. Орлогоо зар сурталчилгаа, шууд утасны, төлбөрт нэвтрүүлгээс олдог. Орон тооны гурван ажилтантай.

Сонгуулийн үеэр ажиллаж байсан, тогтмол бус ажиллагаатай өөр хоёр ФМ радио судалгаанд хамрагдаагүй.

Сонин

“Завхан” сонин

Эрхлэгч: Б.Идэр

Ардчилсан Нам засгийн эрх барьж байсан 1996-2000 оны үед хуучин коммунист сонинг хаагдсанаас хойш “Эгэл” ХХК 2001 онд “Завхан” сонинг байгуулжээ. Энэ сонин нь 10 хоног тутам, улирлаас хамааран 600-1000 хувиар хэвлэгддэг нь харьцангуй өндөр хувь юм. Сонины 20 хувийг Улиастайд, үлдсэнийг нь сумд, бусад газраар борлуулдаг.

Эрхлэгч, Улаанбаатар хотод сэтгүүлчийн мэргэжил эзэмшсэн эмэгтэй сэтгүүлч, менежер, зар сурталчилгаа хариуцсан ажилтан гэсэн дөрвөн ажилтантай. Эрхлэгч нь коммунист дэглэмийн үед сэтгүүлчээр ажиллаж байсан ч, түүнийг улс төрийн шалтгаанаар 1991-2004 онд ногооны талбай руу шилжүүлжээ. 2004 онд эрхлэгч болон эргэж ирсэн. Сумдын захиргаа өөрийн нутагт мэдээлэл цуглуулах үүрэг хүлээдэг тогтолцоо бий болгожээ. Орон нутгийн тухай эдгээр мэдээлэл алслагдсан орон нутагт харьцангуй өндөр захиалагчтай байхад нөлөөлдөг байна.

Сонинд албан ёсны төлбөрт мэдээлэл, орон нутгийн хөгжлийг хөхиүлэн дэмжсэн янз бүрийн төрөл зүйлээр бичигдсэн нийтлэл, ач холбогдол бүхий зарлалууд нийтлэгддэг. Сонин сумын засаг дарга нарыг шүүмжилдэг ч, аймгийн засаг даргад халдаж чаддаггүй.

Ашиг олдоггүй ч, санхүүгийн байдал нь тогтвортой бололтой. “Эгэл” ХХК редакцийн бодлогод шууд оролцож, нөлөөлдөггүй тул сонин ямар нэг бэрхшээлгүйгээр хэвлэгдэж гардаг ажээ.

“Завханы мэдээ” сонин

Эрхлэгч: Д.Уламбаяр

“Завханы мэдээ” сонинг Д.Уламбаяр 1993 онд үүсгэн байгуулсан. Орон тооны гурван ажилтантай. 1,000 хувиар хэвлэгддэг. Тогтмол бус.

6.14.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Энэ аймагт хараат бус сэтгүүл зүй үгүй. Үүнд сонин, телевизүүд нэг их санаа зовдоггүй. ФМ радио нь хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэхийг эрмэлзэж, санхүүгийн байдлаа сайжруулж байна. Сум, малчдад зөвхөн орон

нутгийн сонин хүрдэг тул тэдний мэдээлэл олж авах боломж хязгаарлагдмал.

“Дэлхийн Зөн” олон улсын байгууллагаас 500 ядуу өрхийг дэмжих төсөл хэрэгжүүлж эхлээд байна. “Дэлхийн Зөн” ОУБ ядуу хүмүүсийг дороос нь дэмжих хандлага, хоёр талын мэдээллийн урсгалаар дамжуулан оролцоонд түшиглэн, чадавхижуулах бодлоготой ажээ. Ядуу хүмүүс аль ч хэвлэл мэдээллийн хэрэгслийг хүлээн авах боломжгүй тул одоогийн ХМХ нь мэдээлэл түгээх зөв зүйтэй арга гэж уг төслийн менежер нь бодохгүй байна.

6.15. УВС АЙМАГ

Нутаг дэвсгэр: 69,000 км²
Хүн ам: 83,500; аймгийн төв Улаангомд 26,500
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 1614.3 төгрөг

Аймгийн төв, 10 сум нь цахилгаан эрчим хүчээ Оросын Холбооны Улсаас авдаг.

6.15.1 Үндэсний ХМХ

Телевиз

Аймгийн төв, ойролцоох хоёр суманд газрын хүлээн авах, дамжуулах станцаараа Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, орон нутгийн телевизийн өргөн нэвтрүүлэг үздэг.

Кабелийн телевиз нь сансрын утасгүй кабелиар нэвтрүүлгээ дамжуулдаг ч, үүнийг хүн амын 10 хүрэхгүй хувь нь хүлээн авдаг. Сансрын хиймэл дагуулаас малчдын 15-20 хувь нь нэвтрүүлэг хүлээн авч байна гэсэн дүн мэдээг ЗДТГ гаргажээ.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна.

Бүсийн Олон Нийтийн Радиогийн 30 минутын өргөн нэвтрүүлгийг долоо хоногт хоёр удаа, давталттайгаар Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн сувгаар Говь-Алтай аймгаас хүлээн авдаг.

Мэдээлэл Харилцааны Технологи

Аймгийн төвд 2500-3000 суурин телефон хэрэглэгчтэй. Мөн аймгийн төв, таван суманд үүрэн телефоны сүлжээ барьдаг. 10000 орчим үүрэн телефон хэрэглэгчтэй.

6.15.2 Орон нутгийн ХМХ

Радио, Телевиз

“Сама” ТВ, “Улаан Уул” ФМ-101.1 радио

Эзэн: С.Жавхлан, эрхлэгч: С.Хунчин

Өувийн телевиз 2005 онд С.Жавхлан байгуулсан. Таван цагийн өргөн нэвтрүүлгийг долоо хоногийн дөрвөн өдөр дамжуулдаг. Бямба гарагт сайн нэвтрүүлгүүдээ давтан үзүүлдэг. Хөтөлбөр нь, албан ёсны мэдээ, төлбөрт нэвтрүүлэг, орон нутгийн мэдээ, цаг агаар, бизнесийн мэдээ, хүүхэлдэйн кино, хошин шогийн тоглолт, зар сурталчилгаа, зурхай, уран сайхны, олон ангит кино зэрэг нэлээд өргөн агуулгатай.

Телевиз зургаан ажилтантай. Зар сурталчилгаа, төлбөртэй нэвтрүүлэг, сарын 300 төгрөгтэй тэнцэх сарын сайн дурын хураамжаар санхүүжинэ. Айл өрхийн 15 орчим хувь нь хураамж төлдөг. С.Хунчин хэлэхдээ, зар сурталчилгааны зах зээл бага байгаа нь телевиз хөгжүүлэхэд саад болдог, бизнесийн зар сурталчилгаа ойрын хугацаанд өсөхгүй бол хаагдаж болзошгүй гэв.

С.Жавхлан мөн 2002 онд ФМ радио байгуулсан. Орон тооны нэг ажилтантай, дунд сургуулийн гурван охин сайн дураар тусалдаг. Хөтөлбөр нь, гол төлөв дуу хөгжим, утсаар ая дууны мэндчилгээ дэвшүүлэх, зарлал зэргээс бүтнэ. Гол орлого нь шууд утаснаас ордог. Энэ нь нэмэгдэж байгаа. Радио, телевиз хоёр нь хамтарч ажилладаггүй, бие биенээ дэмжиж, идэвхжүүлсэн үйл ажиллагаа явуулдаггүй.

Радио

“Шинэ зууны” ФМ-100.6

Захирал: Мөнхчулуун

Бизнес эрхлэгч **Мөнхчулуун** Өрсөлддөг хувийн ФМ радиог бизнесээ дэмжих арга хэрэгсэл болгон, 2003 онд байгуулжээ.

Хөтөлбөр нь, үлгэр, боловсрол, мессеж, уралдаан тэмцээн, төрөл бүрийн дуу хөгжим зэргээс бүтнэ. Бусад радиогийн адил үйл ажиллагаагаа явуулдаг.

Сонин

“Увсын Амьдрал” сонин

Эрхлэгч: Баттөмөр

“Увсын Амьдрал” сонин сард хоёр удаа 500 хувиар аймгийн ИТХ-ын дэмжлэгээр хэвлэгддэг. Сонины 50 хувийг аймгийн төв Улаангомд, үлдсэнийг сумд, бусад газарт борлуулдаг.

Орон тооны хоёр ажилтантай. Улс төрийн шинэ албан тушаалд томилогдсон сэтгүүлч Батхүү нь Улаанбаатар хотод мэргэжил эзэмшсэн. Орон нутгийн засаг захиргааны төлбөрт мэдээлэл, албаи ёсны мэдээ, Увс аймагт болж буй үйл явдал, тулгамдсан асуудал, орон нутгийн мэдээ нийтэлдэг. “Нинжа” нартай холбоотой байгаль орчны асуудлыг хөндсөн гэх мэт шүүмжлэлт материал ч нийтэлдэг.

Санхүүгийн хүндрэлийн улмаас 10 хоног тутам хэвлэгддэг байсан сонин сард хоёр удаа гарах болжээ. Сонинд ганц хоцрогдсон компьютерээс өөр тоног төхөөрөмж байхгүй. “Увсын амьдрал” сонины нийтлэлд гомдсон хүмүүс байнга түүнд ханддаг ч, хэн ч зарга үүсгээгүй ажээ.

6.15.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Увс аймагт орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд санхүүжилтийн төлөө тэмцэлдсээр байна. Энд жинхэнэ хараат бус, шүүмжлэлт сэтгүүл зүй алга. Бүх ХМХ санхүүгийн бэрхшээлтэй.

Мэдээллээ түгээх арга олох хэцүү ч, ямар ч атугай олон нийт мэдээлэл сайтай байхыг чухалчилдаг гэж ЗДТГ-ын Батнасан онцлон ярьсан.

6.16 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 45,800 км²
Хүн ам: 95,200; аймгийн төв Өлгийд 28,500
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 4899,4 төгрөг

Баян-Өлгий аймаг нь Казах үндэстэн (хүн амын 90 хувь) зонхилсон аймаг. Судалгаа хийж байх үеийн байдлаар 90,000 орчим оршин суугч Казакстан руу цагаачилжээ.

6.16.1 Үндэсний ХМХ

Телевиз

24 сувагтай кабелийн телевизийн сүлжээтэй, 3500 хэрэглэгчтэй. Малчдын 15-20 хувь сансрын хүлээн авагчаар телевиз үздэг гэсэн тооцоо байна.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна.

6.16.2 Орон нутгийн ХМХ

Орон нутгийн хэвлэл мэдээлэл гол төлөв казах хэл дээр гардаг.

Сонин, Радио, Телевиз

“Шинэ эрин” (“Жана Дауэр”) сонин, Баян өлгий Радио, Баян өлгий ТВ
Захирал, аймгийн Мэдээлэл Технологийн Төвийн дарга: Р.Сураган
Сонины эрхлэгч: Н.Эрбахыт

Орон нутгийн засаг захиргаанаас Мэдээлэл Технологийн Төв (МТТ)-д санхүүгийн дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьдаг. МТТ нь дотроо Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн салбар радио, түр хугацаагаар зогссон телевиз, тогтмол бус гаралттай сонин (гурван сард хоёр удаа)-той.

МТТ-ийн 18 ажилтны цөөн хэд нь бэлтгэгдсэн сэтгүүлч байна. Бүх ХМХ даргын хяналтад байдаг. Бусад ХМХтэй харьцуулахад МТТ нь орон нутгийн засаг захиргаанаас санхүүгийн дэмжлэг сайн авдаг (Жилд 25-30 сая төгрөг). Орон тоо илүүдэлтэй гэж хэлэхээргүй, хангалттай боловсон хүчинтэй.

Санхүүгийн дэмжлэг сайтай ч, дээрх хэвлэл мэдээллийн гурван хэрэгсэл нь бүгд хоцрогдсон тоног төхөөрөмжтэй. Олон нийтийн гэж нэрлэгдэж буй радио орой бүр нэг цагийн өргөн нэвтрүүлгийг МҮОНР-ийн өмчид байдаг дахин дамжуулах станцаар цацдаг. Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймаг бүхэлдээ, хөрш Оросын Холбооны Улс, БНХАУ-ын казах хэлтнүүд хүлээн авдаг.

Нэвтрүүлгээ казах хэл дээр явуулна. Хөтөлбөр нь, зөрчилтэй бус албан ёсны мэдээ, үндэсний, олон улсын мэдээ, алдсан малын зар, эмгэнэл зэрэг нийтэд зориулсан мэдээллээс бүтнэ. Утсан харилцаа холбоо муу хөгжсөн энэ нутагт эмгэнэлийг дамжуулах нь төрөл садангуудад нь оршуулгын ажилд оролцох боломжийг олгодог учраас аймгийн төвөөс бусад газарт ч радиог нэлээд үнэлдэг тухай МТТ-ийн дарга ярьсан юм.

Орон нутгийн сонины гаралт нь тогтмол бус, захиалагчгүй. Зар сурталчилгаа нь хэвлэлтийн зардлаа нөхдөг. Сонины эрхлэгч нь Казакстан улсад хэл, уран зохиолын чиглэлээр суралцсан, хэвлэл мэдээлэлд олон жил ажиллаж байгаа. Албан ёсны мэдээ, соёл урлаг, түүх, онцлох үйл явдал, уншигчдын захидал, зар сурталчилгаа нийтэлдэг. Хааяа сониндоо хүүхдийн хавсралт гаргадаг. Нийтлэлийн бодлогын хувьд сонин хараат бус байж чаддаггүй гэнэ.

Орон нутгийн захиргаа, холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллагуудын хамгийн түрүүнд анхаарлаа хандуулахыг шаардаж буй асуудал бол Радио Өргөн Нэвтрүүлэг Дахин Дамжуулах Станц (РӨНДДС)-ын шинэчлэлт юм. Энэ станц нь Улсын Мэдээлэл, Харилцаа холбоо, Технологийн Газрын (УМХХТГ)-ын Радио Телевизийн Сүлжээ (РТС)-ний харъяалалд байдаг, Монголын дамжуулах тоног төхөөрөмжийг сайжруулах Япон Улсын Засгийн газрын санхүүжилтээр хийгдэх ажлын хүрээнд

хамрагдаагүй ажээ. 1965 онд Чехословакийн Тесла-ийн тоног төхөөрөмжтэй байгуулагдсан. Одоо оросын сэлбэг запаст найддаг. 30Квт-ын хүчин чадлын хагасыг ашиглаж байна. МТТ бэлтгэсэн орон нутгийн радиогийн нэг цагийн өргөн нэвтрүүлэг, Улаанбаатар хотын радиогийн 17 цагийн өргөн нэвтрүүлгийг нэг өдөрт дамжуулдаг. РӨНДДС-ийн дамжуулалтын нэг цагийн үнэ ханшаас үүдэн казах нэвтрүүлгийг нэмэгдүүлэх боломжгүй байна. Баян-Өлгий аймгийн Цахилгаан Холбооны газрын ерөнхий менежер Х.Үзбен, РӨНДДС-ийн дарга З.Асхар, УМТГ-ын РТС-ийн хэлтсийн дарга Т.Гантөмөр нар бүгд тоног төхөөрөмжүүд нь хэрэгцээнээс гарсан гэдэгтэй санал нийлж, хуучирч элэгдсэн тоног төхөөрөмжөө санхүүжилт хүрэлцээгүй, зохих запас сэлбэггүй учраас дамжуулалт удахгүй зогсоно гэж байв. Энэ тохиолдолд үндэсний цөөнх төрөлх хэлээрээ мэдээлэл хүлээн авах, солилцох боломжгүй болж, аймгийн өргөн нэвтрүүлэг зогсоно.

Орон нутгийн телевиз нь долоо хоногт гурван цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг байснаа, түр хугацаагаар зогссон. МТТ нь ФМ радио байгуулах сонирхолтой ажээ.

Телевиз

“Өлгий” ТВ

Эзэн/захирал /ү Х.Мейрам

Хувийн “Өлгий” телевизийг орон нутгийн бизнес эрхлэгч үүсгэн байгуулсан. “Глоб Интернэшнл” ТББ-аас хэрэгжүүлж буй “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих нь” төслийн орон нутгийн сурвалжлагчаар ажилладаг, Ардчилсан Намын гишүүн, сэтгүүлч И.Хуатай ажиллуулдаг. Долоо хоногт 5-зургаан цагийн өргөн нэвтрүүлгийг, давталттай дамжуулдаг. Ерөнхий редактор И.Хуатай, нийт долоон ажилтантай. Нэг нь сэтгүүл зүйн мэргэжилтэй.

Хөтөлбөр нь, орон нутгийн мэдээ, тусгай нэвтрүүлэг, концерт, зар сурталчилгаа зэргээс бүтнэ. Мэдээ, шүүмжлэлт нэвтрүүлэг хааяа бэлтгэдэг.

Радио

Шалхар ФМ 106.5

Захирал: У.Нурбек

Хувийн өмчийн ФМ радио 2004 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ 09:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөр нь, гол төлөв казах дуу хөгжим, цаг агаарын мэдээ, асуулт хариулт, хүүхдийн нэвтрүүлэг, утсаар ая дууны мэндчилгээ дэвшүүлэх, зарлал, зар сурталчилгаа зэргээс бүтнэ.

Радио нь Коран судрын нэг номлолоор долоо хоногт 30 минутын шашны нэвтрүүлэг бэлтгэдэг. Хоёр хөтөлгөч, 1 менежер, нийт гурван

ажилтантай. Шууд утасны, зар сурталчилгаа, төлбөрт нэвтрүүлгийн орлогоор санхүүжинэ.

“ФМ 104.5” радио

Эзэн/захирал: М.Айгулик

Хувийн өмчийн ФМ радио 2004 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ 08:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөр нь, гол төлөв казах дуу хөгжим, цаг агаарын мэдээ, асуулт хариулт, хүүхдийн нэвтрүүлэг, утсаар ая дууны мэндчилгээ дамжуулах, зарлал, зар сурталчилгаа зэргээс бүрдэнэ.

Гурван хөтөлгөч, хоёр менежер, нийт таван ажилтантай. Нэг хөтөлгөч нь сэтгүүл зүйн мэргэжилтэй. Шууд утасны, зар сурталчилгаанаас санхүүждэг. Ямар нэг төлбөрт нэвтрүүлэг хийдэггүй. Эхэн үедээ шууд утас хангалттай орлого олдог байсан. Өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр орлого нь нэлээн буурсан байна.

“Айхой” ФМ 107.5

Захирал: Б.Сайлаухан

Д.Эрбол 2004 онд үүсгэн байгуулсан. Орон тооны өөр хоёр ажилтантай. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 10:00-22:00 цагийн хооронд дамжуулдаг.

“Экран” ФМ 102.5

Захирал: Н.Дидар

А.Хуаныш 2006 оны 3 сард үүсгэн байгуулсан. Орон тооны өөр хоёр ажилтантай. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр, 24 цагаар дамжуулдаг.

6.16.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Орон нутгийн хэвлэл мэдээлэл туйлширсан байдалтай. Хууль тогтоомжтой зөрчилдөж буй ч аймгийн дэмжлэгтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээ засаг захиргаа хяналтад байлгаж, МАХН-ын дуу хоолой болгон ашиглаж байна. Хувийн телевиз нь Ардчилсан Намыг дэмждэг ч, хүчтэй дуугарах хангалттай нөөц боломжгүй ажээ.

Бага төсөвтэй ФМ радионууд нь улс даяа, зөрчлөөс нэлээд хол хөндий. Хөтөлгөчид нь голдуу амжилт олж яваа залуу бүсгүйчүүд байна. Эрчүүдийг илүүд үздэг энэ нийгэмд радио бизнест эмэгтэйчүүдэд эрчүүдээс таатай боломж бий гэж тэд үзэж байна. Энэ аймагт сэтгүүлчдийн эрхийн хэд хэдэн зөрчил бүртгэгджээ.

6.17 ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 63,000 км²

Хүн ам: 108,000; аймгийн төв Арвайхээрт 25,000
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 1463,3 төгрөг

Аймгийн төв, хоёроос бусад сум нь Улаанбаатар хотоос төвийн эрчим хүчээр хангагддаг.

6.17.1 Үндэсний ХМХ

Телевиз

Аймгийн төвд Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, орон нутгийн хоёр телевиз, мөн үндэсний бусад телевизүүдийн өргөн нэвтрүүлгийг хүлээн авах дамжуулах станцаар солбиж үзнэ. Аймгийн төвд кабелийн холболт 10-20 хувьтай гэсэн дүн мэдээ байна.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна.

6.17.2 Орон нутгийн ХМХ

Сонин

“Өвөрхангайн Амьдрал” сонин,
Үзэн/эрхлэгч Г.Ж.Дангаа (МОНЦАМЭ-ийн төлөөлөгч)

“Цагаан Алим” ХХК-ны захирал Д.Дангаа 2002 онд үүсгэн байгуулсан. Хувийн сонин нь ЗДТГ-аас ихээхэн дэмжлэг авдаг эдийн засгийн хувьд хараат. Сард хоёр удаа гаргах зорилго тавьсан ч нэг удаа гардаг. Орон нутгийн бусад сонинтой харьцуулахад хэвлэлтийн тоо нь (1000-1500 хувь) өндөр.

Сүүлийн сонгуулийн өмнө МАХН-ын гишүүн, аймгийн Засаг дарга нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө төлбөртэй нийтлүүлж, 20000 хувийг үнэгүй тараажээ. Гурван ажилтан нь сэтгүүл зүйн мэргэжилгүй.

Аймгийн ЗДТГ-ын албан ёсны мэдээлэл, орон нутгийн мэдээ, аймгийн амьдралын талаар нийтлэл, төлбөрт нийтлэл, зар сурталчилгаа, зарлал зэргийг нийтэлдэг. Бага зэргийн шүүмжлэлт материал нийтэлдэг ч, улс төрийн нөлөө хүчтэй байгааг эрхлэгч нь мэдэрдэг гэнэ.

“Өвөрхангайн сонин”
Эрхлэгч Г.Б.Жавзансүрэн

Ардчилсан намын орон нутгаас сонгогдсон, УИХ-ын гишүүдийн дэмжлэгээр байгуулагдсан хувийн сонин. Сард хоёр удаа гаргах зорилго

тавьсан ч, нэг удаа гардаг. 500 хувь хэвлэгддэг. Сонины эрхлэгчийн ярьснаар, Засаг дарга хүмүүст тэдний сонинг захиалахгүй байхыг уриалж, шуудан холбоо нь хэвлэл захиалгын жагсаалтад оруулахаас татгалзаж байсан ажээ. Ардчилсан намаас сонгогдсон УИХ-ын гишүүдийн дэмжлэг, зар сурталчилгааны орлогоор санхүүждэг. “Өвөрхангайн сонин” нь “Конрад Аденауэр”-ын сангаас 500 ам.долларын бичил зээл авсан. Гурван ажилтны хоёр нь бэлтгэгдсэн сэтгүүлч.

Сонин чөлөөт хэвлэл мэдээллийг жинхэнэ утгаар нь бий болгох хэтийн зорилготой. Бусад хүмүүс Ардчилсан намтай холбоотой гэдэг ч, хараат бус сонин гэдгээ эрхлэгч нь онцолж байв. Сонин маргаантай, шүүмжлэлт олон нийтлэл тавьдаг, Ардчилсан намын хүмүүсийг ч шүүмжилж байсан гэж эрхлэгч нь ярих. Саяхан сонин эрхлэгчийг цагдаагийн байгууллага нэр хүндийг нь гутаасан хэмээн шүүхээр заргалдсан ч, одоогоор шийдвэрлэгдээгүй байна. ЗДТГ-ын албан ёсны уулзалтад сэтгүүлчдийг нь урьдаггүй ажээ. ЗДТГ-ын хяналт хавчилт, цагдаагийн ажилтнуудын сүрдүүлгийн тухай “Глоб Интернэшнл” ТББ-д мэдээлээгүй байна. Эрхлэгч нь “Глоб Интернэшнл” ТББ-ын төслийн тухай мэдэхгүй байв.

“Өвөрхангайн мэдээ” сонин

Эрхлэгч í ү П.Оюунжунай

“Эгэл” ХХК 1998 онд байгуулсан. Орон тооны гурван ажилтантай. 1500 хувиар хэвлэгддэг.

“Гурвалжин Мэдээ” сонин

Эрхлэгч í ү Ш.Бямбаа

“Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн” ТББ 2002 онд байгуулсан. Эрхлэгчээс гадна орон тооны дөрвөн ажилтантай. 1000 хувиар хэвлэгддэг

“Бүс Нутгийн Хөгжил” сонин

Эрхлэгч í ү Ж.Жанцандорж

ШУТИС-ийн орон нутаг дахь салбар 2002 онд байгуулсан. Орон тооны нэг, орон тооны бус хоёр ажилтантай. 1000 хувиар хэвлэгддэг

Телевиз

“Арвайхээр чөлөөт суваг” телевиз

Захирал í ү А.Мөнхжаргал

З.Энхболд, З.Хишигбаатар нар 2004 онд үүсгэн байгуулсан хувийн телевиз. Дээр дурдсан сонин адилаар Ардчилсан намаас сонгогдсон УИХ-ын

гишүүдийн дэмжлэгээр байгуулагдсан. Телевизийг нутгийн хэдэн залууст шилжүүлэн өгчээ. Орон тооны таван ажилтны дунд сэтгүүл зүйн мэргэжилтэй хүн алга. Өдөрт таван цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг. Хөтөлбөр нь, 10-20 минутын үйл явдал, бизнес, цаг уурын гэх мэт орон нутгийн мэдээ, дуу хөгжим, уран сайхны кино, ТББ-ын төлбөрт нэвтрүүлэг, шууд нэвтрүүлэг, зар сурталчилгаа зэргээс бүтнэ. Төлбөрт нэвтрүүлэг, зар сурталчилгааны орлогоор санхүүждэг.

“Өвөрхангай” ТВ

Захирал: Т.Нарангарав

Г.Ганболд 2004 онд үүсгэн байгуулсан. Эрхлэгчээс гадна орон орон тооны гурван ажилтантай. Долоо хоногийн зургаан өдөр, 19:00-23:00 цагийн хооронд өргөн нэвтрүүлгээ дамжуулдаг.

ЗДТГ-ын телевиз судалгаанд хамрагдаагүй.

Радио

Ноён уул ФМ 102.6

Захирал С.Мөнхдалай

Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэх зорилгоор ЮНЕСКО-гийн дэмжлэгээр 2001 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ долоо хоногийн гурван өдөр 12 цагаар, нөгөө гурван өдөр нь дөрвөн цагаар дамжуулдаг. Гурван ажилтны хоёр нь бэлтгэгдсэн сэтгүүлчид.

Хөтөлбөр нь, орон нутгийн мэдээ, SARS-ийн тухай боловсролын нэвтрүүлэг, хүнсний аюулгүй байдал, байгаль орчны асуудал, үндэсний, олон улсын улс төрийн асуудал, хүүхдийн нэвтрүүлэг, төлбөрт нэвтрүүлэг, дуу хөгжим зэргээс бүтнэ. Бусад орон нутгийн радиотой харьцуулахад “Ноён-Уул” радиогийн хөтөлбөр нь олон төрөл хэлбэрт нэвтрүүлгээс бүрддэг.

Радиогийн захирлын хэлснээр, хэвлэл мэдээллүүд туйлширсан өнөөгийн нийгэмд илүү төвийг сахиж ажиллахыг зорьдог, нутгийн олон талт мэдээлэл олж авахын төлөө тэмцэж байна. Аймгийн ИТХ хэвлэл мэдээллийнхэнд нээлттэй байх асуудлыг хүлээн авчээ. Гэсэн хэдий ч, судалгаанд оролцож, ярилцлага өгсөн хэд хэдэн хүн энэ радиог албаны мэдээлэл дамжуулахдаа ЗДТГ-аас мөнгө авдаг учраас МАХН-тай холбоотой гэж үздэг гэсэн юм.

6.17.3 Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Өвөрхангай аймаг дахь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь улс төрийн хувьд туйлширсан нь илт байна. Учир нь, МАХН-ын ХМХ давамгайлж буй тухайн аймагт сөрөг ХМХ-д Ардчилсан намаас дэмжлэг үзүүлдэг. Энэ утгаар

авч үзвэл, бусад аймгийг бодвол, хэвлэл мэдээллийн талбар энд арай олон ургальч санагдав.

ЮНЕСКО-гийн дэмжлэгээр 2001 онд байгуулагдахаас өмнө ФМ радио үгүй байсныг тэмдэглэх хэрэгтэй. Сум, малчдад ямар нэг байдлаар хүрдэг цорын ганц хэвлэл мэдээлэл нь орон нутгийн сонин юм.

6.18 БАЯНХОНГОР АЙМАГ

Нутаг дэвсгэр: 116,000 км²
Хүн ам: 84,000; аймгийн төв Баянхонгорт 32,000
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 8437.4 төгрөг

6.18.1 Үндэсний ХМХ

Телевиз

Аймгийн төв нь газрын хүлээн авах, дамжуулах станцаар Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, хоёр сувгаар ТВ5/ТВ9 болон UBS/25-р суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг солбиж үздэг.

Аймгийн төвд КаТВ-ийн сүлжээтэй. Кабелийн холболт, малчдад буй тавган антенийн тухай дүн мэдээ байхгүй.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авдаг.

Бүсийн Олон Нийтийн Радиогийн 30 минутын өргөн нэвтрүүлгийг долоо хоногт хоёр удаа, давталттай, Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн сувгаар Говь-Алтай аймгаас хүлээн авдаг.

6.18.2. Орон нутгийн ХМХ

Сонин

“Баянхонгор таймс” сонин

Эрхлэгч: Л.Хадбаатар

“Эгэл” ХХК үүсгэн байгуулсан. “Эгэл” ХХК нийтлэлийн бодлогод оролцдоггүй, сонинуудад сургалт явуулдаг гэж эрхлэгч ярих.

Орон тооны дөрвөн ажилтантай, 10 хоног тутам 500-800 хувиар хэвлэгддэг. Мэдээ, албан ёсны төлбөргүй мэдээлэл, төлбөртэй голдуу ярилцлага, зар сурталчилгаа, зар мэдээ нийтэлдэг. Орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах эрхэм зорилготой. Шүүмжлэлт зарим нийтлэл бичсэнээсээ болж, дайралтад орж байжээ. Өөрийн цензурын улмаас

солиноо жинхэнэ “хоточ нохой” байлгах тухайд эрхлэгч нь нэг их анхаарч үздэггүй. Дайралтын тухай цагдаагийн газар, “Глоб Интернэшнл” ТББ-ын аль алинд нь мэдээлээгүй байна. Тэд “Глоб Интернэшнл” ТББ-ын тухай мэдэхгүй байлаа.

Ард нь ЗДТГ байгаа шинэ сонин өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн. Энэ аймагт хүүхдийн, мөн зөвхөн зар сурталчилгаа эрхэлдэг сонин байдаг ажээ. Эдгээрийн аль аль нь судалгаанд хамрагдаагүй.

“Баянхонгорын мэдээ” сонин

Эзэн/эрхлэгч: П.Санаадагва

П.Санаадагва 2005 онд үүсгэн байгуулсан. Эрхлэгчээс гадна гурван ажилтантай. 1400 хувиар хэвлэгддэг.

Телевиз

“Баянхонгор” ТВ

Эзэн: С.Баярсайхан, Эрхлэгч: Д.Базартунгалаг

Хувийн телевиз боловч ЗДТГ ажиллуулдаг. Өмчлөгч нь МАХН-ын гишүүн, аймгийн захиргааны ажилтан, телевизийн зөвшөөрөл аймгийн ИТХ-д байдаг.

Өргөн нэвтрүүлгээ ажлын өдрүүдэд, 19:00-23:00 цагийн хооронд дамжуулж, амралтын өдрүүдэд давтдаг. Редактор (сэтгүүлч), хөтлөгч (сэтгүүлч), зураглаач гэсэн гурван ажилтантай. Хөтөлбөр нь, мэдээ, ТББ, ЗДТГ, МАХН-ын төлбөрт нэвтрүүлэг, хүүхэлдэйн, уран сайхны кино, зар сурталчилгаанаас бүтнэ.

Өмчлөгч нэвтрүүлгийн бодлогод нөлөөлдөггүй, редакц эрх чөлөөтэй гэж эрхлэгч нь онцлов. Гэхдээ ил хэлж болохгүй зарим зүйл бий гэж тэр нэмж хэлсэн. Телевиз засаг захиргааг бага сага шүүмжилдэг ажээ.

“Телеком Бизнес Суваг” ТВ

Захирал: Г.Мөнгөнсүх

1999 онд байгуулагдсан. Телевизийн 40 хувийг аймгийн Цахилгаан Холбооны компани, үлдсэн 60 хувийг хувь хүн өмчилдөг. Нэг ажилтантай. Өдөр бүр 2-3 цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг. Орон нутгийн мэдээ, ЗДТГ-ын төлбөртэй албан ёсны мэдээ, төлбөрт ярилцлага, уран сайхны кино, зар сурталчилгаа явуулна.

Шүүмжлэлт нэвтрүүлгүүд бэлтгэдэг. Зарим шүүмжлэлт мэдээ маргаан үүсгэж, дарамтад өртөж байсан ч, шүүхэд дуудагдаагүй гэж эрхлэгч ярих. Эрхлэгч энэ тухай цагдаа, “Глоб Интернэшнл” ТББ-ын алинд ч мэдээлээгүй. “Аймагт мэдээлэл олж авах бодит боломж байхгүй, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төржсөн” гэж тэрээр цохон тэмдэглэсэн юм.

Радио

“Хонгор нутаг” ФМ 107

Эзэн í ү Л.Хадбаатар, эрхлэгч í ү Ж.Алтанцэцэг

Дээр дурдсан МАХН-ын гишүүн, бизнес эрхлэгчийн өмчлөлд байдаг. 2004 оны сонгуулийн өмнө ухуулга сурталчилгааны хэрэгсэл болгон МАХН байгуулжээ. Хожим нь МАХН радио ажиллуулах сонирхолгүй болсон. Шинэ эрхлэгч Ж.Алтанцэцэг МАХН-аас цалинждаг ажээ.

Бусад ФМ радиогийн адил төрөл бүрийн нэвтрүүлэг явуулдаг. Хөтөлбөр нь аймаг, сумдаас авсан мэдээ, ТББ-ын төлбөрт нэвтрүүлэг, янз бүрийн насныханд зориулсан дуу хөгжмийн нэвтрүүлэг зэргээс бүтнэ. МАХН-аас нэвтрүүлгийн бодлогод нөлөөлдөггүй хэмээн эрхлэгч баталж байсан ч, судалгаанд хамрагдсан хэд хэдэн хүн “ирэх сонгуулиар МАХН хяналтаа сэргээнэ” гэж таамаглаж байлаа.

Өөр нэг ФМ радио судалгаанд хамрагдаагүй боловч, ихэвчлэн дуу хөгжим явуулдаг, олон төрлийн нэвтрүүлэггүй гэсэн.

6.18.3. Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Энэ аймагт хүүхдийн, зар сурталчилгааны гээд нийт дөрвөн сонинтой, хоёр ФМ радио, хоёр телевизтэй гээд хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний байдал гүнзгий сэтгэгдэл төрүүлж байв.

Үүнээс үл хамааран бүтээгдэхүүний төрөл, хэлбэр хязгаарлагдмал, ямар нэг байдлаар МАХН, ЗДТГ дийлэнх хэвлэл мэдээллийг хяналтдаа байлгадаг. Хэвлэл мэдээлэл нь хараат бус, шүүмжлэлт мэдээгээр хангаж чаддаггүй.

Сум, малчдад ямар нэг байдлаар хүрдэг цорын ганц хэвлэл мэдээлэл нь орон нутгийн сонин юм.

6.19 ХӨВСГӨЛ АЙМАГ

Нутаг дэвсгэр: 101,000 км²
Хүн ам: 123,500; аймгийн төвд 36,100
Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 2049,3 төгрөг

6.19.1 Үндэсний ХМХ

Телевиз

Аймгийн төвд Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, мөн ТВ5/ТВ9 болон UBS/25-р суваг телевизийн өргөн нэвтрүүлгийг өнжөөд нэг солбиж үзнэ.

Кабелийн телевизийн хоёр сүлжээтэй. Кабелийн холболт 10 орчим хувьтай. Малчин айл өрхийн 40 хувь нь нарны зай хэрэглэдэг, 20 хувь нь тавган антентай гэсэн тоо баримтыг ЗДТГ өгсөн.

Радио

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна.

Мэдээлэл, харилцаа холбоо

Бүх сумдад суурин телефонтой. Аймгийн төвд үүрэн телефоны сүлжээ барьдаг. Аймгийн төв, гурван сум шилэн кабельд холбогдсон.

6.19.2 Орон нутгийн ХМХ

“Далай ээж” сонин, “Хүний эрхийн радио” ФМ-107

Эрхлэгч: Б.Сарантуяа

Энэхүү хувийн сонинг МАХН 1992 онд байгуулсан. 2004 онд түүнийг одоогийн өмчлөгч нь авчээ. Сонин МАХН-тай ямар нэг холбоогүй, МАХН-аас өв хөрөнгийг нь таслан авахад нэлээд цаг зарцуулсан гэнэ. Орон тооны дөрвөн ажилтантай, хэд хэдэн идэвхтэн бичигчтэй. 10 хоног тутам 400-800 хувиар хэвлэгдэнэ. Дийлэнхийг нь сумдад борлуулна. Орон нутгийн, үндэсний, олон улсын мэдээ, ярилцлага, хөрөг нийтлэл, эрүүл мэндийн, хоол хийх зөвлөгөө, шүлэг, зар сурталчилгаа нийтэлдэг. Төлбөрт нийтлэл, зар сурталчилгаа, захиалгын орлогоор санхүүждэг.

Эрхлэгч нь 2005 онд Америкийн нэг иргэний дэмжлэгээр ФМ радио ажиллуулж эхэлсэн. Радио хүний эрхийг хамгаалах эрхэм зорилготой. Хуулийн зөвлөгөө өгөх, хүний эрхийн зөрчлүүдээр нэвтрүүлэг хийж байжээ. Гэвч санхүүгийн хүндрэлийн улмаас нэвтрүүлгээ бусад орон нутгийн ФМ радиотай адил болгосон. Хөтөлбөр нь, дуу хөгжим, уран зохиол, шашны нэвтрүүлэг, болон утсаар зарлал авах зэргээс бүтнэ. Орон тооны гурван ажилтантай.

Сонин

“Эрх чөлөө” сонин,

Эзэн: Д.Лхагвахүрэн, Эрхлэгч: Ю.Гэрэлтуяа

Анх 1942 онд байгуулагдахдаа намын сонин байв. 1999 онд бизнес эрхлэгч хувьчлан авчээ. “Өмчлөгчийн зүгээс нийтлэлийн бодлогод нөлөөлдөггүй” гэж сонин эрхлэгч хэлж байв. Хэвлэгдсэн таван сонин тутмын нэгийг Мөрөн хотод, үлдсэн хувийг аймгийн төвөөс бусад газраар

борлуулдаг. Аймгийн ИТХ-ын гишүүдийн дэмжлэгээр сумдад захиалгаа өсгөдөг. Улс төрчдөөс ийнхүү хараат байх нь эргээд тэднийг шүүмжлэхэд хүндрэл учруулдаг тухай тэр дурдсан. Орон тооны дөрвөн ажилтантай, бүгд сэтгүүл зүйн мэргэжилтэй,

Сонин нь 10 хоног тутам гардаг. Шилжилтийн үед 5000 хувь хэвлэгдэж байснаа, одоо 500-1000 хувь болж буурсан. Эрэн сурвалжилсан сурвалжлага, улс төрийн мэдээ, орон нутгийн хэрэг явдал, боловсрол, үзэл бодол, уран зохиол, орон нутгийн идэвхтнүүдээс ирүүлсэн мэдээллийг нийтэлдэг.

Сонин хэд хэдэн удаа шүүхэд дуудагдаж, эрхлэгч нь цөөнгүй удаа дарамт шахалтад өртөж байжээ. Зарим тохиолдолд энэ тухай цагдаад мэдээлдэг ч арга хэмжээ аваагүй гэжээ.

Телевиз ба Радио

“Шинэ амьдрал” ФМ-105.5, “Хөх тэнгэр” ФМ-107.5 ба “Далай ван” ТВ

Эзэн: Д.Цэрэнжав, эрхлэгч: Д.Лхагвасүрэн, ФМ-107.5 радио
ФМ-105.5, “Далай ван” ТВ-ийн эрхлэгч: Д.Гангаа

Радио 2003 онд байгуулагдсан. Хөтөлбөр нь, орон нутгийн мэдээ, боловсрол, эрүүл мэнд, залуучуудын нэвтрүүлэг, дуу хөгжим, зар сурталчилгаанаас бүтнэ. Шууд утас, зар сурталчилгаар санхүүждэг. Радио станцууд эзнийхээ бизнесийн бусад үйл ажиллагааг сурталчилдаггүй.

“Далай ван” ТВ нь ТВ5, ТВ9 телевизийн нэвтрүүлгийг, ээлжлэн солбиж дахин дамжуулдаг. Удаагүй өөрийн хөтөлбөр бүхий орон нутгийн телевиз болж ажиллана.

LW радио, ФМ радио, “Мөрөн” ТВ

Захирал: М.Нямаа

Хоёр ФМ радио, телевиз нь захиралтай нийлээд зургаан ажилтантай. Эдгээр нь аймгийн захиргаатай хийсэн гэрээ, зар сурталчилгаа, төлбөрт нэвтрүүлгээс санхүүждэг.

“LW” радио нь 1988 онд байгуулагдсан. 30 минутын өргөн нэвтрүүлгийг долоо хоногт гурван удаа дамжуулдаг. Хөтөлбөр нь, албан ёсны, орон нутгийн мэдээ зэргээс бүтнэ.

ФМ радио Соросын сангийн санхүүжилтээр 2001 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөрт, 09:00-11:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөрөө залуучууд, жолооч нарт түлхүү чиглүүлдэг. Хөтөлбөр нь, цаг тутмын таван минутын мэдээ, замын хөдөлгөөний мэдээлэл, шууд ярилцлага, дууны тэмцээн, дуу хөгжим, зар сурталчилгаа зэргээс бүтнэ.

“Мөрөн” ТВ 2001 онд байгуулагдсан. Долоо хоногт 90-180 минутын өргөн нэвтрүүлэг дамжуулж, дараагийн өдөр нь давтдаг. Хөтөлбөр нь, 30 минутын мэдээ, шууд ярилцлага, төлбөрт нэвтрүүлэг зэргээс бүтнэ.

“Ди-Э-С” ТВ, “Шинэ мянганы радио” ФМ-104.5

Эзэн/захирал Ц.Мягмарбаяр

Телевиз нь 2002 онд байгуулагдсан. Радио нь мөн 2002 онд байгуулагджээ. 2004 он хүртэл хэрэгжсэн Киприйн төслийн хүрээнд санхүүгийн дэмжлэг авсан. Эхэндээ 10 ажилтантай байсан ч, санхүүгийн хүндрэлийн улмаас зургаа болгон цөөлжээ. Одоо телевиз дөрөв, радио хоёр ажилтантай.

Өдрийн 15 цагийн хөтөлбөр нь, мэдээ, хүүхдийн нэвтрүүлэг, байгаль, мэндчилгээ, бизнесийн хөтөлбөр, орон нутгийн асуудлаар нээлттэй микрофон, зар сурталчилгаа зэргээс бүтнэ. Үзэгчдийн сайн дурын хураамж, зар сурталчилгаа, шууд утас, төлбөрт нэвтрүүлгийн орлогоос бүрддэг. ФМ радио шууд утас, зар сурталчилгаагаар санхүүждэг. Радио, телевиз хоёр харилцан бие биенээ дэмжсэн үйл ажиллагаа явуулдаггүй. Гэхдээ зар сурталчилгааны шинэ хэлбэр, уралдаант, шагнал олгох нэвтрүүлэг бэлтгэх зэрэг шинэлэг аргаар ажиллаж байна.

Радио үнэнч сонсогчидтой, тэдний мэдээг олон нийт шударга, хараат бус гэж хүлээн авдаг хэмээн эрхлэгч нь баталж байв. Тэрээр 1990-ээд оны дундуур, МХХ-ийн сургалтад хамрагдсан. 1998 онд Хөвсгөлд эргэж ирсний дараа улс төрчдийн дарамт шахалтад өртөж байсан ч, одоо хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байдал сайжирч байна гэв. Харин санхүүгийн хүндрэлд үе бэлтгэгдсэн сэтгүүлчид дутагдалтай хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний чанарт нөлөөлдөг гэсэн юм.

“Цаа буга” ФМ 104.1

М.Батдаваа, эрхлэгч

ЮНЕСКО-ийн санхүүжилтээр 2006 онд 9 аймгаар сард Рэнчинлхүмбэ сумд байгуулагдсан. Эрхлэгчээс гадна хоёр ажилтантай. Ажилтнууд нь МҮОНРТ, МХХ-ийн сургалтад хамрагдсан. Өргөн нэвтрүүлгээ долоо хоногийн зургаан өдөр, 10:00-13:00, 15:00-18:00 цагийн хооронд 30-70 км-ын радиусаар дамжуулдаг. Хөтөлбөр нь, мэдээ, дуу хөгжим, боловсрол, хүүхэд, хууль эрх зүйн зэрэг нэвтрүүлгээс бүтнэ.

“Лха” КаТВ

Эзэн: Ч.Лхагвадорж, эрхлэгч: О.Лхагвамаа

Ч.Лхагвадорж 2005 онд байгуулсан, Дархан хотод ажилладаг “Лха” телевизийн салбар.

“Скай” КаТВ

“Номин” ТВ, ФМ 104.5 радио

Захирал: Х.Хишигбаатар, телевизийн ерөнхий редактор: С.Баасанжав
ФМ-ийн ерөнхий редактор: Н.Пүрэвдагва

Х.Хишигбаатар “Номин” телевизийг 2004 онд, ФМ радио, сонинг 2005 онд үүсгэн байгуулжээ. Эдгээр нь Ардчилсан намын хөрөнгөөр байгуулагдсан ч, одоо гурвуулаа Х.Хишигбаатар, С.Баасанжав нарын өмч болсон. “Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь Ардчилсан намын талд байдаг гэж олон нийтэд санагддаг ч, энэ бол шударга бус дүгнэлт, редакц хараат бусаар ажилладаг” гэж оуя батлав. Эдгээр ХМХ нь 12 ажилтантай. Голдуу 30-аас доош насны залуучууд, хамгийн ахмад нь 37 настай ажээ. Нэлээд хэдэн ажилтан нь сэтгүүл зүйн мэргэжилтэй, хоёр нь МХХ-ийн сургалтад хамрагджээ.

“Номин” телевиз нь 07:30-24:00 цагийн хооронд өргөн нэвтрүүлгээ дамжуулдаг. Долоо хоногт 20-25 минутаар дөрвөн удаа орон нутгийн мэдээ явуулдаг. Хөтөлбөр нь, мэдээ, цэнгээнт, нийгэм, улс төрийн нэвтрүүлэг, уран сайхны кино, зар сурталчилгаанаас бүтнэ. Өмнө нь боловсролын нэвтрүүлэгтэй байсан.

Шүүмжлэлт нэвтрүүлэг, орон нутагт бэлтгэсэн цэнгээнт нэвтрүүлгээрээ телевиз олон нийтийн дунд нэр хүндтэй болсон гэж захирал нь үздэг ажээ. Телевизийн 500 үзэгчийн дунд хийсэн жижиг судалгаанаас үзэхэд оролцогчдын 388 нь “Номин” телевизийг Эрдэнэт хотын хамгийн сайн телевиз гэжээ. Нэр хүнд, олон нийтийн дэмжлэг телевизийг янз бүрийн дарамт шахалтаас хамгаалж байдаг ч, татварын хатуу хяналтанд байдаг гэж цохон дурьдсан. Орлогын дийлэнх хэсгийг нь зар сурталчилгаа эзэлдэг. Мөн төлбөрт шууд нэвтрүүлэг, нэвтрүүлгээ худалдсан орлогоор санхүүжинэ.

ФМ радиогийн хөтөлбөр нь, гол төлөв дуу хөгжим, мэдээ, зар сурталчилгаа, зарлал зэргээс бүтнэ. Зар сурталчилгаа, утасны орлогоороо санхүүждэг. Утсаар холбогдож буй сонсогчдын 80 хувийг залуучууд эзэлдэг. Тэдний олонх нь жолооч нар ажээ.

Хэвлэл мэдээллийн гурван хэрэгсэл бие биенийхээ бүтээгдэхүүнийг дэмжиж, идэвхжүүлдэг тул удирдлага нь ирээдүйдээ итгэдэг.

Телевиз

“Нийтийн Мэдээллийн Төв” телевиз

Телевизийн захирал, Мэдээллийн Төвийн дарга í ü Б.Мөнгөнтуяа

1994 онд төрийн өмчийн телевиз хэлбэрээр байгуулагдсан. Хэдэн жилийн өмнө 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу олон нийтийн болгож өөрчилжээ. Орон нутгийн төсвөөс санхүүждэг.

Радио, сонинтой байх үедээ 40 ажилтантай байсан бол, одоо нийт есөн ажилтантай.

Өргөн нэвтрүүлгээ 09:00-24:00 цагийн хооронд дамжуулдаг. Энэ цагийнхаа 19:00-22:00 цагийн хооронд үндсэн нэвтрүүлгээ дамжуулдаг. Хөтөлбөр нь, ярилцлага, сурвалжлага, албаны мэдээ, шууд нэвтрүүлэг зэргээс бүтнэ.

Аймгийн Засаг даргаас хараат бус байдаг хэмээн телевизийн захирал нь онцолж хэлэв. Олон нийтийн энэ телевизээс үзэгчдийн 90 хувь нь мэдээллээ олж авдаг гэсэн судалгааг Мэдээллийн төвөөс хийжээ.

Телевиз, Радио, КаТВ

“Лха” ТВ, “Лха” ТВ, “ФМ-105.1” радио

Захирал: Н.Нацагдорж

Хувийн анхны телевиз 2001 онд байгуулагдсан. Өргөн нэвтрүүлгээ 07:00-14:00 цагийн хооронд дамжуулдаг. Хөтөлбөр нь, мэдээ, цэнгээнт нэвтрүүлэг, дуу хөгжим, уран сайхны кино, зар сурталчилгаа зэргээс бүтнэ. Телевиз нь аймгийн наадмыг шууд сурвалжилж байжээ. Компани нь Эрдэнэт хотод 30, Булган хотод 10 ажилтантай. Компаний бизнесийн үндсэн хэсэг нь 3000 хэрэглэгчтэй, 50 суваг бүхий кабелийн телевизийн сүлжээ юм.

Компани мөн ФМ радио ажиллуулдаг. Булган аймагт телевизтэй.

Радио

“ФМ-102.4” радио

Захирал: С.Чинбат

Анхны хувийн радио 2004 онд байгуулагдсан. Техникийн хүндрэлээс болж 2005 онд хэсэг хугацаагаар хаагдсан. Өргөн нэвтрүүлгээ өдөр бүр дамжуулдаг. Хөтөлбөр нь, орон нутгийн, үндэсний, олон улсын мэдээ (зарим мэдээг интернэтээс авдаг), боловсрол, мэдээллийн нэвтрүүлэг, олон нийтийн тулгамдсан асуудал, соёл урлаг, дуу хөгжим, зар сурталчилгаа, зарлал зэргээс бүтнэ. Таван ажилтны хоёр нь сэтгүүл зүйн мэргэжилтэй.

Утасны орлого, зар сурталчилгаа, төлбөрт нэвтрүүлгээс санхүүждэг. Радио утасны орлого ихээхэн дэмжлэг болдог. Радио олон нийтийн шүүмжлэлт дуу хоолой болдог хэмээн захирал онцолсон. Аймгийн эрх бүхий албан тушаалтнууд цөөнгүй удаа маргаан үүсгэж байсан төдийгүй, хэд хэдэн удаа цонхыг нь хагалах зэргээр амгалан тайван байдлыг нь алдагдуулсан тохиолдол гарч байжээ.

“Эрдэнэт” үйлдвэр мөн ФМ радио ажиллуулдаг байна. Ажилтнууддаа зориулан өглөөгүүр орон нутгийн мэдээ, өдрийн бусад цагт нь ердийн нэвтрүүлэг явуулдаг байна. Радио судалгаанд хамрагдаагүй

Сонин

“Шинэ мэдээ” сонин

Эрхлэгч: Ж.Оюун

Уг сонинг одоогийн өмчлөгч С.Шаравдорж 1998 онд байгуулжээ. “Эгэл” ХХК нь орон нутгийн хэд хэдэн сонинг өмчилдөг. Эрдэнэт хотод гардаг энэ сонин долоо хоногт нэг удаа 1800 хувиар хэвлэгддэг. 14 ажилтны найм нь сэтгүүл зүйн мэргэжилтэй. Долоо хоногт хоёр удаа гаргахаар төлөвлөж байгаа. Нийгэм, эдийн засаг, улс төрийн нийтлэл, албаны төлбөрт мэдээ, төлбөрт нийтлэл, зар сурталчилгаа зэргийг нийтэлдэг.

Зар сурталчилгаа, төлбөрт нийтлэл, захиалгын орлогоор санхүүждэг. “Шинэ мэдээ” сонин “Эгэл” ХХК-ны санхүүгийн дэмжлэгээр байгуулагдсан сонины нэг нь, ашигтай ажиллаж байгаа ажээ.

6.20.3. Ерөнхий дүгнэлт/Тайлбар

Орхон аймаг, Эрдэнэт хотын хэвлэл мэдээллийн хэрэгслийн байдал бусад аймагтай харьцуулахад олон талаараа ялгаатай. Хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний төрөл хэлбэр янз бүр.

Энэ аймагт Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн 60 гишүүнтэй салбар ажилладаг. Зар сурталчилгааны зах зээл харьцангуй сайн хөгжсөн. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хоорондоо уялдаа холбоотой ажиллах боломжтой. Судалгаанд хамрагдсан зарим хүний ярьснаар, дахиад хоёр ч телевиз байгуулж буй ажээ.

6.21. БУЛГАН АЙМАГ

Нутаг дэвсгэр: 49,200 км²

Хүн ам: 58,000; аймгийн төв Булганд 12,000

Эдийн засаг: Төсвийн орлого: (саяар) 2500.0 төгрөг

6.21.1 Үндэсний ХМХ

Сонин

Хамгийн олон захиалагчтай сонин

Өдөр тутмын сонин

“Зууны мэдээ”

“Өдрийн сонин”

Өдөр тутмын бус сонин

“Хүмүүс”

“Зиндаа”

“Хань”

“Сэрүүлэг”

Сэлэнгэ, Бугат сумын захиалагчид сониноо Эрдэнэт хотоор хүлээж авдаг.

Телевиз

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн өргөн нэвтрүүлгийг аймгийн хэмжээнд хүлээн авна. 25-р суваг, ТВ5, ТВ9 телевизийн өргөн нэвтрүүлгийг “Хийморь” кабелийн телевизээр дамжуулан үздэг.

6.21.2 Орон нутгийн ХМХ

Сонин

“Булганы мэдээ” сонин

Эрхлэгч Г.Норжмаа

“Эгэл” ХХК-ны захирал С.Шаравдорж 2004 оны 9 сард байгуулсан. Орон тооны гурав, орон тооны бус хоёр ажилтантай. 10 хоног тутам 840 хувиар хэвлэгддэг.

Телевиз, КаТВ

“Лха” телевиз

“Лха” телевиз Дархан хотод ажилладаг хувийн телевизийн Булган аймаг дахь салбар юм. 2002 онд байгуулагдсан, 19:00-20:00 цагийн хооронд нэг цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг.

“Хийморь” КаТВ

Кабелийн телевизийг Монголын Цахилгаан Компаний салбар өмчилдөг. Монголын таван сувагтай нийлээд 14 сувагтай, 300 гаруй хэрэглэгчтэй.

Радио

“Элгэн нутаг” ФМ

᠑ахирал í ү Д.Наранбаяр

2003 онд аймгийн ЗДТГ-ын дарга Д.Наранбаяр байгуулсан. МАХН-ын өмч. 14 цагийн өргөн нэвтрүүлэг дамжуулдаг. Орон тооны гурав, орон тооны бус гурван ажилтантай. Хөтөлбөр нь, дуу хөгжим, зарлал, цэнгээнт нэвтрүүлэг, багахан хэмжээний мэдээ зэргээс бүтнэ.

Мөн урд талын долоон суманд өөрийн жижиг салбартай.

7. Уулзсан хүмүүсийн нэрсийн жагсаалт

Улаанбаатар хот

Д.Цэрэнжав, чөлөөт сэтгүүлч
Батбаатар, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, орлогч ерөнхийлөгч
Оюунгэрэл, Монголын Хэвлэн Нийтлэгчдийн Холбоо, гүйцэтгэх захирал
Ариунбат, Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, захирал
М.Мөнхсоёл, Нээлттэй Нийгэм Форум, Хэвлэл мэдээллийн хөтөлбөрийн менежер
Идэрцогт, Монгол шуудан компани, захирал
Ц.Ариунаа, FM 107.5 радио, захирал
Б.Галсандорж, “Чөлөөт Хэвлэл” Сан, захирал
Робин Гарнер, Монголын Сонин ба Мэдээллийн Холбоо, менежер
М.Мөнхмандах, Монголын Хэвлэлийн Хүрээлэн, гүйцэтгэх захирал
Г.Жамъяан, “Үнэн” сонин, сэтгүүлч
Уянга, “Улс төрийн сонин”, сэтгүүлч
Батзандан, Эрүүл Нийгэм-Иргэний Хөдөлгөөн, зохицуулагч
Ганхуяг, Пакт Монгол, /хуучин “Говийн Санаачлага” хөтөлбөр/ менежер
Ш.Сүхбаатар, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам, дэд сайд
С.Шаравдорж, Орон Нутгийн Сонинуудын Холбоо, ерөнхийлөгч
А.Энхбат, Сансар КаТВ, захирал
Д.Мөнхбүрэн, “Глоб Интернэшнл” ТББ, гүйцэтгэх захирал
Мягмар, Монголын Зар Сурталчилгаа Эрхлэгчдийн Нийгэмлэг, тэргүүн
Зулькафиль, Монгол Улсын Их Сургууль, Сэтгүүл зүйн тэнхим, эрхлэгч
Алтантуяа, Ховд аймаг, Мэдээллийн хэлтсийн дарга
Санги, захирал
Баатарсүрэн, Мэдээлэл Харилцаа Холбооны газрын ажилтан
Ц.Энхбат, МХХ-ийн удирдах зөвлөлийн дарга, ТВ9-ийн захирал
Жаргалмаа, Ийгль ТВ, сэтгүүлч
Бэтина Фэрдэрэр-Инфанте, АНУ-ын Азийн сан
Том Тэрри, Ийгль ТВ, захирал
Г.Баттулга, С1 Телевизийн дарга
С.Ганбаатар, Иргэний хөдөлгөөний зохицуулагч
Батмөнх, Өдрийн сонин, сэтгүүлч
Э.Бат-Үүл, Монгол УИХ-ын гишүүн
Х.Наранжаргал, “Глоб Интернэшнл” ТББ, тэргүүн
Болд, Мэдээлэл Харилцаа Холбооны Газрын дарга

Говь-Алтай аймаг

Самбуудаш, Аймгийн ЗДТГ-ын дарга, хэвлэл мэдээлэл хариуцна
Д.Сэрээтэр, “Цахиур төмөр” сонин, эрхлэгч
Ж.Эрдэнэчимэг, FM-104.5 радио, захирал
Г.Чардаг, Мэдээллийн Төвийн дарга, ”Алтай” радио, “Говь-Алтай”
телевизийн захирал

Өй аа аймаг

А.Бямбасүрэн, “Ховдын мэдээ” сонин, эрхлэгч

Х.Алтантуяа, “Ховд” ТВ

Б.Базар, “Алтан нутаг” сонин

Г.Улам-Оргил, “Ховд” хэвлэлийн компани, захирал

Баян-Өлгий аймаг

Б.Зархум, Аймгийн ЗДТГ-ын дарга

Р.Сураган, Мэдээлэл Технологийн Газар, дарг

Б.Кану, Эрбахад, “Жана Дауэр” сонины редакц, орон нутгийн телевиз

Жасхайрат, Нурмахан, Шынай “Сугалаа” сэтгүүл

Увс аймаг

С.Хунчин, “Сама” ТВ, “Улаан-Уул” FM-101 радио, эрхлэгч

Батнасан, Баттөмөр, Орон нутгийн хэвлэлийн ажилтан

Мөнхчулуун, “Шинэ Зууны” FM-100.6 радио, захирал

Завхан аймаг

Д.Нацагмаа, Мэдээллийн Төвийн дарга, “Завхан” ТВ-ийн захирал

Б.Идэр, аймгийн ЗДТГ-ын орлогч дарга

Д.Эрдэнэсайхан, FM-103.5 радио, захирал

Д.Дашбалжир, FM-106.5 радио

Хөвсгөл аймаг

Алтангэрэл, Аймгийн ЗДТГ

М.Нямаа, Радио, Телевизийн Төвийн дарга

Ц.Мягмарбаяр, “Далай ээж” ТВ, захирал

О.Лхагвамаа, “Лха” ТВ-ийн захирал

Б.Сарантуяа, “Далай ээж” сонин, эрхлэгч

Ю.Гэрэлтуяа, “Эрх чөлөө” сонин, эрхлэгч

М.Пүрэвсүрэн, “Мөнгөн үсэг” хэвлэлийн компани, захирал

Ганзориг, “Хөвсгөл Хонгор” хэвлэлийн компани, захирал

Архангай аймаг

Чадраабал, Аймгийн ЗДТГ-ын дарга

О.Амарзаяа, Мэдээллийн Төвийн дарга, “Архангай амьдрал” сонин,

“Тамир” ТВ, “

FM-107.5” радио

Баянхонгор аймаг

Д.Энэбиш, “Болор үсэг” хэвлэх үйлдвэр, захирал
П.Санаадагва, “Баянхонгорын мэдээ” сонин, эрхлэгч
Л.Хадбаатар, “Баянхонгор таймс” сонин, эрхлэгч
Г.Болортунгалаг, “Баянхонгор” ТВ
Г.Даваасамбуу, “Наран” хэвлэх үйлдвэр, захирал

Өвөрхангай аймаг

С.Мөндалай, “Ноён-Уул” FM радио, захирал
Т.Нарангарав, “Өвөрхангай” телевиз, захирал
Ж.Дангаа, “Өвөрхангайн амьдрал” сонин

Орхон аймаг

Сувдаа, Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Орхон аймгийн салбарын эрхлэгч
Б.Мөнгөнтуяа, Мэдээллийн төвийн дарга
С.Баасанжав, “Номин” ТВ, ерөнхий редактор
Н.Нацагдорж, “Лха” ТВ, захирал
Ж.Оюун, “Шинэ мэдээ” сонин, эрхлэгч
Батчулуун, FM-100.4 радио, захирал
С.Чинбат, FM-102.4 радио, захирал

Дорнод аймаг

Хүрэлбаатар, аймгийн ЗДТГ-ын дарга
С.Бадарч, Бүсийн олон нийтийн радиогийн захирал
Б.Туяа, “Дорнод” сонин, эрхлэгч
С.Дэлгэр, “Шинэ суваг” ТВ, захирал
Баярмагнай, “Хэрлэн суваг” ТВ, захирал

Сүхбаатар аймаг

С.Амартайван, “Шинэ Сүхбаатар” сонин, эрхлэгч
Г.Сүхээ, Аймгийн Мэдээллийн Төвийн дарга
С.Батсайхан, “Талын долгион” ТВ, захирал
Д.Мөнхбат, “Талын цуурай” FM радио, захирал

Хэнтий аймаг

И.Байгальмаа, “Хэнтийн сонин” сонин, эрхлэгч
Б.Адъяахүү, “Дөлгөөн хэрлэн” радио, захирал
О.Насантогтох, FM101 радио, захирал
Ариунбаатар, “Урагшаа” сонин, эрхлэгч
Б.Пүрэвбанзрагч, “Санбүрд” ТВ
Батцэцэг, Аймгийн Мэдээллийн төв, мэдээллийн ажилтан

Говь-Сүмбэр аймаг

Д.Уранцэнгэл, “Боржигон нутаг” радио, “Жанжин Чойр”, “Чойр” ТВ, захирал

Г.Баасансүрэн, “Чойр 54” сонин, эрхлэгч
Батжаргал, “Говь-Сүмбэрийн мэдээ” сонин, эрхлэгч

Дорноговь аймаг

Ч.Дүүрэн, Аймгийн Мэдээллийн Төвийн дарга
Мөнхтуяа, “Дорноговь” ТВ, радио
Ганзориг, “FM 105.5” радио
Б.Зоригтбаатар, “FM 101.5” радио

Өмнөговь аймаг

Д.Наранчимэг, Аймгийн Мэдээллийн Төвийн дарга
Бат-Өлзий, “Монгол говь” сонин, эрхлэгч
С.Номинцэцэг, “Алтан нутгийн мэдээ” сонин
Баянмөнх, “Говь” ТВ

Дундговь аймаг

С.Пүрэвсүрэн, Аймгийн Мэдээллийн Төвийн дарга, “Хадаг” сонин,
эрхлэгч
Т.Отгонтуяа, “Говийн амьдрал” сонин
Д.Баярмаа, “Говийн тэнгэр” FM-101.9, захирал
С.Оюунчимэг, “Мандалговь” FM-107.5, захирал
М.Нарангэрэл, “Дундговь” ТВ
Ч.Түмэннаст, “Өглөө” хүүхдийн сонин, эрхлэгч

Төв аймаг

Ж.Энхбаатар, “Төв таймс” сонин, эрхлэгч
Мөнхдорж, “Мишээл” FM-99.3
Мөнхтүвшин, “Зуун мод” ТВ, захирал

Дархан-Уул аймаг

Ө.Рагчаасүрэн, МХХ-ийн бүсийн зохицуулагч
О.Хишигсүрэн, “Орхон” FM-106, захирал
Ч.Лхагвадорж, “Лха” ТВ, захирал
А.Түвшинбат, “ДБС” ТВ, захирал
Б.Ганбаяр, FM-107.5 радио, захирал
А.Батзаяа, “Найрамдлын Дархан” сонин, эрхлэгч, FM-104.5, захирал

Сэлэнгэ аймаг

Ж.Оюунмаа, “Сэлэнгийн мэдээ” сонин, эрхлэгч
Л.Бямбаа, “Шинэ гэгээ” сонин, эрхлэгч
Д.Балдан, “Сэлэнгэ” ТВ, захирал
Р.Бумдарь, FM 104 радио, захирал
Д.Ганболд, “Миний Монгол” FM радио, захирал

8. Товчилсон үгсийн жагсаалт

ÖĪÖ	Öýäéýë İý äýüëëëéí Öýöýñýë
İÖÖ	İí ĩ ēūí Öýäéýëëéí Öĵöýýéí
ÓÈÖ	Óēñúí Èö Öóðäë
ÈÖÖ	Èðäýäëéí Ö°ë°ë° ä-äëéí Öóðäë
ÇÄÖÄ	ÇañääÄàðäüí Çàìä üí Äàçàð
İÖÖÖ	İý äýüéýë Öàðëëöàà Öíëáíííü Çàðííēí æ
ÍÍÐÖ	Íēíííëéðëéí Ðàäēí Çäëääèç
ÍÍªÍ	Íēíííëéðëéíª ðäíííýàððĵĵëýä
Ī ÐÖĪ ĩ ĩ ēūí Ī äýñí ēé Ðàäēí Çäëääèç	
Ī Ī Ī ÐÖ	İí ĩ ĩ ēūí Ī äýñí ēé Ī ēííííëéðëéí Ðàäēí Çäëääèç
ØÖÖÈÑ	Øēí æýð Öóàáí Çàðííēí æéí ÈðÑóðäóöü
İÒÒ	İý äýüéýë Çàðííēí æéí Öª
ÐªÍÄÄÑ	Ðàäēíª ðäíííýàððĵĵëýäÄàðēí ÄàìæóóëäðÑòáíö
ÖĪÖÖÄ	Öēñúí İý äýüéýë, Öàðëëöàà Öíëáííí, Çàðííēí æéí Äàçàð
ÐÖÑ	Ðàäēí Çäëääèèçëéí Ñĵæýý
ÖÁÁ	Ö°ðëéí Áóñ Áäéäóëëäää
×ÖÑ	×°ë°ö Öýäéýë Ñàí

Äí òĵ ĵð

ᠮᠠᠨᠢᠨᠢ -æéí Äýüæéí äýð ñäëääðüí Öàðëëöàà ðíëáíí, İý äýüëëëéí ö°ö°ëá°ðëéí çàðëäëääàð İí ĩ ē äàðü öýälэл мэдээллийн салбарын төлөв байдалд задлан шинжилгээ ðëëä.

Судалгаа нь Монголын хэвлэл мэдээллийн байдалд бүрэн дүүрэн үнэлгээ өгөх ерөнхий зорилготой байсан юм.

Судалгаа хийхдээ дараах чиглэлд анхаарлаа хандуулсан болно.

Үүнд:

- Хэвлэл мэдээллийн хөгжилд үзүүлж буй эрх зүй, улс төр, эдийн засгийн үр нөлөөг үнэлж дүгнэх,
- Сонин хэвлэл, телевиз, радио, тоон технологийн хэвлэл мэдээлэлд шинэчилсэн статистик судалгаа хийх,
- ХМХ-ийн бүтээгдэхүүн, түгээлт, агуулга, эзэмшил, санхүүжилтийн механизм, хөрөнгө оруулалтын бодлогод зонхилж буй хандлагыг тодорхойлох,
- Хот, хөдөөд буй хэвлэл мэдээллийн нөхцөлд анхаарал татаж буй давуу ба сул талд задлан шинжилгээ хийх,
- Ер нь хэвлэл мэдээллийг хүрээмж, ялангуяа, үндэсний цөөнхийн мэдээлэл хүртэх байдалд үнэлэлт дүгнэлт өгөх,

Тайланд дараах зүйлийг тусгав. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн салбарыг цаашид хөгжүүлэх уялдаа холбоо бүхий стратеги тодорхойлох,
- Аймаг, мөн үндэсний хэмжээнд хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд саад тотгор болж буй тулгамдсан асуудал, бартаа, үндсэн бэрхшээлийг тодорхойлох,
- Хэвлэл мэдээллийг дэмжих ерөнхий стратеги, зорилго, холбогдох зорилтот бүлэг, үйл ажиллагааны үндсэн чиглэлд санал зөвлөмж өгөх

Хэвлэл мэдээллийн салбар дахь задлан шинжилгээг 2006 оны 9-р сард нэг сарын хугацаагаар Монгол Улсад хийв.

Судалгааны баг нь бүхий л бичиг баримтыг цуглуулан, задлан шинжилж, Улаанбаатар хотын гол гол үздэг ХМХ, мөн бүх аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэн, эрхлэгч, сэтгүүлчидтэй бүлэглэсэн ярилцлага хийж байв.

Бас Монголын зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага, хэвлэл мэдээллийн мэргэжлийн холбоо, ТББ, иргэний нийгмийн бүлгүүдтэй ярилцсан юм. Мөн хэвлэл мэдээллийн хэрэглээ, мэдээлэл харилцаа холбооны хэрэгцээ шаардлагын тухай иргэдтэй санамсаргүй ярилцлага хийсэн билээ.